Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Монгол Улс дахь “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”

Үйл ажиллагааны эцсийн тайлан

2019 оны 7 дугаар сар

Японы олон улсын хамтын ажиллагааны
Байгууллага (JICA)

Koei Research & Consulting Inc.

HM
JR
19-030

ЖАЙКА-ийн албан ёсны валютын ханш (2019 оны 06 дугаар сар)	USD/ JPY 109.386000
	MNT/ JPY 0.041850

Гэрэл зургууд

Нийслэл дэх “Туршлага солилцох семинар” (2019.05)

Төслийн хүрээнд боловсруулсан эцсийн бүтээгдэхүүнүүд (2019.05)



1 дэх удаагийн Япон дахь сургалт (2015.12)

4 дэх удаагийн Япон дахь сургалт (2018.09)

18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн сургагч багш бэлтгэх сургалт (2018.10)

Баянгол дүүргийн “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр” (2017.04)

“Портеж боловсролын хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх” 2 дахь удаагийн сургалт (2018.08)

Хөвсгөл аймгийн “Кэйс хэлэлцүүлэг” (2018.05)

Баянгол дүүрргийн цэцэрлэгийн багш нарыг бэлтгэх сургалт (2018.03)

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах дадлага ажил (2017.04)

Туршилтын ердийн сургууль дахь судалгаат хичээл (2019.03)



Тусгай сургуулийн хэлэлцүүлэг сургалт (2019.03)

Тусгай сургуулиас ердийн сургуульд зөвлөн туслах үйл ажиллагаа (2016.11)

Хөвсгөл аймаг дахь Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал (2019.05)

130-р сургуульд Монголын дауны холбоо ТББ-ын нээсэн туршилтын ангийн сургалтын үйл ажиллагаа (2017.03)

Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвийн сургалтын үйл ажиллагаа (2017.03)

Хүүхдийн хөгжил, мэдээллийн Учрал төв ТББ-ын хүүхэд асрах үйлчилгээний тухай сургалт (2017.03)

МУБИС-ийн харьяа 249-р цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ганцаарчлан сургаж буй байдал (2018.01)

Ховд аймгийн 7-р сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагаа (2018.01)

Сонсголгүйн боловсрол ТББ-ын боловсруулсан дохионы хэлний зурган карт (2018.10)

Төслийн үйл ажиллагааны талаар бэлтгэсэн Ийгл телевизийн сурвалжлага (2019.05)

Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулсан сонины нийтлэл (2017.12)

Хуанли хэвлүүлэв (2018.11)

Дэлхийн хичээлийн судалгааны нийгэмлэгийн онол практикийн бага хуралд ханын илтгэлээр оролцов (2017.11)

Төсөл хэрэгжсэн байршлын зураг



Товчилсон үг, нэр томъёоны тайлбар

CUDBAS	A Method of Curriculum Development Based on Vocational Ability Structure	Мэргэжлийн чадварт суурилсан хөтөлбөр боловсруулах арга
DET	Disability Equality Training	“Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал” сургалт
ICF	International Classification of Functioning, Disability and Health	Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал
ХЗЗ	Joint Coordination Committee	Хамтарсан зохицуулах зөвлөл
ЖАЙКА	Japan International Cooperation Agency /JICA/	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
МҮОНРТ	Mongolia National Broadcaster	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
ТББ	Non-Government Organization	Төрийн бус байгууллага
OJT	On-the-Job Training	Ажлын байран дахь сургалт
OT	Occupational Therapist	Ахуй засалч
PDM	Project Design Matrix	Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй
PO	Plan of Operation	Үйл ажиллагааны төлөвлөгөө
PT	Physical Therapist	Хөдөлгөөн засалч
UNICEF	United Nations Children's Fund	НҮБ-ын Хүүхдийн сан

Монгол Улс дахь “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагааны эцсийн тайлан

Гарчиг

Гэрэл зургууд
Төсөл хэрэгжсэн байршлын зураг
Товчилсон үг, нэр томъёоны тайлбар

Төслийн танилцуулга 1

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ 4

1-1 Японы талаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа (Төслийн оролт) 4

1-2 Монгол талаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа (Оролт) 5

1-3 Үйл ажиллагаа 8

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ 88

2-1 Төслийн зорилт болон шалгуур үзүүлэлт 88

2-2 Төслийн зорилго болон шалгуур үзүүлэлтүүд 102

2-3 Төслийн хүрэх үр дүнгийн хураангуйг сайжруулах өөрчлөлтүүд 104

2-4 Бусад 104

БҮЛЭГ 3. 5 ҮЗҮҮЛЭЛТЭЭР ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН 105

3-1 5 үзүүлэлтээр хийсэн үнэлгээний үр дүн 105

3-2 Төслийн хэрэгжилт, үр дүнд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд 109

3-3 Төслийн эрсдлийн менежментийн үр дүнтэй холбоотой үнэлгээ 109

3-4 Сургамж ба тулгамдсан асуудал 110

БҮЛЭГ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ДУУССАНААС ХОЙШ ЭРХЭМ ЗОРИЛГЫГ БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛД 118

4-1 Эрхэм зорилго биелэгдэх төлөв 118

4-2 Монголын талд тавих санал 122

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Төслийн эрхэм зорилго ба төслийн зорилго, зорилтууд 2
Хүснэгт 2 Төслийн эхний хагаст Япон мэргэжилтнүүдийн ажилласан байдал (2015.08-2017.06) 4
Хүснэгт 3 Төслийн сүүлийн хагаст Япон мэргэжилтнүүдийн ажилласан байдал (2017.07-2019.07) 4
Хүснэгт 4 Төсөлд хамтран ажиллаж буй гол мэргэжилтнүүд 6
Хүснэгт 5 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хариуцсан зардал 8
Хүснэгт 6 Туршилтын дүүргийг сонгосон шалгуур нөхцөл 10
Хүснэгт 7 Туршилтын аймаг сонгосон шалгуур нөхцөл 10
Хүснэгт 8 Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа 11
Хүснэгт 9 Хамтарсан зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн 14
Хүснэгт 10 ХЗЗ-ийн хурал зохион байгуулсан өдөр ба хэлэлцэж шийдвэрлэсэн агуулгууд 14
Хүснэгт 11 Эрт илрүүлэг, оношилгоо, хөгжлийн хөтөлбөрийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн 17
Хүснэгт 12 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” -тай холбоотойгоор зохион байгуулсан уулзалтууд 20
Хүснэгт 13 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлагын бүтэц 21
Хүснэгт 14 “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулах сорил судалгаа, сургалтын хэрэгжилт 26
Хүснэгт 15 Портеж хөтөлбөрийн Монгол хувилбар боловсруулах үйл ажиллагааны явц 29
Хүснэгт 16 Кэйс хэлэлцүүлгийн үйл явц 30
Хүснэгт 17 Баянгол дүүрэгт Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн байдал 33
Хүснэгт 18 Хөвсгөл аймагт Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн байдал . 33
Хүснэгт 19 Цэцэрлэг багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байдал .. 35
Хүснэгт 20 Мэргэжил арга зүйн багийн гишүүд 37
Хүснэгт 21 Нийслэлийн туршилтын ердийн сургуулийг сонгох шалгуур 38
Хүснэгт 22 Нийслэлийн туршилтын сургуулийн нэрс 38
Хүснэгт 23 Тусгай сургуулийн ажлын хэсэг 39
Хүснэгт 24 Туршилтын ердийн сургуулийн ажлын хэсэг 39
Хүснэгт 25 Төсөл хэрэгжихийн өмнөх ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний жишээ 41
Хүснэгт 26 Шинэ загварын дагуу боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний жишээ 42

Хүснэгт 27 Туршилтын тусгай сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн тоо (2018-2019 оны хичээлийн жилд).....44
Хүснэгт 28 Хөгжлийн төвшинг тодорхойлох хүснэгт.....47
Хүснэгт 29 Туршилтын ердийн сургуулиудад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх дэмжлэгийн агуулга.....53
Хүснэгт 30 Туршилтын сургуулийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн тоо (2018-2019 оны хичээлийн жил).....56
Хүснэгт 31 Багш өөрчлөгдөхөд хүүхэд өөрчлөгдөнө—Хөвсгөл аймгийн сайн жишээнээс.....57
Хүснэгт 32 “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж”-ийн хүүхдийн онцлог хэрэгцээг таних асуулга 58
Хүснэгт 33 Аль нэг чадварын хувьд доголдолтой хүүхдийн тоо, дундаж 60
Хүснэгт 34 Нийслэлийн туршилтын ердийн сургуульд суралцаж байсан өгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо (2017 оны 02-р сарын байдлаар).....60
Хүснэгт 35 СБД-ийн 35-р сургуулийн сонгосон хүүхдэд тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх төлөвлөгөө.....62
Хүснэгт 36 Хүүхэд хөгжлийн төвд хамрагдсан хүүхдийн тоо 64
Хүснэгт 37 Сургуулийн дэмжлэгийн багийн гишүүд болон үйл ажиллагааны төлөвлөгөө 65
Хүснэгт 38 Эхний удаагийн бичил төслийн хэрэгжилтийн агуулга, үр дүн.....68
Хүснэгт 39 2 дахь удаагийн бичил төслийн хэрэгжилтийн агуулга, үр дүн 70
Хүснэгт 40 Эхний жилийн туршлага солилцох семинар 74
Хүснэгт 41 Хоёрдох жилийн туршлага хуваалцах семинар.....75
Хүснэгт 42 БМДИ-ийн арга зүйчдэд зориулсан сургалт.....77
Хүснэгт 43 Багшийн хөгжил портал сайтад байршуулсан бүтээгдэхүүний жагсаалт .77
Хүснэгт 44 Зайн сургалтын бүтэц 78
Хүснэгт 45 МУБИС, БоСС-ын ТХБ-ын тэнхмийн оюутнуудад хичээл ордог сургагч багш нарын хичээлийн агуулга (2017-2019).....80
Хүснэгт 46 Бага, дунд боловсролын сургуулийн барилга байгууламжийг сайжруулах төсөлд хамрагдсан сургуулийн багш нарт зориулсан цуврал сургалт.....82
Хүснэгт 47 Техникийн хамтын ажиллагааны үр дүн, эцсийн бүтээгдэхүүн.....85
Хүснэгт 48 Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт.....88
Хүснэгт 49 Холбогдох байгууллагын хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх 90
Хүснэгт 50 Зорилт 2-ын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт 92
Хүснэгт 51 Туршилтын сургуулийн багш нараас хүлээгдэж буй чадавх болон биелэлт 93

Хүснэгт 52 Бичил төслүүдийн батлагдсан үр дүн.....99
Хүснэгт 53 Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт.....101
Хүснэгт 54 Төслийн зорилго дахь шалгуур үзүүлэлтийн биелэлт.....103
Хүснэгт 55 Үндэсний хөтөлбөрийн төсөлд өгсөн санал.....110
Хүснэгт 56 Сургууль нийтээр хамтран ажиллах тогтолцоо бий болгох арга хэмжээ 113

Бүдүүвч, зургийн жагсаалт

Бүдүүвч, зураг 1 Кэйс хэлэлцүүлгээр дэмжлэг үзүүлэх үйл явц 30
Бүдүүвч, зураг 2 Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний жишээ (Зарим хэсгийг товчлов) 31
Бүдүүвч, зураг 3 Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг,.....103
Бүдүүвч, зураг 4 Хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай хөтөлбөр 122

Графикийн жагсаалт

График 1 Туршилтын сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 118
График 2 Туршилтын болон туршилтын бус сургуулиудад хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо.....119
График 3 Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн салбар комиссоор хэлэлцсэн хүүхдийн тоо 120
График 4 Туршилтын сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо.....120
График 5 Туршилтын сургууль болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо.....121

Хавсралтууд

1 Япон дахь сургалтад оролцогчдын жагсаалт

2 Тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт

3 Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй (PDM)

4 Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө (PO)

5 Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурлын тэмдэглэл (7 удаагийн)

6 Төслийн сонин (Дугаар 1-4)

7 Төслийн эцсийн төлөв байдлын судалгааны тайлан

8 “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбарыг боловсруулах сорил судалгаа, сургалтад оролцогчид

9 “Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад оролцогчид

10 Туршилтын тусгай сургуулиудад хэрэгжүүлсэн сургалтууд

Төслийн танилцуулга

1. Улсын нэр: Монгол Улс
2. Төслийн нэр: “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”
   Project for Strengthening Teachers’ Ability and Reasonable Treatments for Children with Disabilities
3. Төслийн хэрэгжих хугацаа: 2015 оны 08 дугаар сараас 2019 оны 07 дугаар сар
4. Төслийн үндэслэл:

Монгол Улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцид нэгдэн орсон бөгөөд тус конвенцийн үзэл санааны хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийг 2016 оны 02 дугаар сард УИХ-аар батлан хэрэгжүүлж байна. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2017 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (Монгол Улсын Засгийн газрын 321 дүгээр тогтоол)”-т хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, төрийн бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн санал бодлыг тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусламж үйлчилгээг сайжруулах зэргээр төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тусгасан болно.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны судалгаанд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн цэцэрлэг болон бага сургуульд хамрагдсан байдал ойролцоогоор 40%, суурь боловсролд дэвшин суралцсан байдал 14% байна гэжээ (“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”). Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй нь тогтоогдсон ч шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг авч чадахгүй байх, гэр бүлд дэмжлэг үзүүлэх тогтолцоогүй, сургуульд хүлээн авах тогтолцоо бүрдээгүй зэрэг нь хүүхдүүдийн сургуульд хамрагдахад хүндрэл учруулж байна. Мөн сургуульд хамрагдсан боловч хэрэгцээндээ нийцсэн боловсролын үйлчилгээ авч чадахгүй, сургуулиас гарах тохиолдол ч цөөнгүй байна.

Эдгээр шалтгаанд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг сайжруулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлсэн.

5. Төслийн эрхэм зорилго ба төслийн зорилго, зорилтууд:

Төслийн эрхэм зорилго болон зорилго, зорилт, үйл ажиллагааг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1 Төслийн эрхэм зорилго ба төслийн зорилго, зорилтууд

Төслийн эрхэм зорилго	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг хүртэх
Төслийн зорилго	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилогоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох

Зорилт 1	Үйл ажиллагаа
Туршилтын аймаг, дүүрэг дэх холбогдох байгууллагуудын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийг хэрэгжүүлэх чадавх бэхжинэ.	1-1 Туршилтын аймаг, дүүргийг сонгох. 1-2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн, хөгжлийн дэмжлэгийн талаар эргэн судалж, сайжруулах. 1-3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс болон туршилтын аймаг, дүүргийн Салбар комисст зориулсан хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэгтэй холбоотой сургалтуудыг зохион байгуулах. 1-4 Туршилтын аймаг, дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийн үйл ажиллагааг зохион байгуулах (Асран хамгаалагчдад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа зэрэг). 1-5 Үйл ажиллагаа 1-4-ийг эргэн судлах. 1-6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагаанаас гадна, бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг болон Эмчилгээ-сэргээн засалтыг хэрэгжүүлэх боломжийг судлах. 1-7 Холбогдох байгууллага тус бүрийн цуглуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн мэдээллүүдийг хяналт удирдлагаар хангах механизмийг судлах.
Зорилт 2	Үйл ажиллагаа
Туршилтын сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд (Оюуны бэрхшээлтэй) өндөр чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ.	2-1 Туршилтын сургуулиудыг сонгох. 2-2 Мэргэжил, арга зүйн баг бүрдүүлэх. 2-3 Мэргэжил, арга зүйн баг нь хуучин хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн жишээ туршлагыг эргэн судалж, сайжруулах. 2-4 Мэргэжил, арга зүйн баг болон туршилтын сургуулийн багш нарын сайжруулсан хэрэглэгдэхүүнийг ашиглаж, хичээлийг чанартай зохион байгуулж сургах сургалт зохион байгуулах. 2-5 Туршилтын сургуулийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах болон тэрхүү төлөвлөгөөнд тулгуурлан хичээл зохион байгуулах. 2-6 Үйл ажиллагаа 2-5-ыг эргэн судлах. 2-7 Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалтай холбоотой гарын авлага боловсруулах. 2-8 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд (Оюуны бэрхшээл) зориулсан хичээлийн жишээ туршлагын эмхэтгэлийг боловсруулах.
Зорилт 3	Үйл ажиллагаа
Бичил төслөөр дамжуулан хөгжлийн	3-1 Бичил төсөл хэрэгжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн (Бүх хөгжлийн бэрхшээлийн ангилал) хэрэгцээнд нийцсэн боловсрол сургалтын төрөл бүрийн арга хэлбэрүүдийг туршин хэрэгжүүлэх.

бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн төрөл бүрийн боловсролын үйлчилгээний хэлбэр, загвар, түүний үр дүн батлагдана.	3-2 Бичил төслийг хэрэгжүүлэх. 3-3 Бичил төслийг үнэлэх.
Зорилт 4	Үйл ажиллагаа
Зорилт 1-3-ын холбогдох байгууллагууд харилцан туршлага солилцож, үр дүн нь үндэсний бодлого тогтолцоонд тусгагдана.	4-1 Боловсролын байгууллагуудад зориулан, Зорилт 1-3-ын туршлагыг хуваалцах семинар зохион байгуулах. 4-2 Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалтыг сайжруулах зорилгоор сургуулийн удирдлагуудад Зорилт 2-ын туршлагаас танилцуулах. 4-3 Багш бэлтгэх ангийн сургалтын хөтөлбөрт (Тусгай хэрэгцээт боловсролын анги болон ердийн анги) Зорилт 2-ын туршлагаас тусгах. 4-4 БМДИ-ын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад Зорилт 2-ын туршлагыг тусгах. 4-5 Тусгай хэрэгцээт боловсролтой холбоотой сургалтын хөтөлбөрт Зорилт 2-ын туршлагаас тусгах 4-6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үнэлгээ болон хөгжлийн дэмжлэг, боловсролын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн аян зохион байгуулах.

6. Хэрэгжүүлэгч байгууллага
   - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
   - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

7. Зорилтот аймаг, дүүрэг (туршилтын аймаг, дүүрэг) ба зорилтот сургууль
   - Зорилтот аймаг, дүүрэг: Нийслэлийн Баянгол дүүрэг
     Хөвсгөл аймаг
   - Зорилтот сургуулиуд: 25, 55, 63, 70 дугаар тусгай сургууль
     Нийслэлийн 16, 26, 28, 34, 35, 79, 111, 113 дугаар сургууль

     Хөвсгөл аймгийн “Ирээдүй 21-р зуун” цогцолбор сургууль, “Титэм” 2 дугаар сургууль

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ

1-1 Японы талаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа (Төслийн оролт)

1-1-1 Хүний нөөц

Японы талаас 13 мэргэжилтэн дараах хүснэгтэд дурьдсан ажил үүргийг хариуцаж ажилласан.

Хүснэгт 2 Төслийн эхний хагаст Япон мэргэжилтнүүдийн ажилласан байдал (2015.08-2017.06)

Овог нэр	Хариуцсан ажил үүрэг	Хүн/сар(гүйцэтгэл)	
		Монголд	Японд
Иший Тэцүяа	Ерөнхий менежер, боловсролын бодлого 1	6. 70	0. 20
Сүзүки Саяака	Менежер, боловсролын бодлого 2	7. 60	0. 20
Хаяаши Акико	Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулах дэмжлэг 1	0. 60	1. 20
Хашимото Соичи	Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулах дэмжлэг 2	0. 80	1. 20
Канно Ацүши	Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулах дэмжлэг 3	0. 20	0. 00
Нишимүра Күмико	Хөгжлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх дэмжлэг 1	0. 40	0. 40
Сакүрай Рёохэй	Хөгжлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх дэмжлэг 2	3. 60	0. 00
Оотомо Киёши	Тусгай хэрэгцээт боловсрол 1	0. 80	1. 20
Нэмото Юүки	Тусгай хэрэгцээт боловсрол 2	2. 63	0. 37
Үэхара Шёоко	Бичил төслийн удирдлага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, багш бэлтгэх сургалт 1	6. 30	0. 00
Мориява Кимика	Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, багш бэлтгэх сургалт 2, Мэдээлэл, сурталчилгаа	7. 10	0. 00
	Нийт	36. 73	4. 77

Хүснэгт 3 Төслийн сүүлийн хагаст Япон мэргэжилтнүүдийн ажилласан байдал (2017.07-2019.07)

Овог нэр	Хариуцсан ажил үүрэг	Хүн/сар	
		Монголд	Японд
Иший Тэцүяа	Ерөнхий менежер, боловсролын бодлого 1	9.23	0.00
Сүзүки Саяака	Менежер, боловсролын бодлого 2	0.57	0.6
Хаяаши Акико	Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулах дэмжлэг 1	0.00	0.45
Хашимото Соичи	Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулах дэмжлэг 2	0.77	0.50
Канно Ацүши	Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулах дэмжлэг 3	0.90	0.08
Нишимүра Күмико	Хөгжлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх дэмжлэг 1	2.80	0.00
Сакүрай Рёохэй	Хөгжлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх дэмжлэг 2	9.20	0.00
Шимизү Наожи	Хөгжлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх дэмжлэг 3	0.20	0.00
Ёшикава Мачико	Хөгжлийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх дэмжлэг 4	0.20	0.00
Оотомо Киёши	Тусгай хэрэгцээт боловсрол 1	0.80	0.40
Нэмото Юүки	Тусгай хэрэгцээт боловсрол 2	0.90	0.00
Үэхара Шёоко	Бичил төслийн удирдлага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, багш бэлтгэх сургалт 1	12.30	0.00
Мориява Кимика	Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, багш бэлтгэх сургалт 2, Мэдээлэл, сурталчилгаа	1.10	0.00
	Нийт	38.97	2.03

1-1-2 Төсөв, санхүүгийн нөөц

Сургалтын байр танхим түрээслэх зардлыг Японы тал хариуцсан. Үйл ажиллагааны нийт зардал 91 сая иен (ойролцоогоор) болсон.

- Төслийн эхний хагас (2015.08 сараас 2017.06 сар): 36, 939 мянган иен
- Төслийн сүүлийн хагас (2017.08 сараас 2019.07 сар): 55, 053 мянган иен

1-1-3 Япон дахь сургалт

Энэхүү төслийн үйл ажиллагаанд хамтран ажилласан Монголын талын холбогдох хүмүүст зориулсан сургалтыг Японд 4 удаа зохион байгуулсан бөгөөд 4 удаагийн сургалтад нийт 52 хүнийг хамруулсан. Сургалтад оролцогчдын нэрсийн жагсаалтыг Хавсралт 1-д үзүүлэв.

Япон дахь сургалтыг Монголд технологи шилжүүлэх үйл ажиллагааны нэг чухал хэсэг гэж үзсэн. Оролцогчид Япон дахь сургалтаас санаа авч, эх орондоо ирсний дараа төслийн үйл ажиллагаанд ашиглах нь сургалтын үндсэн зорилго байсан. Түүнчлэн төрийн захиргааны төв байгууллага болон их сургууль, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын янз бүрийн мэргэжилтнүүд тодорхой хугацаагаар өдөр тутмын ажлаасаа хөндийрөн нэг зүйлд анхаарч, нэг сэдвээр сургалтад хамрагдах явцдаа Монголд тулгамдаж буй асуудлууд болон түүнийг шийдвэрлэх арга замын талаар харилцан ярилцаж, санаа бодлоо уралдуулах боломжоор хангахыг зорьсон.

1-1-4 Тоног төхөөрөмж, хэрэгсэл олгосон байдал

Энэхүү төсөл хэрэгжих хугацаанд олгосон тоног төхөөрөмж, хэрэгслийн дүн ойролцоогоор 2.6 сая иен болсон бөгөөд олгосон тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалтыг Хавсралт 2-т үзүүлэв.

1-2 Монгол талаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа (Оролт)

1-2-1 Төсөлд хамтран ажилласан гол хүмүүс

Монгол тал тус төсөлд хамтран ажиллах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Хамтарсан зохицуулах зөвлөл, Зорилт 1-ийн Ажлын хэсэг, Зорилт 2-ын Мэргэжил, арга зүйн багийг бүрдүүлсэн. Энэ 3 багаас гадна гол холбогдож ажилласан мэргэжилтнүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв. Түүнчлэн Ажлын хэсэг болон Мэргэжил, арга зүйн баг бүрэлдэхүүнийг тус бүр Хүснэгт 11, Хүснэгт 20-т үзүүлэв.

Хүснэгт 4 Төсөлд хамтран ажиллаж буй гол мэргэжилтнүүд

Зорилт 1: Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт холбогдох байгууллагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжинэ.		
Байгууллага	Албан тушаалтан/баг	Төсөлтэй холбоотой үйл ажиллагаа
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хүн амын хөгжлийн газрын дарга С.Тунгалагтамир	• ХЗЗ-ийн хурлын дэд дарга
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс	Дарга С.Тунгалагтамир, Мэргэжилтэн Р.Нэнсэндэн, Мэргэжилтэн Ц.Нямтулга, Мэргэжилтэн Х.Мөнхзул	• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага боловсруулахад оролцсон. • Салбар комиссуудад зориулсан бүсчилсэн сургалтыг зохион байгуулсан.
Баянгол дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс	Дарга А.Одонтунгалагтуул, бусад 6 гишүүн	• Ээлжит хуралдааныг тогтмол зохион байгуулсан. • Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр (2017.10 сараас 2 ээлж) • Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулсан. • “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулахад сорил авагчаар ажилласан. • Портеж эрт боловсролын хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад хамрагдсан.
Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв	Төвийн дарга Ө.Батжаргал, бусад эмч мэргэжилтэн	• 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг (2017.05 сараас сар бүр) • Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр (2017.10 сараас 2 ээлж)
Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс	Дарга Ж.Ганболд, бусад 6 гишүүн	• Ээлжит хуралдаан тогтмол зохион байгуулсан. • Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр (2018.03 сараас) • Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулсан. • “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулах судалгаанд сорил авагчаар ажилласан. • Портеж эрт боловсролын хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад хамрагдсан.
Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Баяндалай, бусад мэргэжилтэн	• 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг (2017.10 сараас)
Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг	Дарга С.Чагнаадорж, бусад эмч мэргэжилтэн	• 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг (2017.10 сараас)
Зорилт 2: Туршилтын сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд (Оюуны бэрхшээлтэй) өндөр чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ.		
Байгууллага	Албан тушаалтан/баг	Төсөлтэй холбоотой үйл ажиллагаа
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан	• ХЗЗ-ийн хурлын дарга
Боловсрол, соёл,	Тэгш хамруулан сургах	• Тус төслийг хариуцсан мэргэжилтэн, ХЗЗ-ийн

шинжлэх ухаан, спортын яам	боловсролын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Б.Гэрэлтуяа	хурлын нарийн бичгийн дарга • Тэгш хамруулан сургах боловсролын цахим сургалтын сургагч багш
Боловсролын хүрээлэн	Тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан Ц.Цэвэгмид	• Мэргэжил, арга зүйн багийн гишүүн
Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	Арга зүйч Ч.Жаргал	• Мэргэжил, арга зүйн багийн гишүүн • Тэгш хамруулан сургах боловсролын онлайн сургалтын сургагч багш
Монгол Улсын Боловсролын их сургууль	Тусгай хэрэгцээт боловсролын тэнхмийн эрхлэгч Г.Батцэнгэл	• Мэргэжил, арга зүйн багийн гишүүн • Тэгш хамруулан сургах боловсролын онлайн сургалтын сургагч багш • Туршилтын сургуулийн Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагаа
	Багш Д.Одгэрэл	• Мэргэжил, арга зүйн багийн гишүүн • “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулах
Туршилтын 4 тусгай сургууль	Ажлын баг	• Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар боловсруулах аргачлал • Судалгаат хичээл зохион байгуулах, хичээлд дүрс бичлэг хийх • Туршилтын ерөнхий боловсролын сургуулиудад өгөх арга зүйн зөвлөмж, лекц, дадлага ажлууд
Нийслэл дэх туршилтын 8 ерөнхий боловсролын сургууль	Ажлын баг	• Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл • Сургуулийн дэмжлэгийн баг • Тохирох хэрэглэгдэхүүнээр хангах • Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагаа (5 сургууль) • Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж
Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар	Насан туршийн боловсрол хариуцсан арга зүйч Д.Баасансүрэн (Хөвсгөл аймгийн Салбар комиссын гишүүн)	• Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл • Сургуулийн дэмжлэгийн баг
Хөвсгөл аймгийн туршилтын 2 ерөнхий боловсролын сургууль	Ажлын баг	• Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл • Сургуулийн дэмжлэгийн баг • Тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үйл ажиллагаа • Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж

1-2-2 Төсөв, санхүүгийн нөөц

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын (цаашид Комисс гэх) гишүүдийн туршилтын аймагт ажиллах томилолтын зардлыг хариуцаж байсан. Мөн Комиссын Салбар комиссуудад зориулсан бүсчилсэн сургалт (2017.10-11 сар) зохион байгуулах зардлыг хариуцсан.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь техникийн хамтын ажиллагааны төслийн эцсийн бүтээгдэхүүнийг хянан засварлах, цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулсан сургагч багшийн хөлс, тусгай сургуулийн багш нарын туршилтын ердийн сургуульд чиглэсэн зөвлөн туслах үйл ажиллагааны зардал, Хөвсгөл аймгийн багш нарын Нийслэлийн тусгай сургуультай танилцах үйл ажиллагаа, туршилтын ердийн сургуулийн хүүхэд хөгжлийн төвд ажилласан оюутан туслагчийн хөлс зэрэгт дараах мөнгөн дүнг зарцуулсан.

Хүснэгт 5 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хариуцсан зардал

Он сар	Батлагдсан дүн	Зарцуулсан дүн
2017.01-12 сар	40, 808, 000 төгрөг	7, 123, 600 төгрөг
2018.01-12 сар	20, 484, 500 төгрөг	12, 972, 435 төгрөг
2019.01-06 сар	18, 395, 840 төгрөг	19, 995, 850 төгрөг
Нийт	79, 688, 340 төгрөг	40, 091, 885 төгрөг
Япон иенд шилжүүлэхэд [1]	3, 334, 957 иен	1, 677, 845 иен

1-2-3 Материаллаг нөөц

Зорилт 1-ийн баг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт, Зорилт 2-ын баг нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны байранд ажлын өрөө, материаллаг орчин нөхцөлөөр хангагдаж ажилласан.

1-3 Үйл ажиллагаа

Төслийн зорилтуудыг биелүүлэхийн тулд төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэ хэсэгт төслийн үйл ажиллагааны биелэлтийн талаар тэмдэглэлээ.

Дараагийн хуудсанд бүх үйл ажиллагаа болон зорилтууд, төслийн зорилготой хэрхэн холбогдож буй талаар дурдсан болно.

[1] ЖАЙКА “Төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх гэрээ, Төслийн үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлэх гэрээнд заасан валютын ханш” (2019.06 сар) 1 төгрөг = 0.041850 иен

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаллын үйлчилгээг сайжруулах төсөл”
Төслийн үйл ажиллагааны эцсийн тайлан

Төслийн зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох.

Зорилт 4: Зорилт 1-3-ын холбогдох байгууллагууд харилцан туршлага солилцож, үр дүн нь үндэсний бодлого тогтолцоонд тусгагдана.

- Зорилт 1-3-ын туршлагыг хуваалцах семинар зохион байгуулах
- Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг боловсронгуй болгох
- Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг сайжруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан аян зохион байгуулах
- Буцалтгүй тусламжаар баригдсан сургуулийн багш нарт сургалт зохион байгуулах

Зорилт 3: Бичил төсөл хэрэгжүүлэх замаар тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төрөл бүрийн боловсрол, сургалтын арга хэлбэрийг туршин хэрэгжүүлж, үр дүнг судална.

- Насан туршийн боловсролын төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдалтыг дээшлүүлэх
- Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сургалтын модул боловсруулах
- Ерөнхий боловсролын сургууль дахь ХБХ-д зориулсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа
- Ерөнхий боловсролын сургууль дахь харилцаа, хамтын суралцахуй
- Цэцэрлэгт тэгш хамруулан сургах
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан зурган карт боловсруулах

Зорилт 1: Туршилтын аймаг, дүүрэгт холбогдох байгууллагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжинэ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага” боловсруулах

Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхыг бэхжүүлэх	Хөгжлийн үнэлгээний чадавхыг бэхжүүлэх	Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлэх	Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх
Видео сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах	Портеж эрт боловсролын хөтөлбөрийн Монгол хувилбарыг боловсруулах	Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулах	Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр
ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах	“Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбарыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх		Цэцэрлэгт тэгш хамруулан сургахад чиглэсэн сургалт
18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг нэвтрүүлэх	Хуучин хэрэглэгдэхүүнийг эргэн судлах, шинэ хэрэглэгдэхүүн судлах		БГД-т чухал шаардлагатай байгууллагуудын зураг боловсруулах
			Аутизмтай хүүхэдтэй асран хамгаалагчдад зориулсан гарын авлага боловсруулах

Комиссын чадавхыг бэхжүүлэх

Ажлын хэсгийг байгуулах

Зорилт 2: Туршилтын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд (Оюуны бэрхшээл) өндөр чанартай боловсрол олгох чадавх бэхжинэ.

Хүүхдийн бодит байдлыг судлах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлэх	Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн хичээл зохион байгуулах чадавхыг бэхжүүлэх	Туршилтын ЕБС-ийн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх	ЕБС-д тохируулгат орчин бүрдүүлэх чадавхыг бэхжүүлэх
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний нэгдсэн загвар боловсруулах, гарын авлага боловсруулах	Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж	Туршилтын ЕБС-д зөвлөн туслах үйл ажиллагаа	Тохируулгат орчин бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
ЕБС-ийн багш нарт сургалт зохион байгуулах	Өдөр тутмын хэрэглээний 450 үгийн зурган цомог		Хүүхэд хөгжлийн төв байгуулах
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага		Сургуулийн дэмжлэгийн баг байгуулах
	Сургуульд хэлэлцүүлэг сургалт зохион байгуулах		Сургуульд хамрагдаагүй болон шинээр хамрагдах хүүхдэд үзүүлэх дэмжлэг
	Судалгаат хичээл зохион байгуулах, хичээлийн жишээ туршлагын эмхэтгэл боловсруулах		

Туршилтын сургуулиудад ажлыг баг бүрдүүлэх

Туршилтын сургуулиудыг сонгох

Мэргэжил, арга зүйн баг бүрдүүлэх

1-3-1 Төслийн ерөнхий үйл ажиллагаатай холбоотой зүйлүүд

1-3-1-1 Туршилтын аймаг, дүүргийг сонгон шалгаруулав

2015 оны 08 дугаар сараас 11 дүгээр сард Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай (хуучнаар) зөвшилцөн, Нийслэлийн төвийн 6 дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс болон Боловсролын хэлтэстэй уулзаж ярилцсаны эцэст Хамтарсан зохицуулах зөвлөлийн анхны хурлын шийдвэрээр Баянгол дүүргийг сонгосон.

Хүснэгт 6 Туршилтын дүүргийг сонгосон шалгуур нөхцөл

- Дүүрэгтээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлэх хүсэл сонирхолтой байгаа.
  - Тухайн дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, бусад холбогдох байгууллага, хэлтэс (Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн дэмжлэгийн төв зэрэг) нь тус төслийн зорилгыг ойлгосон, хамтран ажиллахад бэлэн.
  - Дүүргийнхээ үйл ажиллагаатай холбоотой зардал, төсвийг хариуцах боломжтой.
- Хэдийнэ тодорхой хэмжээнд хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлж эхэлсэн.
- Тусгай сургуультай дүүрэг байвал давуу тал болно.

2016 оны 02-07 дугаар сард, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (Цаашид Салбар комисс гэх) нь ээлжит хуралдааныг [2] тогтмол зохион байгуулж байсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд ихээхэн анхаардаг гэсэн мэдээлэл бүхий 6 аймагт очиж танилцсаны эцэст туршилтын аймгийг сонгосон. ХЗЗ-ийн 3 дахь удаагийн хурлын шийдвэрээр Хөвсгөл аймгийг туршилтын аймгаар сонгосон.

Хүснэгт 7 Туршилтын аймаг сонгосон шалгуур нөхцөл

	Шалгуур нөхцөл		Оноо
Эхний шатны шалгаруулалт	Салбар комисс	Ээлжит хуралдаан зохион байгуулж буй давтамж	Тогтмол: A (10 оноо) Тогтмол биш: B (5 оноо) 0 удаа: C (0 оноо)
		Үйл ажиллагааны төсөв, зардал	Хангалттай: A (10 оноо) Бага зэрэг : B (5 оноо) Байхгүй: C (0 оноо)
		Дэмжлэгийн хэрэгцээ шаардлага	Арга технологи: A (10 оноо) Хүний нөөц: B (5 оноо) Төсөв: C (0 оноо)
	Боловсрол	Төрийн өмчийн сургуульд сурдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	Их 33%: A (10 оноо) Дунд зэрэг 33%: B (5 оноо) Цөөн 33%: C (0 оноо)
		Тусгай анги бий эсэх	Байгаа: A (10 оноо) Төлөвлөсөн: B (5 оноо) Байхгүй: C (0 оноо)

[2] 16 хүртэлх насны хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр хөгжлийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулан зөвлөгөө өгөхийн зэрэгцээ халамж олгох асуудлыг шийдвэр гаргадаг хурал.

		Насан туршийн боловсролын төв	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үйлчлүүлдэг: А (5 оноо) Төлөвлөсөн: В (3 оноо) Үйлчлүүлдэггүй: С (0 оноо)
		Бусад боловсролын нөөцтэй эсэх (Эцэг эхийн холбоо, ТББ зэрэг)	Байгаа: А (5 оноо) Байхгүй: С (0 оноо)
2 дахь шатны шалгаруулалт	Бусад хандивлагчдаас туслалцаа авч буй эсэх		
	Газар зүйн байршлын чухал		
	Багш бэлтгэдэг сургуультай эсэх		

1-3-1-2 Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа

Монгол, Япон хоёр орны ард түмэнд энэхүү туслалцаа дэмжлэгийн ач холбогдол болон үйл ажиллагааны агуулга, төслийн зорилтыг зөвөөр ойлгуулахын хамт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтийг дээшлүүлэхийн тулд дараах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулсан. Гэрэл зураг болон дүрс бичлэг ашиглахдаа тухайн хүн болон асран хамгаалагчийнх нь (Насанд хүрээгүй тохиолдолд) зөвшөөрлийг авч байсан.

Хүснэгт 8 Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа

	Мэдээлэл, сурталчилгааны ажлууд	Цаг хугацаа/тоо давтамж
Төсөлтэй холбоотой мэдээлэл, сурталчилгаа	Төслийн танилцуулга хэвлүүлэх, шинэчлэх	• 2015.10 сард анх удаа хэвлүүлсэн. • 2015.12 сар, 2016.07 сар болон 11 сард тус тус шинэчилсэн.
	Төслийн сонин хэвлүүлэх (9 дүүрэг, 21 аймгийн Салбар комисс болон бусад холбогдох байгууллагуудад тараах)	• Дугаар 1: 2016.04 сард • Дугаар 2: 2017.02 сард • Дугаар 3: 2018.12 сард • Дугаар 4: 2019.03 сард
	ЖАЙКА-ийн цахим хуудсанд байршуулах https://www.jica.go.jp/project/mongolia/013/index.html	• 2015.08-2019.07 сар хүртэл 38 нийтлэл
	Төслийн Facebook хуудсанд (JICA START) байршуулах, нийтлэх https://www.Facebook .com/jicastart/	• 2017.10-2019.07 сар хүртэл 150 нийтлэл (2019.06.30-ны байдлаар дагагчдын тоо 1021 хүн)
	Мэдээлэл, сурталчилгаа зорилгоор хуанли хэвлүүлж тараах (9 дүүрэг, 21 аймгийн Салбар комисс, бусад холбогдох байгууллагуудад тараах)	• 2017.01 сар: Гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээлээр ширээний хуанли хэвлүүлсэн. • 2017.12 сар: Туршилтын сургуулиудаас ирүүлсэн бүтээлүүдээр ширээний хуанли, ханын хуанли хэвлүүлсэн. • 2018.12 сар: Туршилтын сургуулиудаас ирүүлсэн бүтээлүүдээр ширээний хуанли хэвлүүлсэн.
	Төслөөс гарч буй үр дүнг сурталчлах	• 2019.05 сар: Төслийн үйл ажиллагааны үр дүн болон холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагыг Ийгл телевизээр нэвтрүүлсэн (1 удаа 3 минут орчим, 8 удаа).

		• 2019.05 сар: “Туршлага солилцох семинар”-ыг хэвлэл мэдээллийн 7 байгууллага сурвалчилсан. • 2019.06 сар: ХЗЗ-ийг Ийгл телевиз сурвалжилсан
Эрт илрүүлгийн өдөр	Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн өдрийг тохиолдуулан шторк бэлтгэж нэвтрүүлэх	• 2016.05 сар: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комисс (хуучнаар) шторк бэлтгэхэд туслалцаа үзүүлсэн. • 2017.05.11-14: Нийслэлд гудамжны 2 том дэлгэцээр уг шторкыг нэвтрүүлсэн. • 2019.05 сар: 2018 онд бэлтгэсэн мэдээлэл, сурталчилгааны 2 видеог (Хойно дурдах) MYOHPT-ээр нэвтрүүлсэн.
Эх үрсийн баяр	Хүүхэд өсгөхөд хэрэгтэй зөвлөмж бэлтгэж, нийтлэх	• 2018.06 сар: Хүүхэд өсгөхөд хэрэгтэй зөвлөмжийг (Шүд угаах, хооллолт, шим тэжээл, аюул ослоос сэргийлэх болон аюулгүй байдлыг хангах, тоглоом) Facebook-т нийтэлсэн. • 2019.06.03: Дээрх зөвлөмж нийтлэлийг дүрсжүүлэн, MYOHPT-ээр нэвтрүүлсэн.
Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр	Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан шторк бэлтгэж нэвтрүүлэх	2015.11 сард Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн үндэсний төвд (хуучнаар) шторк бэлтгэхэд нь туслалцаа үзүүлсэн. 11.29-12.10-нд MYOHPT, TV5, TV9, MN25, UBS телевизээр нэвтрүүлсэн.
	Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийслэлийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулах, бүтээлийн үзэсгэлэн гаргах	• 2016.11-12 сар: Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн бүтээлүүдийг шалгаруулсан бөгөөд шагнал гардуулах ёслол, үзэсгэлэн зохион байгуулах, бүтээлийн цомог хэвлүүлж тараасан. • 2017.11-12 сар: Туршилтын сургуулиуд, БГД болон Хөвсгөл аймгийн Салбар комиссоос ирүүлсэн хүүхдүүдийн бүтээлийг сонинд (UB Post, Өдрийн сонин) нийтлүүлж, БСШУСЯ, ХНХЯ, тусгай сургуульд үзэсгэлэн гаргасан.
	Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан мэдээлэл, сурталчилгааны видео бэлтгэх	Нийслэлийн 35-р сургуульд сурдаг ихэр хөвгүүдийг сурвалжилсан “Бүх хүүхэд хөгждөг”, Ховд аймгийн 7-р сургуульд сурдаг охиныг сурвалжилсан “Хүүхэд нэг бүрт тэгш боломж” сэдэвт 2 баримтат нэвтрүүлэг бэлтгэсэн. 2018.12 сард ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын Youtube сувагт байршуулснаас гадна, БСШУСЯ-ны телевизийн нэвтрүүлэг, ХНХЯ-ны цахим хуудсанд байршуулж, Хөвсгөл аймгийн орон нутгийн телевизээр нэвтрүүлсэн.
Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, товхимолд	Нээлттэй нийгэм форум ТББ-аас зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын форум”-д аман илтгэл	2015.12.21-нд Японы тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоо ба Оосака хотын “Хамтдаа суралцах боловсрол сургалтын жишээ туршлага” сэдвээр илтгэл тавьсан.
	ХУД-ээс зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах өнөөдрийн чиг хандлага” сэдэвт бага хуралд аман илтгэл	2016.05.11-нд Японы хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, эрт оролцооны тогтолцоо болон БГД-т хэрэгжүүлж буй туршилтын үйл ажиллагааны талаар илтгэл тавьсан.

	Токио Гакүгэй их сургуулийн Боловсролын судалгаа, дэмжлэгийн төвөөс гаргадаг товхимолын дугаар 14-т судалгааны илтгэл нийтлэх	“Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол”, “Хичээлийг сайжруулахад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө ашиглах нь: Монголын сургуулиудын хичээл сургалт” сэдвээр судалгааны 2 илтгэл нийтлүүлсэн.
	Дэлхийн хичээлийн судалгааны нийгэмлэгийн 2017 оны онол практикийн бага хуралд ханын илтгэл	2017.11.26-нд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үр өгөөж” сэдэвт ханын илтгэлээр оролцсон.
	Японы тусгай боловсролын нийгэмлэгийн 56 дахь удаагийн хуралд ханын илтгэл	2018.09.24-нд “Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгож буй боловсрол 1) Сургуулийн боловсролын өнөөгийн байдал ба тулгамдаж буй асуудал 2) Ердийн сургууль дахь суралцахуйн бэрхшээл, зан үйлийн асуудалтай хүүхдийн бодит байдал” сэдвээр илтгэл тавьсан.
	“Японы хөгжлийн бэрхшээлд дэмжлэг үзүүлэх тогтолцоо” нийгэмлэгийн 2018 оны эрдэм шинжилгээний хуралд ханын илтгэл	2018.12 сард “Монгол дахь хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг-18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн дараах “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийн туршилтын үйл ажиллагаа” сэдвээр илтгэл тавьсан.
	БМДИ-ээс эрхлэн гаргадаг “Багшийн хөгжил” сонинд нийтлэл	2017.04 сард хэвлэгдсэн уг сонинд, 28-р сургуулийн тохируулгат орчин бүрдүүлэх үйл ажиллагааны талаар нийтлүүлсэн.
	“Кёодо Ньюс”-ийн “Дэлхий ертөнц баялаг” нийтлэл	2017.12 сард “Өчүүхэн санаачлага, туслалцаанд хэн бүхэн баярладаг сургууль болгоё” сэдвээр нийтлэл хэвлүүлсэн.
	2019 онд хэвлэгдсэн “Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийн лавлах”-д нийтлэл	2018.09 сард “Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өнөөгийн байдал ба тулгамдаж буй асуудал” сэдвээр нийтлэл хэвлүүлсэн.
	“Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх” Ази, номхон далайн орнуудын бүсийн чуулган” (CBID)	2019.07.03-нд “Significance of “resource room” in establishing inclusive values in Mongolia, Perspectives of case pupils, parents/guardians, teachers, and university students” сэдвээр аман илтгэл тавьсан.

* Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн өдөр: Жил бүрийн 05 дугаар сарын 13-ны өдөр
* Эх үрсийн өдөр: Жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдөр
* Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр: Жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдөр

1-3-1-3 Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал (цаашид ХЗЗ гэх)

ХЗЗ-ийн хурлын даргаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны төрийн нарийн бичгийн дарга, хурлын дэд даргаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга ажилласан ба ХЗЗ-ийн хурлаар төслийн төлөвлөгөө боловсруулах, явцад хяналт тавих, чухал шийдвэрүүдийг гаргах зэргээр ажилласан. 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн эхний удаагийн ХЗЗ-ийн хурлын өмнөхөн бүрэлдэхүүнийг 2 яамны сайдын хамтарсан тушаалаар баталсан. Хожим нь 2 яамны зарим мэргэжилтнүүд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдөр 2 яамны сайдын хамтарсан тушаал шинэчлэгдэж, гишүүдийг албан тушаалаар нь томилох болсон.

Хүснэгт 9 Хамтарсан зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн

Чиг үүрэг	Байгууллага, албан тушаал
Хурлын дарга	БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
Хурлын дэд дарга	ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын дарга
Нарийн бичгийн дарга	БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын газрын мэргэжилтэн
Монголын талын гишүүд	БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын газрын дарга
	БСШУСЯ-ны Төсөл, хөтөлбөр, гадаад харилцааны газрын дарга
	БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын газрын мэргэжилтэн
	ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэлтсийн дарга
	ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын 3 гишүүн
	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн үндэсний төвийн дарга
	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газрын дэд дарга
	25-р тусгай сургуулийн захирал
	55-р тусгай сургуулийн захирал
	63-р тусгай сургуулийн захирал
	70-р тусгай сургуулийн захирал
Японы талын гишүүд	ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга
	ЖАЙКА “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн ерөнхий менежер
	ЖАЙКА “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн менежер

2019 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд ХЗЗ-ийн хурлыг 6 удаа зохион байгуулсан. Бүх хурлуудыг зохион байгуулсан өдөр болон хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн агуулгыг дор үзүүлэв (Хавсралт 3: ХЗЗ-ийн бүрэлдэхүүн, хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн агуулгыг үзнэ үү). 6 дахь удаагийн ХЗЗ-ийн хурлаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргыг ХЗЗ-ийн гишүүнээр томилсон. 7 дахь удаагийн ХЗЗ-ын хурлыг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан.

Хүснэгт 10 ХЗЗ-ийн хурал зохион байгуулсан өдөр ба хэлэлцэж шийдвэрлэсэн агуулгууд

	Зохион байгуулсан өдөр	Хурлаар хэлэлцсэн агуулга
Эхний	2015.11.02	• Монгол хэл дээрх төслийн албан ёсны нэр, Нийслэл дэх туршилтын дүүрэг, туршилтын сургуулиудыг тогтов. • Монголын талаас хариуцах зардал, “Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр”-т зориулсан аян зохион байгуулах, төслийн хүрэх үр дүнгийн шалгуурын нэмэлт өөрчлөлтийг (Зорилт 2-ын шалгуур 1) хэлэлцэв.
2 дахь	2016.05.06	• Төслийн явцын тайлан болон 2 дахь жилийн (2016.08-2017.06) үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэв. • Туршилтын аймаг болон бичил төсөл шалгаруулах аргачлалыг тогтов.
3 дахь	2016.10.24	• Төслийн явцын тайлан (2015.08-2016.10) болон 2016.11-2017.06 сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэв. • ХЗЗ-ийн шинэ бүрэлдэхүүн, Зорилт 1-ийн ажлын хэсэг, Зорилт 2-ын

		мэргэжил, арга зүйн багийн бүрэлдэхүүнийг танилцуулав. • Туршилтын аймгийн сонгон шалгаруулалт болон төсвийн талаар зөвшилцөв.
4 дэх	2017.05.19	• Төслийн явцын тайлан (2016.11-2017.05), 3 дахь жилийн (2017.08-2018.06) үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэв. • Бичил төслийн эхний шатны сонгон шалгаруулалт талаар хэлэлцэв.
5 дахь	2018.03.09	• Төслийн явцын тайлан (2017.06-2018.02), 4 дэх жилийн (2018.03-2019.06) үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэв. • Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг танилцуулав.
6 дахь	2019.01.29	• Төслийн явцын тайлан (2018.03-2019.01) болон 2019.01-06 сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэв.
7 дахь	2019.06.26	• Төслийн зорилго, зорилтын биелэлтийг дүгнэж, Монголын талаас цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцэв.

1-3-1-4 Төслийн үйл ажиллагаанд хийсэн ЖАЙКА-ийн үнэлгээ, судалгаанд хамтарч ажиллав

2016 оны 04 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд, ЖАЙКА нь төслийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн ба уг ажилд боловсролын бодлого хариуцсан төслийн мэргэжилтэн хамтарч ажилласан. Төсөлд хамтран ажилласан гол байгууллагуудтай (БСШУСЯ, ХНХЯ) зөвлөлдсөний зэрэгцээ Япон дахь сургалтын оролцогчидтой уулзаж ярилцан, төслийн явц, Япон дахь сургалтын үр дүн, цаашдын тулгамдсан асуудлын талаар хэлэлцсэн.

1-3-1-5 Төслийн суурь судалгааг зохион байгуулав

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээлэл цуглуулахын хамт төслийн үр өгөөжид тоон болон чанарын хэмжилт хийх зорилгоор туршилтын аймаг, дүүргээр ажилласан Баянгол дүүрэг (2016.03-04 сар), Хөвсгөл аймагт (2017.01 сар) төслийн суурь судалгааг зохион байгуулсан. Уг судалгааг Комисс, Салбар комисс, туршилтын сургуулиуд, Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиуд, холбогдох эрүүл мэндийн ажилтнуудаас авсан. Суурь судалгааны тайланг төслийн эхний хагасын үйл ажиллагааны тайланд хавсаргасан болно.

1-3-1-6 Төслийн эцсийн төлөв байдлын судалгааг зохион байгуулав

Төслийн суурь судалгаанаас гарсан үр дүнг төслийн эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнтэй харьцуулж, төсөл хэрэгжих хугацаанд шалгуур үзүүлэлт бүрээр зорилт биелсэн эсэхэд хэмжилт хийх болон цаашид тус төслөөс гарсан үр дүнг хэвшүүлэхэд ашиглах үүднээс 2018 оны 10 дугаар сараас төслийн эцсийн төлөв байдлын судалгааг зохион байгуулсан. Судалгааны тайланг Хавсралт 8-д үзүүлэв.

1-3-2 Зорилт 1-тэй холбоотой үйл ажиллагаа

Зорилт 1: Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт холбогдох байгууллагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжинэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чадвар, боломжийг аль болох нэмэгдүүлэх, эрүүл

өсөлт хөгжлийг дэмжихийн тулд тухайн хүүхэд болон гэр бүлд аль болох эрт тохирох дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай байдаг. Тохирох дэмжлэгт, тухайн хүүхэд болон гэр бүлийнх нь нөхцөл байдалд нийцүүлэн үзүүлэх дэмжлэг төдийгүй, цэцэрлэгт хамруулах зэргээр бусад хүүхдүүдтэй ижил тэгш байлгахад чиглэсэн дэмжлэгийг ч багтааж ойлгоно. Энэ зарчимд тулгуурлан Зорилт 1-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийг аль болох эрт үед нь тогтоох, хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулсны үндсэн дээр тохирох хөгжлийн дэмжлэгт холбох, цэцэрлэг, сургуульд боловсролын үйлчилгээ авахыг баталгаажуулах Хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагааг Комисс болон туршилтын аймаг, дүүргийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Төсөл хэрэгжиж эхэлсэн 2015 онд хөгжлийн бэрхшээлийг эмнэлэгт оношилж, тухайн онош дүгнэлтдээ тулгуурлан халамжийн тэтгэмж олгодог байсан хэдий ч хөгжлийн дэмжлэг гэдэг утгаараа хийж чадах зүйл хомс байсан. Мөн оюуны бэрхшээл, аутизмын хүрээний эмгэгийн талаар ойлголт хангалтгүйн улмаас эдгээр хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхэд хүндрэл ихтэй, дэмжлэгт холбон зуучилж чадахгүйд хүрэх зэргээр олон асуудлууд тулгамдаж байсан. Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Зорилт 1-ийн үйл ажиллагааны хүрээнд туршилтын аймаг, дүүргийн холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах, хөгжлийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой чадавхыг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа зохион байгуулсан.

Энд хэсэгт 1-3.2.1) Хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, 1-3.2.2) Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны талаар дурдъя.

1-3-2-1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

2013 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссыг байгуулах шийдвэрийн дагуу Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дэргэд байгуулж, 2014 оны 06 дугаар сард 9 дүүрэг, 21 аймагт Салбар комисс байгуулагдсан. Ийнхүү комисс байгуулагдсанаар, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээгээр дамжуулан хөгжлийн дэмжлэг үзүүлэх, сургуульд хамрагдалтыг дэмжих ажлыг зохион байгуулах болж, Монгол Улсад хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болно гэсэн хүлээлт үүссэн. Харин төсөл хэрэгжиж эхлэх үеийн байдлаар хөгжлийн дэмжлэг үзүүлдэг байгууллага, мэргэжилтнүүдийн ойлголт хангалтгүй, харилцан адилгүй байснаас гадна голчлон эрүүл мэндийн загварт суурилж байсан. Хөгжлийн үнэлгээ болон хөгжлийн дэмжлэгт ашиглах боломжтой хуучин хэрэглэгдэхүүн, нөөц боломжийг судлах, цэгцлэх ажил хангалттай хэмжээнд хийгдээгүй, холбогдох байгууллагуудын уялдаа холбоо ч хязгаарлагдмал байв.

Дээр дурдсан нөхцөл байдлыг үндэслэн, тус төслийн хүрээнд дараах шат дараатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд

хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн. Туршилтын аймаг, дүүрэг дэх туршилтын үйл ажиллагаандаа тулгуурлан холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран олонтаа судалсны үр дүнд, Монгол Улсад хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо ямар байж болох талаар тайлбарласан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” болон гарын авлагыг боловсруулсан. Эдгээр баримт бичиг нь цаашид хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд гол чиглэл нь болох юм.

а) Эрт илрүүлэг, оношилгоо, хөгжлийн хөтөлбөрийн ажлын хэсэг байгуулагдав (2015.11 сар)

2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/443, А/414 тоот Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар, Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцооны талаар судлах ажлын хэсэг байгуулагдсан. Харин дараа нь Засгийн газрын бүтцэд зарим өөрчлөлт орсонтой уялдан 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/86, А/187 тоот Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дор танилцуулав. Уг ажлын хэсэг нь хожим дурдах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” болон гарын авлагыг боловсруулахад хамтарч ажилласан.

Хүснэгт 11 Эрт илрүүлэг, оношилгоо, хөгжлийн хөтөлбөрийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

д/д	Нэрс	Байгууллага	Тайлбар
1	С.Тунгалагтамир	ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын дарга	
2	Х.Мөнхзул	ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	
3	Ч.Ганцэцэг	БСШУСЯ-ны Боловсролын бодлого газрын СӨБ болон бага боловсролын хэлтсийн мэргэжилтэн	Өөрчлөгдсөн
4	М.Уянга	ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн	
5	Р.Нэнсэндэн	ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Тушаал гарах үед мэргэжилтэн томилогдоогүй байсан
6	Д.Ганболд	ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн	
7	Э.Уянга	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн үндэсний төвийн эрдэм шинжилгээний ажилтан	
8	Д.Ундраа	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн	
9	Д.Оюун-Эрдэнэ	Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын	

		хөгжлийн газрын Гэр бүлийн хөгжлийн дэмжлэг хариуцсан мэргэжилтэн	
10	С.Дааримаа	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын зорилтот бүлгийн нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	
11	А.Одонтунгалагтуул	Баянгол дүүргийн Салбар комиссын дарга	
12	С.Сэлэнгэ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн	
13	Ч.Эрдэнэчулуун	“Монголын дауны холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал	
14	Л.Алтангэрэл	“Монголын аутизмын холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал	

*Байгууллагуудын нэр нь сайдын тушаал гарах үеийн байдлаар

б) Хуучин хэрэглэгдэхүүний мэдээллийг цуглуулан, шинээр боловсруулах хэрэглэгдэхүүний талаар судлав (2015.09 сараас)

Монгол Улсад авч ашиглах боломжтой эрт илрүүлэг, хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийн ямар хэрэглэгдэхүүн байгаа болох, мөн шинээр ямар хэрэглэгдэхүүн боловсруулах шаардлагатайг судлах зорилгоор, 2016 оны 02 дугаар сар хүртэл Монголд ашиглаж ирсэн сэтгэл зүй, хөгжлийн тест болон хөгжлийн дэмжлэгийн хэрэглэгдэхүүний талаар судалгаа хийж, эрүүл мэндийн байгууллагууд, их дээд сургуулиуд, ТББ-уудад ашиглаж ирсэн 19 хэрэглэгдэхүүний жагсаалтыг гаргасан.

Мөн 2016 оны 03 дугаар сард тус төслийн япон мэргэжилтэн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвд нийт 9 хүүхдэд хөгжлийн үнэлгээ хийж, асран хамгаалагчид нь зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан бөгөөд Комисс, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Баянгол дүүргийн эмнэлгийн ажилтан зэрэг 34 хүн ажиглагчаар оролцсон. Уг үйл ажиллагааны үеэр Японд ашиглагддаг “Танака Бине оюун ухааны сорил V”, “Шинэчлэгдсэн K загварын хөгжлийн сорил”, “Шинэчлэгдсэн Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийг танилцуулан, хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийн хэрэглэгдэхүүний талаар холбогдох мэргэжилтнүүдийн ойлголтыг дээшлүүлсэн

Эдгээр үйл ажиллагаанаас, Монгол хүүхдэд зориулсан стандарт сэтгэл зүй, хөгжлийн тест байдаггүйгээс гадна хөгжлийн хоцрогдол, зан үйлийн асуудалтай хүүхдийг бодит байдал дээр илрүүлж чадахгүй байгааг олж мэдсэн. Мөн Монголд хөгжлийн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх боломж хязгаарлагдмал байгаа ба хөгжлийн үнэлгээ хийж, хөгжлийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд сайтар бэлтгэн, асран хамгаалагчид өдөр тутмын амьдралд ашиглах боломжтой хэрэглэгдэхүүн шаардлагатай байгааг ойлгосон. Ингээд “Танака Бине оюун ухааны сорил V”[3] болон “Шинэчлэгдсэн Портеж эрт боловсролын хөтөлбөр”[4]-ийн Монгол хувилбар боловсруулах ажлыг

[3] Танака Бине оюун ухааны сорил нь анх Францын эрдэмтэн Бинегийн зохиосон оюун ухааны тестийг Танака Кан-Ичи засварлан Японы хөрсөнд буулгаж, 1-13 насны ангиллаар жишиг болгон боловсруулсан оюун ухааны тест юм. Уг тест нь хүүхдээр болон насанд хүрэгчдээр хийлгэх даалгаврууд, мөн 1 нас хүртэлх хүүхдийн хөгжлийг шалгах даалгаруудаас бүрдэх бөгөөд 2 настай хүүхдээс насанд хүрсэн хүнээс авах боломжтой.

[4] Портеж эрт боловсролын хөтөлбөр нь анх 1972 онд АНУ-ын Вискинсон мужийн Портеж хотод зохиогджээ. Эцэг эх,

эхлүүлэхэд хамтарч ажиллахаар болсон.

в) Комиссын чадавхыг бэхжүүлэв (2015.09 сараас)

Төсөл хэрэгжиж эхлэх үед комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйч зэрэг нийт 6 мэргэжилтэн ажиллаж байв. Харин 2016 онд Засгийн газар солигдсоны дараа мэргэжилтний тоо 3 болж цөөрсөн ба 1 мэргэжилтнээс бусад нь өөрчлөгдсөн. Төслийн баг комиссын чадавхыг бэхжүүлэх зорилгоор дараах байдлаар идэвхтэй ажилласан.

- 2015 оны 09 дүгээр сард, Монгол Улсад хөгжлийн дэмжлэг үзүүлэх ямар тогтолцоо шаардлагатайг судлах үүднээс, Комисстой хамтран Нийслэлийн 9 дүүргийн Салбар комисст (45 хүн) зориулан семинар зохион байгуулав. Семинарт, төслийн мэргэжилтэн Япон дахь хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн тухай танилцуулж, дүүргүүдийн Салбар комиссын үйл ажиллагааны байдал, тулгамдаж буй асуудлуудаар мэдээлэл солилцсон.
- 2016 оны 02 дугаар сард, Комиссын ажил үүрэг болон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай чадавхыг нь тандах зорилгоор 3 гишүүнд зориулан CUDBAS буюу “Мэргэжлийн чадварт суурилсан хөтөлбөр боловсруулах арга” (A Method of Curriculum Development Based on Vocational Ability Structure) ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулсан. Үүний үр дүнд, гишүүдийн бодлоор нэн чухал бөгөөд шаардлагатай чадавх нь “Монголын нөхцөл байдалд тохирсон тогтолцоог бүрдүүлэх чадавх” болохыг олж мэдсэн. Япон дахь сургалтын Японы тогтолцоо, зохион байгуулалтын тухай танилцуулга болон туршилтын аймаг, дүүрэг дэх туршилтын үйл ажиллагаанд чиглэсэн ажлуудаар дамжуулан Монголын нөхцөлд тохирсон хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны талаар судлах зэргээр шаардлагатай чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажиллав. Мөн “Хүүхдэд ажиглалт хийх чадвар” дутмаг байгаагаа анзаарч байсан тул хүүхдийн хэвийн хөгжлийн талаар зөв мэдлэг олгох зорилгоор 2016 оны 02-03 дугаар сард нийт 3 удаа хэлэлцүүлэг сургалт зохион байгуулсан.
- 2017 оны 10 болон 11 дүгээр сард, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Комиссын зүгээс бүх Салбар комисст зориулан бүсчилсэн сургалт зохион байгуулахад нь туслалцаа үзүүлсэн. Энэ сургалтыг 9 дүүрэг, 21 аймгийн Салбар комиссуудад зориулан 4 бүсэд хуваан зохион байгуулсан бөгөөд нийт 272 хүнийг хамруулсан. Төслийн баг, сургалтыг төлөвлөх явцад сургалтын агуулгатай холбоотой зөвлөгөөг комисст өгсөн. Мөн Нийслэлд дэх сургалт (2017.10.26-27, 124 оролцогч), Ховд аймаг дахь сургалт (2017.10.26-27, 46 оролцогч), Хөвсгөл аймаг дахь сургалтад (2017.11.22-23, 48 оролцогч), “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо”, “Тэгш хамруулан сургах боловсролын чиг хандлага”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх Салбар комиссын чиг үүрэг”, “ICF буюу Үйл ажиллагаа, хөгжлийн

гэр бүл нь өдөр тутамд хүүхдээрээ даалгавар ажиллуулах замаар хөгжлийн түвшинг нь тодорхойлох шалгах хуудас (Нялхсын хөгжил, нийгэмшихүй, хэл яриа, бие дааж хийх үйлдэл, танин мэдэхүй, хөдөлгөөн зэрэг 6 хөгжлийн айд нийт 576 даалгавартай), хөгжүүлэх даалгаврын карт, ашиглах гарын авлага, хөгжлийн явцыг тэмдэглэх хүснэгт зэргээс бүрддэг.

бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилалд тулгуурласан хүүхдийн хөгжлийн үнэлгээ” сэдэвт лекцүүдийг тус төслийн мэргэжилтэн хариуцаж ажилласан.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-т тусгасан хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны талаарх Салбар комиссуудын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалтыг 2019 онд зохион байгуулахаар төлөвлөсөн.

г) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, гарын авлага боловсруулав

Салбар комисс, холбогдох байгууллагуудын олонх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэгт ямар үүрэг гүйцэтгэвэл зохих талаар хангалттай түвшинд мэдэхгүй байсан тул хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэгийн тухай суурь ойлголт, ерөнхий чиглэл, холбогдох байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоог тодорхой болгох шаардлагатай болсон.

Эдгээр шаардлагад үндэслэн Монгол Улсад хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо ямар байх талаарх ерөнхий зураглалыг гаргахын сацуу хөгжлийн дэмжлэгийн ерөнхий чиглэл, агуулга, холбогдох байгууллагуудын чиг үүрэг зэргийг илтгэсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-ыг Комисстой хамтран боловсруулсан.

Уг зааврыг боловсруулахдаа, туршилтын аймаг, дүүрэг дэх туршилтын үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан комисс болон төслийн баг хамтран бичиж, дараах уулзалтуудаар холбогдох хүмүүсийн саналыг авч тусгасан.

Хүснэгт 12 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-тай холбоотойгоор зохион байгуулсан уулзалтууд

Цаг хугацаа	Зорилтот бүлэг	Агуулга
2016.03 сар	ХНХЯ	• Заавар боловсруулах санал
2016.06 сар	Ажлын хэсэг, салбарын мэргэжилтнүүд, нийт 28 хүн	• Заавар боловсруулах үндэслэл болон зорилгыг тайлбарлах • Комиссын бүтэц, тогтолцоо ба үйл ажиллагаатай нь танилцсан Салбар комиссуудын үйл ажиллагааны талаар танилцуулах • Заавар боловсруулах төлөвлөгөө гаргах
2016.12 сар	Ажлын хэсэг	• Зааврын зорилтот бүлгийг тодорхойлох • Зааврын нэрийг тогтох • Монгол Улсын Засгийн газраар албан ёсоор батлуулахаар тогтох
2018.06 сар	Ажлын хэсэг, холбогдох мэргэжилтнүүд, нийт 22 хүн	• Зааврын төслийг танилцуулах • Сайжруулах зүйлүүдийн талаар зөвшилцөх

Зааврыг эцэслэн боловсруулах явцад, сайдын тушаалаар батлуулан албажуулах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Эрүүл мэндийн яаманд танилцуулан, зааврын хэрэгцээ шаардлагыг тайлбарласан.

Үүний үр дүнд, уг заавар 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/304, А/699, А/460 тоот Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Заавар, маягт батлах тухай” тушаалаар батлагдсан. Ингээд уг зааврыг хэрэгжүүлэх аргачлалыг тусгасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага”-ыг боловсруулж 21 аймаг, 9 дүүргийн Салбар комисс зэрэг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Цаашид уг гарын авлага хамтарсан тушаалд тодорхой заасанчлан хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болгох, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл болох юм.

Хүснэгт 13 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлагын бүтэц

Товчилсон үгийн тайлбар Удиртгал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал
Нэг. Нийтлэг зүйл 1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх дэлхий дахины чиг хандлага 1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар Монгол Улсын төр, засгаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, санаачлага 1.3 Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байдал
Хоёр. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд бага насанд нь хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо 2.1 Хөгжлийн дэмжлэг, эрт оролцоонд хамруулах үйл явц 2.2 Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэлт 2.3 Оношилгоо ба үнэлгээ 2.4 Хөгжлийн дэмжлэгт хамруулах асуудлыг шийдвэрлэх 2.5 Хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээ 2.6 Боловсролын үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх 2.7 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэх үйл явц
Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс 3.1 Комиссын үйл ажиллагаа 3.2 Салбар комисс 3.3 Салбар комиссын үйл ажиллагаа

1-3-2-2 Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх

(а) Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, (б) Хөгжлийн үнэлгээ хийх, (в) Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах, (г) Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэхтэй холбоотойгоор Төсөл хэрэгжихийн өмнө, төслийн оролцоо болон төслийн үр дүнгийн талаар тэмдэглэв.

а) Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхыг бэхжүүлэв

Анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох Өрхийн эрүүл мэндийн төв[5] (Цаашид ӨЭМТ гэх) нь эх хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд хүүхэд, түүний гэр бүлд хамгийн ойрхон эрүүл мэндийн байгууллага байдаг. Төслийн хүрээнд, ӨЭМТ-үүдийг түшиглэн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд анхаарсан. Тодорхой дурдвал, Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн (цаашид ЭХЭМД гэх) ашиглалтыг сайжруулах болон 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг (цаашид Эрүүл мэндийн үзлэг гэх) нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхыг бэхжүүлсэн. Энд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв болон 23 хорооны ӨЭМТ-үүд, мөн Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар болон аймгийн төвийн 5 ӨЭМТ, 23 СЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан.

ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулав (2015.05 сараас)

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэг, үйлчилгээнд холбох хэрэглэгдэхүүнд, төсөл эхлэх үед үндэсний хэмжээнд хэдийнээ ашиглаж эхэлсэн ЭХЭМД-ийг ашиглахаар тогтсон. ЭХЭМД-ийг Япон улсын хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн үндэсний төвийн шинйлэх ухааны судалгааны тусламжийн үйл ажиллагааны хүрээнд 2007-2009 онд Булган аймагт анх туршин нэвтрүүлсэн.

“Төсөл хэрэгжихийн өмнө”

Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэгт ЭХЭМД-ийг ашиглахад ямар асуудал тулгамдаж байгааг судлахын тулд, 2016 оны 05 дугаар сард Баянгол дүүргийн Салбар комисс болон тус дүүргийн Эрүүл мэндийн төв, ӨЭМТ-үүдэд ЭХЭМД-ийн сургалт зохион байгуулсан. ЭХЭМД-т хүүхдийн хөгжлийн үзүүлэлт байдаг боловч, асран хамгаалагч нь энэ хэсгийг бөглөсөн эсэхийг ӨЭМТ-ийн эмч асуух төдийхнөөр, хөгжлийн хоцрогдолтой эсэх, хоцрогдол илэрсэн ч авах арга хэмжээ нь хангалтгүй гэдэг асуудал байгааг мэдсэн. Мөн 2016 оны 07 дугаар сард Баянгол дүүрэг дэх ЭХЭМД-ийн ашиглалтын байдлыг тандах судалгаа хийсэн. Уг судалгааны дүнд ӨЭМТ-ийн өрхийн эмч нар болон асран хамгаалагчид хүүхдийн сэтгэц, бие махбодын хөгжлийг шалгах хуудсыг хангалттай түвшинд ашиглахгүй байгаа нь харагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх хэмжээнд хүрээгүйг ойлгосон.

2017 оны 03 дугаар сард Хөвсгөл аймгийн эмнэлгийн ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулж, 2017 оны 09 дүгээр сард ЭХЭМД-ийн ашиглалтын байдалд

[5] Хороо бүрт нэг ӨЭМТ-тэй.

судалгаа хийхэд мөн ижил үр дүн гарсан.

“Төслийн оролцоо”

Дээр дурдсан нөхцөл байдлаас улбаалан төслийн хүрээнд ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах сургагч багш бэлтгэхээр төлөвлөн 2018 оны 02 дугаар сард 3 өдрийн сургалт зохион байгуулсан. Уг сургалтад Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт чухал чиг үүрэг бүхий 14 эмнэлгийн ажилтныг хамруулсан. Сургалтад хамрагдсаны дараа эдгээр хүмүүс өөрсдийн аймаг, дүүрэгтээ ӨЭМТ-ийн эмч, сувилагчдад зориулан сургалт хийж, явуулын сургалтаар дамжуулан анхан шатанд ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулсан.

Мөн дээр дурдсан үйл ажиллагаанд үндэслэн, өрхийн эмч нар зэрэг холбогдох мэргэжилтнүүд ашиглах боломжтой “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглах гарын авлага” боловсруулсан. Уг гарын авлагад ЭХЭМД-ийн үзүүлэлтүүдийн агуулга, шалгах дараалыг дэлгэрэнгүй тусгасны зэрэгцээ нас бүрээр хөгжлийн үзүүлэлт, үнэлэх аргачлал, хүүхэд хөгжүүлэх аргын талаар асран хамгаалагчдад өгөх зөвлөгөөний агуулгыг ойлгомжтой тайлбарласан.

“Төслийн үр дүн”

Сургагч бэлтгэх сургалт болон “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглах гарын авлага”-ыг ашиглах болсноор ӨЭМТ, асран хамгаалагчдын ЭХЭМД-ийг ашиглах байдал нь сайжирч, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлдэг болох юм.

<u>18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг нэвтрүүлэв (2017.05 сараас)</u>

“Төсөл хэрэгжихийн өмнө”

Монгол Улсад хүүхдийг товлолын дагуу дархлаажуултын үндэснмй ад хамруулдаг тогтолцоотой боловч эрүүл мэнд, хөгжлийн товлолт үзлэг хийдэг тогтолцоо байгаагүй. Тиймээс аливаа өвчин эмгэг, хөгжлийн бэрхшээл, хоцрогдолыг эрт үед нь илрүүлэх байдал хангалтгүй байсан.

“Төслийн оролцоо”

Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг хөгжлийн дэмжлэгтэй холбож өгдөг Япон улсын туршлагад тулгуурлан, 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг шинээр нэвтрүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн.

Ингээд Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго болон үзлэг хийх аргачлалын талаар заах 5 өдрийн урьдчилсан сургалтыг зохион байгуулж, Баянгол дүүрэгт 2017 оны 05 дугаар сард, Хөвсгөл аймагт тухайн жилийн 10 дугаар сараас эрүүл мэндийн үзлэг хийж эхэлсэн. Эрүүл мэндийн үзлэгт ашиглах үзлэгийн маягтыг төслийн баг болон Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв хамтран боловсруулсан бөгөөд туршилтын журмаар хийсэн үзлэг болон сургалтаар дамжуулан засварлан сайжруулах ажлыг хийж, эцэслэн боловсруулсан.

2018 оны 10 дугаар сард эрүүл мэндийн үзлэгийн чанарыг хадгалах зорилгоор, өмнө дурдсан ЭХЭМД ашиглалтын сургагч багш бэлтгэх сургалтын дараах нэмэлт сургалт

болгож 3 өдрийн “18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн сургагч бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулсан. Уг сургалтад Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагтаа чухал үүрэг бүхий нийт 13 эрүүл мэндийн эмч, мэргэжилтэн (Баянгол дүүргээс 7 хүн, Хөвсгөл аймгаас 6 хүн) оролцсон бөгөөд эдгээр оролцогчид ӨЭМТ-д явуулын сургалт хийх аргачлалд суралцсан.

Түүнчлэн эрүүл мэндийн үзлэг хийх туршилтын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн хөгжилтэй холбоотой өрхийн эмч нарын өгөх зөвлөмжийн агуулгад асуудал байгаа нь харагдсан тул, хөгжлийг шалгах үзүүлэлтийн агуулга болон үнэлэх аргачлал, зөвлөгөөний талаар тайлбарласан “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага”-ыг боловсруулж, үндэсний хэмжээний бүх ӨЭМТ-үүдэд хүргүүлсэн.

“Төслийн үр дүн”

Одоо Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт эрүүл мэндийн үзлэг сар бүр тасралтгүй хийгдэж байна. Анх эхлүүлсэн цагаас 2019 оны 02 дугаар сар хүртэлх хугацааны дундаж хамралт Баянгол дүүрэгт 75.7%, Хөвсгөл аймагт 73.1% байна. Эрүүл мэндийн үзлэгийг нэвтрүүлснээр, туршилтын аймаг, дүүргийн бүх хүүхэд 18 сартайдаа эрүүл мэнд, хөгжлийн үзлэгт хамрагдах болж, өвчин эмгэг болон хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх боломжтой болсон.

“18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн сургагч бэлтгэх сургалт” болон “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага”-аар дамжуулан эмнэлгийн ажилтнууд хүүхдийн хөгжлийн талаар шинэ мэдлэгт суралцан, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх нь бэхэжсэн гэж болно.

Түүнчлэн 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг нь 2017 оны 12 дугаар сард батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төдийгүй, Эрүүл мэндийн сайд Нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төв болон 21 аймгийн Эрүүл мэндийн газарт хандан тушаал гаргаж хэрэгжүүлэхээр болсон.

<u>Бусад</u>

ЭХЭМД болон эрүүл мэндийн үзлэгийг хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэгт холбохын тулд эрүүл мэндийн эмч, мэргэжилтнүүд болон асран хамгаалагчид бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээлийн талаар зөв мэдлэгтэй байх шаардлагатай юм. Төслийн хүрээнд, 2016 оны 10 дугаар сард “Бага насны хүүхдийн хэвийн хөгжил”, “Дауны хам шинжийн эрт илрүүлэг ба ойлголт”, “Аутизмын хүрээний эмгэгийн эрт илрүүлэг ба ойлголт” сэдэвт видео сургалтын хэрэглэгдэхүүнийг тайлбартайгаар бэлтгэн гаргаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсанд байршуулснаас гадна 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн талаарх видео танилцуулгыг боловсруулсан. Эдгээрийг эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт төдийгүй, төслийн хүрээнд зохион байгуулсан төрөл бүрийн сургалтуудад ашигласан болно.

б) Хөгжлийн үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэв

“Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэх болон “Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийн Монгол хувилбар боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулж, хөгжлийн үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажилласан.

“Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэв (2015.08 сараас)

“Төсөл хэрэгжихийн өмнө”

Өмнө дурдсанчлан, төсөл хэрэгжүүлж эхлэх тухайн үед Монголд өмнө нь ашиглаж ирсэн сэтгэл зүй, хөгжлийн сорил байгаа эсэх, мөн хэрхэн ашиглаж байсан талаар мэдээлэл цуглуулсны үр дүнд, сэтгэл зүй, хөгжлийн жишиг сорил байгаагүй бөгөөд хөгжлийн хоцрогдол, зан үйлийн асуудалтай хүүхдийг бодитоор илрүүлэх боломжгүй байсныг олж мэдсэн.

“Төслийн оролцоо”

Төслийн хүрээнд, ашиглахад хялбар эсэх болон зохиогчийн эрх авах боломжтой эсэх зэргийг нь харгалзан, Монгол хувилбар боловсруулах боломж өндөртэй сэтгэл зүй, хөгжлийн сорилын талаар судалж үзсэн. Яг энэ үед, Монгол Улсын Боловсролын их сургууль болон Японы Нагояа их сургууль сэтгэл зүй, хөгжлийн сорилтэй холбоотой хамтарсан судалгаа хийж байсан бөгөөд “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулах талаар судалж байсан учир уг үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэхээр болсон. Тухайлбал, дараах дэмжлэг туслалцааг үзүүлсэн болно.

- Сорилын хэрэглэгдэхүүнд багтах “Сорилын заавар”, “Оноо дүгнэх заавар”, “Онолын заавар” зэрэг 3 төрлийн гарын авлага болон тоглоом хэрэгсэл, тэмдэглэл хөтлөх хуудас зэргээс “Сорилын заавар”-ыг Япон хэлнээс Монгол хэлэнд хөрвүүлэх, Монгол хэлнээс Япон хэлэнд буцаан хөрвүүлэх, сорилд ашиглагдах зургийг зурж бэлтгэх зэрэг ажилд туслалцаа үзүүлсэн.
- Нийт 3 удаагийн сорил судалгаа (Урьдчилсан, бэлтгэл, үндсэн) болон өмнөх сургалтад тус төсөлтэй хамтран ажилладаг мэргэжилтнүүдийг сорил авагч болон тэмдэглэл хөтлөгчөөр[6] урин ажиллуулж сэтгэл зүй, хөгжлийн сорилын талаар тодорхой ойлголт өгөхийн хамт, ирээдүйд сорил авагчаар ажиллах чадварт сургасан. 2018 оны 06 дугаар сард, төсөл бие даасан сургалт зохион байгуулж, “Оюун ухааны сорил ашиглах аргачлал ба үндсэн судалгаанд анхаарах зүйлүүд” сэдэвт лекц болон сорилын дадлагыг зохион байгуулсан. Сорил судалгаа, сургалтын хэрэгжилтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

[6] Японд, сорил авагч нь сорил өгөгчийн хариултыг өөрөө тэмдэглэдэг. Харин энэ судалгаан, сорилыг алдаа мадаггүй, зөв авах үүднээс тэмдэглэл хөтлөх хүн ажиллуулсан.

Хүснэгт 14 “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулах сорил судалгаа, сургалтын хэрэгжилт

д/д	Цаг хугацаа	Судалгаа, сургалт	Тайлбар
1	2015.08 сараас	Мэдээлэл цуглуулах ажил, тандалт судалгаа	Өмнө ашиглаж байсан сэтгэл зүй, хөгжлийн сорил бий эсэх болон хэрхэн ашиглаж байсан талаар мэдээлэл цуглуулах ажил, тандалт судалгаа
2	2016.06 сар	Урьдчилсан судалгааны өмнөх сургалт ба Урьдчилсан судалгаа	• Сорилд хамрагдсан 20 хүүхдийн (нийт 68) сорилыг төсөл хариуцсан • 4 сорил авагч, 3 тэмдэглэл хөтлөгчийг төслөөс оролцуулсан
3	2017.11 сар	Бэлтгэл судалгааны өмнөх сургалт ба Бэлтгэл судалгаа	• Сорилд хамрагдсан 110 хүүхдийн (нийт 320) сорилыг төсөл хариуцсан • 18 сорил авагч, 18 тэмдэглэл хөтлөгчийг төслөөс оролцуулсан
4	2018.06 сар	Төслийн багийн бие даасан сургалт	Үндсэн судалгаанд сорил авагчаар ажиллах хүмүүст зориулсан лекц, сорилын дадлага (Лекцийн сэдэв: Оюун ухааны сорил ашиглах аргачлал ба үндсэн судалгаанд анхаарах зүйлүүд”)
5	2018.10 сар	Үндсэн судалгааны өмнөх сургалт ба Үндсэн судалгаа	• Сорилд хамрагдсан 256 хүүхдийн (нийт 800) сорилыг төсөл хариуцсан • 37 сорил авагч, 39 тэмдэглэл хөтлөгчийг төслөөс оролцуулсан

- Урьдчилсан судалгааны өмнө болон урьдчилсан судалгаа, бэлтгэл судалгааны дараа хийсэн дүн шинжилгээний хариуг үндэслэн МУБИС болон Нагоя их сургуультай хамтран Танака боловсролын хүрээлэнтэй хийсэн уулзалтад оролцож, Монголын ахуй соёл, нийгмийн байдалд тохируулан сорилын даалгаруудыг өөрчлөн засварлахтай холбоотой зөвлөгөөг өгсөн. Японы хувилбарт ашиглагддаг даалгаруудыг Монгол хөрсөнд буулган өөрчилж засварлахдаа, Япон Монгол хоёр ард түмний ахуй соёл, нийгмийн байдлын ялгааг харгалзан тусгасан төдийгүй, даалгаварт тэнцэх магадлалыг ч анхаарч үзсэн. Бэлтгэл судалгаанд хийсэн дүн шинжилгээний хариуг үндэслэн засварласан сорилын даалгаруд, сорилын заавар зэргийг дахин судалж, өөрчлөхтэй холбоотойгоор Нагоя их сургууль, МУБИС, Танака боловсролын хүрээлэнтэй хийсэн хэлэлцүүлгээс дараах төлөв ажиглагдсан.
  - Японтой харьцуулахад, даалгаварт тэнцэх ерөнхий хувь хэмжээ (Жишээлбэл, 4 дэд асуултын хоёроос илүүд зөв хариулсан бол тооцох тохиолдолд, тухайн даалгаварт тэнцсэн сорил өгөгчийн хувь) харьцангуй доогуур байсан.
  - Тухайн наснаасаа дээш насны ангиллын даалгаварт тэнцэх хувь зарим нь доогуур байсан. Ялангуяа, 12-16 насны ангиллын даалгаварт тэнцэх хувь харьцангуй доогуур байсан.
  - Гариг өдөр, баруун зүүн, зүг чигийг асуух даалгаварт тэнцэх хувь доогуур гарч байсан.
  - Тооцоолон бодох төдийгүй, учир шалтгаан болон зүй тогтлыг олох зэргээр тоо бодох, таамаглах төрлийн даалгаруудад тэнцэх хувь доогуур гарч байсан.

- Өгүүлбэртэй бодлого зэрэг цаг зарцуулсан даалгаварт (Сорилын цаг урттай) тэнцэх хувь доогуур гарч байсан.

Эдгээр нь сорилыг авч буй хүн болон сорилд хамтран ажилласан хүүхдээс шалтгаалж байж болох юм. Сорил авагчийн ур чадвар болон чанарын асуудал, нэмэлт асуултыг зөв асуухгүй байх зэрэг нь даалгаварт тэнцэх хувь доогуур гарахад нөлөөлдөг. Мөн Монголын сургуулиуд дахь хичээл сургалтын агуулга, чанар, хүүхдийн хөгжлийн онцлог, ахуй соёл зэрэг хүчин зүйлүүд ч нөлөөлж байж болно. Ерөнхийдөө Монголын сургуулиуд учир шалтгаан, зүй тогтлыг олох чадвараас илүү тооцон бодох, цээжлэх чадварыг чухалчлах хандлагатай байдаг нь ч нөлөөлсөн байх магадлалтай юм. Япон хүүхэдтэй харьцуулахад, анхаарлаа удаан төвлөрүүлэх чадвар болон нягт нямбай байдал тааруу гэсэн үр дүн гарсан.

“Төслийн үр дүн”

Төслийн хүрээнд, нийт 37 сорил авагч, 39 тэмдэглэл хөтлөгчийг бэлтгэсэн (Оролцогчдын нэрсийг Хавсралт 9-өөс үзнэ үү). Сорил авагчдын дунд хоёр буюу түүнээс дээш удаа судалгаанд оролцож туршлагажсан 16 хүн (Нийслэлээс 14, Хөвсгөл аймгаас 2), үүнээс 3 удаа оролцсон 2 хүн (Хоёулаа Нийслэлээс) байна. Судалгаанд оролцогчид сорилын оноо дүгнэх болон хөгжлийн үнэлгээ хийх, зөвлөгөө өгөх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх зэрэг агуулгад суралцаагүй боловч, 1-13 насны ангиллын нийт 96 даалгавар болон туслах даалгавруудыг сорилын зааврын дагуу гүйцэтгүүлэх чадварыг эзэмшсэн. Тэмдэглэл хөтлөгчөөр ажилласан хүмүүс ч уг оюун ухааны сорилд суралцан сэтгэл зүй, хөгжлийн сорилын талаарх мэдлэг, ойлголтоо дээшлүүлсэн.

Ирээдүйд эдгээр хүмүүс сэтгэл зүй, хөгжлийн сорилд сорил авагчаар ажиллах бүрэн боломжтой.

“Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийн Монгол хувилбарыг боловсруулав (2016.08 сараас)

“Төсөл хэрэгжихийн өмнө”

Төсөл хэрэгжиж эхэлмэгцээ мэдээлэл цуглуулах ажилд ханцуй шамлан орж, Монгол Улсад хөгжлийн дэмжлэг үзүүлэх боломжтой байгууллага болон хэрэглэгдэхүүн цөөхөн байдаг, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх нөхцөл боломж дутагдалтай байдгийг тогтоосон.

“Төслийн оролцоо”

Дээрх байдлыг үндэслэн, хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор асран хамгаалагч нь гэр орондоо, өдөр тутамд хүүхдээ хөгжүүлэх боломжтой “Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийг (цаашид Портеж хөтөлбөр гэх) Монголд танилцуулан нэвтрүүлэхээр тогтсон. Ингээд 2017 оны 07 дугаар сард, Портеж хөтөлбөрийг Монголд ашиглахтай холбогдуулан Японы Портеж нийгэмлэгээс зөвшөөрөл авсан. Тодорхой зүйлийг дор тайлбарлав.

- Уг хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнийг Монгол хэлэнд хөрвүүлсний дараа Монголын ахуй соёл болон нийгмийн байдлыг харгалзан бага насны хүүхэдтэй

эмэгтэйчүүдээс саналыг нь сонсож, хөгжлийн 6 ай бүхий даалгаврын картын агуулгад нийт 43 (Нялхсын хөгжлийн 4 даалгавар, нийгэмшихүйн 14 даалгавар, хэл ярианы 10 даалгавар, бие дааж хийх үйлдлийн 4 даалгавар, танин мэдэхүйн 10 даалгавар, хөдөлгөөний 1 даалгавар) өөрчлөлтийг оруулсан. Энд дараах өөрчлөлтүүдийг оруулсан болно..

- Асран хамгаалагчдад ойлгомжтой болгохын тулд хэл найруулгыг засах
- Ашиглах зүйлсийг Монголын нөхцөлд тохируулан өөрчлөх (Жишээ: Япон дуу болон тоглоомыг Монгол дуу, тоглоомоор солих, Японы “Баатрын дүрд хувирдаг” тоглоомыг “Телевизийн одыг дуурайх” тоглоом болгож өөрчлөх)
- Япон хэл болон Монгол хэлний хэл найруулгын ялгаатай холбоотой өөрчлөлт (Жишээ: Япон хэлний “Жаахан хүүхдийн хэл” гэдэг нэр томъёо Монгол хэлэнд байдаггүй)

- 2016 оны 09 дүгээр сараас, Монголын Аутизмын холбоо ТББ болон Монголын Дауны холбоо ТББ-ын дэмжлэгтэйгээр нийт 9 гэр бүлд дэмжлэг, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Хагас жилийн хугацаанд зохион байгуулсан дэмжлэг, зөвлөгөөний үр дүнд, асран хамгаалагч болон хүүхдэд Портеж хөтөлбөр үр өгөөжтэй гэдэг нь харагдсан. Туршилтын үйл ажиллагааны үр дүнг үндэслэн холбогдох хүмүүс, мэргэжилтнүүдтэй харилцан зөвшилцөж, хөтөлбөрийг Монгол хөрсөнд буулгах ажлыг зохион байгуулсан.
- 2017 оны 08 дугаар сард, Японы Портеж нийгэмлэгийн 2 мэргэжилтэн Портеж хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх анхны сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг сургалтыг 2018 оны 08 дугаар сард 2 дахь удаагаа зохион байгуулсан.
- 2017 оны 12 дугаар сар болон 2018 оны 03, 12 дугаар сард, 1) Портеж хөтөлбөрийн туршлага, хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийх, 2) Хэрэгжүүлж буй байгууллагууд хоорондоо туршлага солилцох замаар үйл ажиллагаагаа улам сайжруулах, харилцан суралцах боломж бий болгох, Портеж хөтөлбөрийн чанарыг дээшлүүлэх, 3) Хэрэгжүүлж буй байгууллагууд хоорондын уялдаа холбоо, сүлжээг бэхжүүлэх зорилгоор, Портеж хөтөлбөрийн туршлага солилцох семинарыг зохион байгуулсан. Оролцогчид “Мэргэжилтэн бэлтгэх сургалтаар заалгасан ч, заримыг нь дутуу ойлгосон, эсвэл ор тас мартчихсан байдаг тул тэдгээрийг дахин тодруулж, эсвэл эргэж санадаг. Мөн туршлага солилцох семинарт бэлтгэх зорилгоор зөвлөгөө өгөх өдөр тутмын үйл ажиллагаандаа дүгнэлт хийх, нэгтгэх зэргээр үйл ажиллагаагаа цэгцтэй болгож, тулгамдсан асуудал болон сайжруулах зүйлүүдээ анзаарч ойлгон шинэ санаа олж авдаг” зэргээр сэтгэгдлээ хэлсэн.

Хүснэгт 15 Портеж хөтөлбөрийн Монгол хувилбар боловсруулах үйл ажиллагааны явц

д/д	Цаг хугацаа	Үйл ажиллагааны агуулга
1	2016.06-2016.09 сар	Портеж хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнийг Монгол хэлэнд хөрвүүлэх, Монгол хөрсөнд буулгаж өөрчлөх үйл ажиллагаа
2	2016.09-2017.03 сар	Монголын Аутизмын холбоо ТББ болон Монголын Дауны холбоо ТББ-д туршилтын журмаар дэмжлэг, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
3	2017.08 сар	Портеж хөтөлбөрийн багш бэлтгэх эхний сургалт
4	2017.12 сар	Портеж хөтөлбөрийн туршлага солилцох эхний семинар
5	2018.03 сар	Портеж хөтөлбөрийн туршлага солилцох 2 дахь удаагийн семинар
6	2018.08 сар	Портеж хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх 2 дахь удаагийн сургалт
7	2018.12 сар	Портеж хөтөлбөрийн туршлага солилцох 3 дахь удаагийн семинар

“Төслийн үр дүн”

Энэ үйл ажиллагаагаар дамжуулан, Портеж хөтөлбөрийн Монгол хувилбарыг боловсруулан, 78 хүнийг Портеж хөтөлбөрийн багшаар бэлтгэсэн (Хавсралт 10-ийг үзнэ үү). Сургалтад оролцогчид, одоо тус тусын байгууллагадаа Портеж хөтөлбөрийг туршин зохион байгуулж байна. 2019 оны 03 дугаар сарын байдлаар Нийслэлд 14 байгууллага, Хөвсгөл аймагт 10 байгууллага буюу нийт 24 байгууллага Портеж хөтөлбөрийг туршиж байгаа бөгөөд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүлд хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх боломж өргөжсөн гэж болно.

Одоо Портеж хөтөлбөрийг ашиглаж буй байгууллагууд Монголын Портеж нийгэмлэг гэсэн нэртэй ТББ байгуулахаар бэлтгэлээ хангаж байна.

в) Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлэв

Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлэхийн тулд, Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймгийн Салбар комисстой хамтран Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулсан.

<u>Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулав (2017.09 сараас)</u>

“Төсөл хэрэгжихийн өмнө”

Монголд өнөөг хүртэлх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэмжлэг нь эрүүл мэнд, халамжийн үйлчилгээгээр хязгаарлагддаг гэдэг асуудал байсан. Тиймээс 2013 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс байгуулагдаж, 2014 оны 06 дугаар сард Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт Салбар комиссууд байгуулагдсан. Комисс байгуулсан зорилго нь, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуульд хамрагдалтыг дээшлүүлэх явдал байв. Салбар комисс нь боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдээс бүрддэг бөгөөд цогц байдлаар хөгжлийн дэмжлэгийн зөвлөгөө өгөх чиг үүргийг хүлээсэн. Харин төсөл хэрэгжиж эхлэх тухайн үед Салбар комисс дөнгөж байгуулагдаад удаагүй байсан ба цогц хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулж чадахгүй байсан.

“Төслийн оролцоо”

Дээрх нөхцөл байдлаас улбаалан төслийн хүрээнд, Салбар комиссыг цогц хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулж сургах тулд чадавхыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулсан. Дэлгэрэнгүй дурдвал, 2017 оны 09 дүгээр сараас хойш, дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй байгаа хүүхдийг сонгон, ДЭМБ-аас баталсан “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)”-д суурилан хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах “Кэйс хэлэлцүүлэг”-ийг Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймгийн Салбар комисстой хамтран зохион байгуулсан (Тус бүр 7 удаа).

ICF-ийг ашиглах болсон шалтгаан нь уг хэрэглэгдэхүүн нь хүүхдийг тойрсон орчин нөхцлийг цогцоор нь судалж мэдсэний үндсэн дээр ашигтай бөгөөд ICF-ийн зарчимд суурилан олон мэргэжлийн багаар хэлэлцүүлэхэд хялбар болдог явдал юм. Кэйс хэлэлцүүлэгт Салбар комиссын гишүүдээс гадна, хариуцсан өрхийн эмч зэрэг хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг судлан боловсруулахад чухал хүмүүсийг нэг дор цуглуулсан. Нэг удаа хуралдахад ойролцоогоор 3 цаг шаардлагатай болдог бөгөөд гол үйл явцыг доор үзүүлэв.

Хүснэгт 16 Кэйс хэлэлцүүлгийн үйл явц

1. Тухайн кэйсийг хариуцсан мэргэжилтэн нь өмнөх хурлаар авч хэлэлцсэн хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлж буй явц, байдлыг тайлагнах.
2. Шинэ кэйсийн талаарх мэдээллийг танилцуулах. (Мэдээллийг урьдчилан бэлтгэсэн байх)
   ※ Нөхцөл байдлаас хамаарч, асран хамгаалагч болон хүүхдийг хуралд оролцуулж, тодруулах зүйлүүдээ асуух тохиолдол ч гарч болно.
3. ICF-д суурилсан хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах.
4. Дэмжлэг үзүүлэх аливаа үйл ажиллагаа хариуцсан хүмүүс болон төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд авах арга хэмжээний талаар хэлэлцэх.

Дараах Бүдүүвч, зурагт, кэйс хэлэлцүүлгээр дэмжлэг үзүүлэх үйл явцыг дүрслэн үзүүлэв.



Бүдүүвч, зураг 1 Кэйс хэлэлцүүлгээр дэмжлэг үзүүлэх үйл явц

Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулахдаа “Цэцэрлэгт явдаг болно”, “Гэрийнхэнтэйгээ хамт дэлгүүр явж сурна” гэх мэтчилэн “Оролцоо, үйл ажиллагаа”-г зорилт болгон дэвшүүлэх, тэр зорилтыг биелүүлэхэд шаардлагатай зүйлүүдээ судалдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэгт, өмнө нь бие махбод болон сэтгэцийн үйл ажиллагааг нь сэргээн сайжруулахад л гол анхаарлаа хандуулдаг байсан бол, “Оролцоо, үйл ажиллагаа”-г зорилт болгон дэвшүүлсний үндсэн дээр эрүүл мэндийн асуудал руу нь хэт хазайлгүйгээр үзүүлж болох хөгжлийн дэмжлэгийг судалж тогтоох гэдэг нь Салбар комиссын гишүүдийн хувьд амаргүй байв. Олон удаагийн дадлага ажлаар дамжуулан аажим аажмаар ойлголтыг дээшлүүлж ирсэн бөгөөд тус төсөл дуусах ойртох тусам “Оролцоо, үйл ажиллагаа”-г зорилт болгосон хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулж сурсан. Салбар комиссын боловсруулсан хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний жишээг энд үзүүлэв.

Боловсруулсан: 2018.08 сар

Нэр	М	Хүүхдийн хүсэл	Гэрийнхэнтэйгээ хамт дэлгүүр явдаг болох.
Нас	5 нас 1 сартай	Асран хамгаалагчийн хүсэл	Бусад хүүхдийн адилаар өсгөж бойжуулах. Өөрийгөө илэрхийлдэг болгох.
Хүйс	Эр		

Жилийн дараа хүрэх зорилт	Сургуульд явдаг болгох

	Жилийн дараах зорилтоо биелүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудал ба хэрэгцээ шаардлага	Дэмжлэгийн зорилт	Хүрэх цаг үе, хугацаа	Дэмжлэгийн агуулга (Давтамж, хугацаа)	Хариуцах байгууллага, мэргэжилтэн
1	Өөрийнхөө санаа бодол, хүсэж буй зүйлээ хэлж чаддаггүй.	Өдөр тутмын амьдралд ойр зуурын дохионы хэлээр ашиглаж сургах.	2019.06 сар	Долоо хоногт 1 удаа дохионы хэлний хичээлд суулгах.	Салбар комиссын боловсролын мэргэжилтэн, Тусгай сургууль
2	Тэргэнцэрийнх нь хэмжээ тохиромжгүй.	Өөрт нь тохирсон тэргэнцэртэй болгох.	2018.10 сар	Сэргээн засалтын төвийн шугамаар тэргэнцэр олгох.	Салбар комиссын халамжийн мэргэжилтэн, Сэргээн засалтын төв
3	Орцны шат нь налуу замгүй тул гадаа гарахад хэцүү байдаг.	Орцных нь шатанд налуу хийж өгөх.	2018.11 сар	Сум, баг, хорооны туслалцааг авч, налуу замтай болгох.	Салбар комисс, Сум, баг, хороо
4	Сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээж авахаас зайлсхийх хандлагатай.	Элсэх сургуулийнх нь захирал, сургалтын менежерийг М хүүгийн талаар ойлголттой болгох.	2019.07 сар	• Салбар комиссын гишүүн, цэцэрлэгийн багштай хамт М хүүг сургуульд хамруулах асуудлаар сургуультай нь уулзаж мэдээлэл өгөх. • М хүү болон асран хамгаалагчийг нь сургуультай танилцуулах	Салбар комиссын боловсролын мэргэжилтэн, цэцэрлэг, сургууль

Бүдүүвч, зураг 2 Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний жишээ (Зарим хэсгийг товчлов)

“Төслийн үр дүн”

Кэйс хэлэлцүүлэг хийх эхний үед тус төслийн мэргэжилтэн чиглүүлэгчээр ажиллаж, ICF-ийн зарчим болон хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тайлбарлахад ихэнх цагийг зарцуулж байсан бол төсөл дуусах дөхөх тусам Салбар комиссын гишүүд бие даан кэйс хэлэлцүүлэгт бэлтгэн зохион байгуулах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх ажлынхаа хэрэгжилтэд хяналт тавьж сурсан. Мөн улирал бүр зохион байгуулахыг хоёр Салбар комисс үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгасан байснаас харахад кэйс хэлэлцүүлгийг хэвшил болгосон гэж болохоор байна.

Кэйс хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулснаар дэмжлэг үзүүлэх үйл явц, аргачлал нь улам тодорхой, цэгцтэй болсон. Анх “Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг хэн хариуцаж хэрэгжүүлэх вэ” гэдэг асуудал байсан боловч, Салбар комиссын зааврыг үндэслэн баг, хорооны түвшинд янз бүрийн мэргэжилтнүүд уялдаатай ажиллаж, найдвартай дэмжлэг үзүүлж чаддаг болсон жишээ олон байлаа. Жишээлбэл, “Байрных

нь орц, үүдэнд налуу зам тавина” гэсэн төлөвлөгөөний дагуу ойр хавийн оршин суугчдын туслалцааг авах, багийн нийгмийн ажилтантай хамтран сургуульд хамруулах бэлтгэлийг хангах зэргээр ажиллах болсон. Улмаар ээлжит хуралдааны үед гишүүд ICF-ийн загварыг ашиглан хүүхдийн нөхцөл байдлыг цогцоор нь үнэлэн, олон мэргэжлийн хүмүүс уялдаа холбоотой ажиллан, хөгжлийн дэмжлэг үзүүлдэг болсон нь ч төслийн нэг үр дүн юм.

г) Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэв

Төсөл хэрэгжиж эхлэх үед Монголд хөгжлийн дэмжлэг гэдэг утгаар нь үзүүлж чадах дэмжлэг хомс, мөн гол төлөв Нийслэлд ТББ-ууд зарим дэмжлэгийг үзүүлдэг зэрэг нөхцөл байдалтай байв. Төслийн хүрээнд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүл оршин суугаа газартаа эрт үеийн хөгжлийн дэмжлэг авах боломжтой болгохын тулд 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн дараах нэмэлт үйл ажиллагаа болгож “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”, “Цэцэрлэгт тэгш хамруулалтыг дээшлүүлэх сургалт”, “Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийг нэвтрүүлсэн. “Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийн талаар өмнө дурдсан.

<u>Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэв (2017.10 сараас)</u>

“Төсөл хэрэгжихийн өмнө”

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны талаар судлах явцад, бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн дараах дэмжлэг шаардлагатай эцэг эх, хүүхдүүдийг зөвхөн дараагийн шатны эмнэлэгт танилцуулах бус хөгжүүлэх зорилгоор дэмжих үзүүлэх, цэцэрлэг сургуульд хамруулахын тулд “Холбон зуучлах дэмжлэг” үзүүлэх шаардлага байгаа нь харагдсан.

“Төслийн оролцоо”

Дээрх байдлыг харгалзан Японы жишээ туршлагаас санаа авч, эрүүл мэндийн үзлэгээр хөгжлийн хоцрогдол, бэрхшээл илэрсэн хүүхдүүдэд зориулан туршилтын аймаг, дүүрэгт “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг туршин зохион байгуулсан.

“Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийн зорилго нь 1) Хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг, 2) Гэр бүлд үзүүлэх дэмжлэг, 3) Холбон зуучлах дэмжлэг юм. “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр” нь хүүхдийн бага насанд чухал мэдрэхүй, бие махбодын хөдөлгөөн, эх хүүхдийн харилцааг дэмжих гарын хөдөлгөөнтэй дуу, цаасаар тоглох тоглоом, эх хүүхэд хамт тоглох тоглоом, хөдөлгөөнт тоглоом зэргээс бүрддэг бөгөөд сард 1 удаа (90 орчим минут) буюу нийт 1 ээлжинд 6 зохион байгуулагдана.

Туршилтын аймаг, дүүргийн Салбар комисстой хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөлдсөний дараа тусгай цэцэрлэгийн багш нартай уулзаж хөтөлбөрийн агуулгын талаар ярилцсан. Ингээд уг багш нартай хамтран төслийн мэргэжилтэн уг хөтөлбөрийн багш нарыг бэлтгэхийн сацуу шаардлагатай тоглоом хэрэгслүүдээр хангаснаар, Салбар комисс хөтөлбөрийг гардан хэрэгжүүлсэн. Хэрэгжүүлсэн байдлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 17 Баянгол дүүрэгт Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн байдал

Гол хэрэгжүүлэгч	Салбар комисс болон дүүргийн Эрүүл мэндийн төв
Хэрэгжүүлсэн газар	8-р хорооны байр Ахмад настан, хүүхдийн эмнэлэг
Багш	3 багш Дүүргийн ЗДТГ-ын сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон ДЭМТ-ийн хөдөлгөөн засалч
Эхний ээлж	Хэрэгжүүлсэн хугацаа: 2017.10-2018.03 (Нийт 6 удаа)
	Зорилтот хүүхэд: 2017.05-08 сарын ЭМҮ-д хамрагдсан хүүхдүүдээс хөгжлийн бэрхшээлтэй гэж оношлогдсон хүүхдүүд (Жишээ: Дауны хам шинж) болон “Хөлд ороогүй” хүүхдийг сонгож авсан. 15 хүүхэд байснаас (Үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 1.7% орчим), үүнээс 9 гэр бүл тогтмол хамрагдсан.
Хоёр дахь ээлж	Хэрэгжүүлсэн хугацаа: 2018.03-09 сар (Нийт 6 удаа, 07 дугаар сард завсарласан)
	Зорилтот хүүхэд: 2017.09-2018.02 сарын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс хөгжлийн бэрхшээлтэй гэж оношлогдсон хүүхдээс гадна, хэлд ороогүй, хүний нүд рүү хардаггүй гэсэн оноштой хүүхдүүдийг сонгосон. 31 хүн байснаас (Үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 2.4%), үүнээс 15 гэр бүл тогтмол оролцсон.

Хүснэгт 18 Хөвсгөл аймагт Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн байдал

Гол хэрэгжүүлэгч	Салбар комисс (Салбар комиссын удирдлагаар Эрүүл мэндийн газар болон зарим цэцэрлэгүүд хамтран хэрэгжүүлсэн)
Хэрэгжүүлсэн газар	Нийт 5 газар: Аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх сургалтын төв, 4-р цэцэрлэг, 10-р цэцэрлэг, Тариалан сум, Рэнчинлхүмбэ сум
Багш	Нийт 20 багш (Тус бүр 4 багш) Цэцэрлэгийн багш, өрхийн эмч, сувилагч, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, ХБХЭЭХ-ны багш
Эхний ээлж	Хэрэгжүүлсэн хугацаа: 2018.03-2018.09 (Нийт 6 удаа)
	Зорилтот хүүхэд: 2017.10-2018.02 сарын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдүүдийг сонгосон. 7 хүүхдийг сонгосон (Үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 1%). Мөн эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй ч Салбар комиссын ээлжит хуралдаанд оролцож Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрөөр дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэж үзсэн 4 хүүхэд, нийт 11 хүүхдийн гэр бүлийг хамруулахаар шийдвэрлэсэн. Үүнээс 9 гэр бүл тогтмол оролцсон.
Хоёр дахь ээлж	Хэрэгжүүлсэн хугацаа: 2018.10-2019.03 (Нийт 6 удаа) Зорилтот хүүхэд: 5 газарт 23 хүүхдийг хамруулсан. Мөрөн суманд 3 газар, 2 суманд зохион байгуулсан.

“Төслийн үр дүн”

Баянгол дүүрэгт “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг эхний ээлж (2017.10-2018.03 сар), хоёр дахь ээлж (2018.03-09 сар) болгон зохион байгуулсан. Эхний ээлжинд эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн 15 хүүхдээс 9 хүүхэд ээжийн хамт тогтмол оролцож, хоёр дахь ээлжинд 31 хүүхдээс 15 нь тогтмол оролцсон. 3 багшийг бэлтгэсэн бөгөөд 2 байгууллагад хөтөлбөрийг хэрэгжүүлдэг болсон.

Хөвсгөл аймагт эхний ээлжийг 2018 оны 03 дугаар сараас 09 дүгээр сард зохион

байгуулсан. Хожим нь Салбар комисс “Аймгийнхаа бүх хүүхдийг үр өгөөжийг нь хүртэгч хэмээн үзэж байгаа тул хэрэгжүүлэх газраа 5 (Мөрөн суманд 3 газар болон бусад 2 суманд) болгон өргөжүүлмээр байна” гэсэн хүсэлт гаргасан. Ингээд 2018 оны 08 дугаар сард цэцэрлэгийн багш, ӨЭМТ-ийн эмч мэргэжилтэн зэрэг 18 хүнд зориулан багш бэлтгэх сургалт зохион байгуулсан. Хөвсгөл аймгийн Салбар комиссын удирдлага дор Эрүүл мэндийн газар, ӨЭМТ-үүд, цэцэрлэгүүд уялдаа холбоотой ажиллаж, 2018 оны 10 дугаар сараас хойш нийт 5 газарт тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2019 оны 03 дугаар сард 5 газрын багш нарыг цуглуулан сургалт зохион байгуулж, тус бүр хэрэгжилтийн явцаа тайлагнаж, хөтөлбөрийн үйл ажиллагаагаа сайжруулах болон дэмжлэг үзүүлэх аргачлалынхаа талаар хэлэлцүүлсэн.

Цэцэрлэгт холбон зуучлах дэмжлэгийн тал дээр ч үр дүн гарсан. Хөтөлбөрийн багш нар асран хамгаалагчдаас хүүхдээ цэцэрлэгт хамруулах тухай хүсэлт, сэтгэл зовниж буй асуудлуудыг нь сонсох, мэдээлэл болон зөвлөгөө өгөх, Салбар комисс цэцэрлэгт хамруулах дүгнэлт гаргах зэргээр ихэнх хүүхдүүдээ цэцэрлэгт хамруулж чадсан байна.

Ийнхүү Баянгол дүүрэг, Хөвсгөл аймагт “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн туршлагадаа тулгуурлан төслийн баг “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж”-ийг боловсруулсан. Цаашид бусад аймаг, дүүрэгт “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд уг зөвлөмжийг ашиглах боломжтой болсон.

<u>Сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулан сургах үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн сургалт зохион байгуулав (2018.03 сараас)</u>

“Төсөл хэрэгжихийн өмнө”

“Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9-д “Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно” гэж заажээ. Гэтэл нэг бүлгийн хүүхдийн тоо хэт олон буюу Баянгол дүүрэгт, нэг бүлэгт 50-55 хүүхэд бүртгэгдсэн (Хөвсгөл аймгийн төрийн өмчийн цэцэрлэгүүд, Баянгол дүүрэгтэй харьцуулахад бүлэг бүр 5 орчим хүүхдээр цөөн байна). Харин анги удирдсан 1 багш, туслах 1 багштайгаар ажилладаг. Олон хүүхэдтэй бүлэгт тусгай хэрэгцээтэй хүүхэд нэмж оруулбал хариуцах багшид ихээхэн ачаалал болно.

Ихэнх багш нар, хэл ярианаас үүдсэн харилцааны хүндрэлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, асран хамгаалагчидтай ажиллах арга зүй, бусад байгууллагатай ажлаа уялдуулах тал дээр тулгамдсан асуудлууд ихтэй байсан.

“Төслийн оролцоо”

Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, анги удирдсан багш нарт зориулсан сургалтыг нийт 6 удаа зохион байгуулсан.

Сургалтын агуулгад Салбар комиссын мэдээлэл, сургагч багшийн лекц, асуулт хариултын цаг багтсан. Салбар комиссын зүгээс сургуулийн өмнөх боловсролд тэгш хамрагдалтыг сайжруулах хууль, эрх зүйн тогтолцоо, төрийн өмчийн цэцэрлэгт тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд хүлээн авч буй байдал, Япон дахь сургалтын тайлан, эдгээртэй холбоотой Салбар комиссын үйл ажиллагааны талаарх мэдээллийг

өгсөн. Сургагч багшаар тус төслийн мэргэжилтэн болон төрийн өмчийн 10 болон 186 дугаар тусгай цэцэрлэгийн эрхлэгчид ажиллаж, тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлж буй олон улсын чиг хандлага, бага насны хүүхдийн хөгжил, бие махбодын бэрхшээл, оюуны бэрхшээл болон хөгжлийн хоцрогдолын талаарх ойлголт, тухайн хүүхдийг хүлээн авах арга, асран хамгаалагчтай харилцан итгэлцэл бий болгох арга, Японы сургуулийн өмнөх боловсролын тогтолцоо, тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлж буй Японы цэцэрлэгүүдийн жишээ танилцуулга, Монголын тусгай цэцэрлэгүүд дэх мэргэжлийн арга зүй, аргачлал зэргийн талаар лекц уншсан.

Хүснэгт 19 Цэцэрлэг багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байдал

	Удаа	Цаг хугацаа	Оролцогч	Дэлгэрэнгүй
Баянгол дүүрэг	Эхний	2018.03 сар	56	Төрийн өмчийн цэцэрлэгийн 1 эрхлэгч, 2 арга зүйч, анги удирдсан 29 багш БСШУСЯ, ХНХЯ, ГБХЗХГ, Хөвсгөл аймгийн Салбар комисс, хувийн цэцэрлэг, ТББ-ийн төлөөлөл 24 хүн
	2 дахь	2018.09 сар	58	Төрийн өмчийн цэцэрлэгийн 23 эрхлэгч, 8 арга зүйч, анги удирдсан 18 багш Бусад 9 хүн
	3 дахь	2018.11 сар	50	Төрийн өмчийн цэцэрлэгийн 1 арга зүйч, анги удирдсан 38 багш Хувийн цэцэрлэгээс 4 хүн, бусад 7 хүн
	4 дэх	2019.03 сар	68	Төрийн өмчийн цэцэрлэгийн 59 багш Хувийн цэцэрлэг болон албан бус сургалтын төвөөс 2 хүн, бусад 7 хүн
Хөвсгөл аймаг	Эхний	2018.11 сар	44	Төрийн өмчийн цэцэрлэгийн 1 эрхлэгч, 9 арга зүйч, анги удирдсан 28 багш Хувийн 5 цэцэрлэгээс 6 хүн
	2 дахь	2019.03 сар	119	Төрийн өмчийн цэцэрлэгийн 8 арга зүйч, анги удирдсан 88 багш, бусад 23 хүн

“Төслийн үр дүн”

Сургалтад улсын цэцэрлэгийн нийт 313 багшийг (давхардсан тоогоор) хамруулсан. Тодруулбал 25 эрхлэгч, 28 арга зүйч, 260 анги удирдсан багш 260 хүн байсан. Үүнээс гадна, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн, улсын цэцэрлэгийн эмч, хувийн цэцэрлэгийн багш, улсын сургуулийн эмч, албан бус сургалтын төв, ТББ-аас оролцсон. Эдгээр хүмүүст, тусгай хэрэгцээтэй хүүхэд хүлээн авахад шаардлагатай мэдлэгийг зааж сургасан.

Баянгол дүүрэг дэх эхний сургалтын дараах асуумжийн үр дүнгээс харахад “Сургалтын агуулга нь цэцэрлэгт тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэхэд хэрэгтэй байсан уу” гэсэн асуултад, үр дүнтэй гэж хариулсан 36 хүний 27 нь “Маш хэрэгтэй” гэж хариулсан байсны зэрэгцээ, бусад 9 хүн нь “Хэрэгтэй” гэж хариулжээ. Түүнчлэн “Сургалт маш ойлгомжтой, олон зүйлийг сурч авсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах, сургахад шаардлагатай суурь мэдлэг олж авлаа”, “Сургалтын агуулга

маш үр дүнтэй, сайн байсан. Цаашид ажилдаа ашиглах боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой олон сайн жишээ сонслоо. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах урам зориг, эрмэлзэл дүүрэн сургалт байлаа” гэх зэрэг эерэг санал сэтгэгдлүүдийг ирүүлсэн юм.

Мөн дээр дурдсан “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-тэй холбосон хамтын хүчин чармайлтаар тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт хүлээн авах явдал хэвшил болж эхэлсэн.

Түүнчлэн сургалтаар дамжуулан, тусгай болон ердийн цэцэрлэгийн хооронд сүлжээ бий болж байгаа нь ч төслийн үр дүн гэж болно. Сургагч багшаар ажилласан тусгай цэцэрлэгийн эрхлэгч нартай ердийн цэцэрлэгийн багш нар холбоо тогтоож, утсаар ярих, уулзах зэргээр зөвлөдөг болжээ. Улмаар ердийн болон тусгай цэцэрлэгт зэрэг хамруулах тохиолдол ихсэж байна. Ингэснээр тусгай цэцэрлэгийн багш нар хүүхдээ хамруулсан асран хамгаалагчид зөвлөгөө өгдөг болсон.

<u>Бусад</u>

Монгол Улсад хөгжлийн дэмжлэг үзүүлэх нөөц хязгаарлагдмал байгаа тул төслийн баг цаашид үр дүнтэй гэж үзсэн дараах 2 эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулан гаргасан.

- “Баянгол дүүргийн чухал шаардлагатай байгууллагуудын хаяг, байршлын зураг”

  Монгол Улсад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг, үйлчилгээ хязгаарлагдмал тул тухайн оршин суугаа газрынхаа нөөц бололцоог ашиглах нь чухал юм. Нөгөө талаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүл оршин суугаа газартаа байгаа нөөц бололцооны талаар хангалттай мэдээлэлгүй байгааг тогтоосон. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүлд хэрэгтэй мэдээллүүдийг багтаасан чухал шаардлагатай байгууллагуудын хаяг, байршлын зургийг Баянгол дүүргийн Салбар комисстой хамтран боловсруулсан юм. Чухал шаардлагатай байгууллагуудын хаяг, байршлын зургийг гол нь ээлжит хуралдаанд оролцсон асран хамгаалагчдад тараахаар төлөвлөсөн. Цаашид, Салбар комисс уг чухал шаардлагатай байгууллагуудын хаяг, байршлын зурагаа тогтмол шинэчлэн ашиглах ёстой.

- Аутизмтай хүүхэдтэй асран хамгаалагчдад зориулсан гарын авлага

  Сүүлийн үед, Монгол Улсад аутизм хэмээх нэр томъёо нилээд яригдах болсон ч, аутизмтай хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэгийн талаар хангалттай мэдлэггүй, тэдэнтэй ажиллах тал дээр асуудал бэрхшээлтэй тулгардаг хүмүүс олон байдгийг төслийн үйл ажиллагааны явцад олж мэдсэн юм. Тиймээс төслийн баг Монголын Аутизмын холбоо ТББ-тай хамтран гарын авлага боловсруулах болсон. Уг гарын авлагад, асран хамгаалагчдын сэтгэлийг зовоодог асуудал болон өгөх зөвлөгөө, нийтлэг асуулт хариултуудыг нэг бүрчлэн оруулсан болно. Гарын авлагыг нийт 400 хувь хэвлүүлсэн бөгөөд холбогдох хүмүүст түгээсэн. Ашиглаж буй байгууллага, хүмүүс “Агуулга нь бодитой, мэдээлэл ихтэй учраас ашиглахад үр дүнтэй юм” хэмээн сэтгэгдлээ хэлж байв. Мөн ашиглаж буй байгууллага, хүмүүс цааш нь танилцуулан түгээж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн, мөн тус төслийн Facebook хуудсанд гарын авлага боловсруулсан тухай мэдээллийг нийтлэх зэргээр

сурталчлахад “Худалдаж авмаар байна” гэсэн хүсэлтийг олноор ирүүлсэн тул уг гарын авлагыг Facebook хуудас болон ЖАЙКА-ийн цахим хуудаснаас чөлөөтэй татаж авах боломжтойгоор байршуулсан.

1-3-3 Зорилт 2-ын үйл ажиллагаа

Зорилт 2 : Туршилтын сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өндөр чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ.

Зорилт 2-ын хүрээнд Нийслэлийн 4 тусгай сургууль, хамтран ажиллах ерөнхий боловсролын 8 сургууль (1 дүүрэгт 1 тусгай сургууль, 2 ердийн сургууль) болон Хөвсгөл аймагт 2 ердийн сургуулийг туршилтын сургуулиар сонгон багш, ажилчдын багшлах арга зүй, ур чадварыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авах тогтолцоо бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг явуулсан. a) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах тогтолцоо бүрдүүлэх, b) Тусгай сургуулийн багш нарын ур чадварыг сайжруулах c) Ердийн сургуулийн багш нарын ур чадварыг сайжруулах гэсэн 3 хэсэгт ангилсан.

1-3-3-1 Үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх

a) Мэргэжил арга зүйн баг байгуулав (2015.11)

Тусгай сургуулийн үнэлгээний уламжлалт арга хэрэгслийг өөрчлөх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын үйл ажиллагааг шинэчлэн сайжруулахад чиглэсэн санал дүгнэлт гаргах, сургалт зохион байгуулах ажлын хэсгийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, Хамтарсан зохицуулах зөвлөлийг мэдээллээр хангах үүрэг бүхий Мэргэжил арга зүйн багийн бүрэлдэхүүнийг анх 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын А/443, А/141тоот хамтарсан тушаалаар байгуулсан.

Хүснэгт 20 Мэргэжил арга зүйн багийн гишүүд

д/д	Гишүүдийн нэрс	Байгууллага, албан тушаал
1	Ө.Ганболд	БСШУСЯ, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
2	Г.Амарсанаа	Нийслэлийн боловсролын газрын арга зүйч
3	Ц.Цэвэгмид	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
4	Ч.Жаргал	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
5	Г.Батцэнгэл	МУБИС, Боловсрол судлалын сургуулийн багш
6	Д.Одгэрэл	МУБИС, Багшийн сургуулийн багш
7	Б.Энхцэцэг	Ерөнхий боловсролын 25 дугаар тусгай сургуулийн сургалтын менежер
8	Ц.Саранцацрал	Ерөнхий боловсролын 55 дугаар тусгай сургуулийн сургалтын менежер
9	О.Мөнхцэцэг	Ерөнхий боловсролын 63 дугаар тусгай сургуулийн сургалтын менежер
10	Т.Наранчимэг	Ерөнхий боловсролын 70 дугаар тусгай сургуулийн сургалтын менежер

*Одоогийн байдлаар БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газрын мэргэжилтэн хариуцаж байна.

b) Туршилтын сургуулийг сонгон шалгаруулав. (2015.11, 2016.11)

Төсөл эхэлмэгц оюуны бэрхшээлтэй хүүхэд хүлээн авч боловсролын үйлчилгээ үзүүлдэг 4 тусгай сургуулийг туршилтын сургуулиар сонгон ажиллах саналаа илэрхийлэхэд бүх сургуулиуд зөвшөөрсөн. Харин туршилтын ердийн сургуулийг дараах шалгуураар сонгон шалгаруулсан.

Хүснэгт 21 Нийслэлийн туршилтын ердийн сургуулийг сонгох шалгуур

- Цаашид үйл ажиллагаагаа түгээн дэлгэрүүлэх тул сургуулийн байршлыг харгалзан үзнэ. (Дүүргийн өмнөд, дунд, хойд хэсэг, байшин, гэр хороолол)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авах бодлоготой байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа сургууль
- Багш нарынхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ур чадварыг сайжруулах хүсэлтэй боловч арга зүй дутмаг гэх мэт бэрхшээл тулгараад буй сургууль
- Өөрийн дүүргийн тусгай сургуультай хамтран ажилладаг/ажиллах хүсэлтэй сургууль
- Туршилтын сургуулиар ажиллах сонирхолтой байх (Төсөл хэрэгжүүлэх үндсэн агуулга нь мөнгөн болон эд материалын дэмжлэг үзүүлэх бус сургалт хийх, чадавх бэхжүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд оролцох боломжтой сургууль сонгоно)

Нийслэлийн боловсролын газар болон дүүргийн боловсролын хэлтэс, тусгай сургуулиудаас туршилтын сургуулийн сонгон шалгаруулалтад оролцуулах сургуулийн санал авсны дараа төслөөс боловсролын бодлогын мэрэгжилтний хамт сургуулиудаар (СБД:3 сургууль, БЗД: 5 сургууль, ХУД: 2 сургууль, БГД: 3 сургууль) явж танилцан, сонгон шалгаруулалтын шалгуурыг хангах эсэхийг нягталлаа. Үүний үр дүнд Хамтарсан зохицуулах зөвлөлийн анхдугаар хурлаар дараах 4 тусгай сургууль, 8 ердийн сургуулийг төслийн туршилтын сургуулиар сонгон 2015 оны 11 дүгээр 13-ны өдрийн БСШУЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргын албан бичгээр баталгаажуулсан.

Хүснэгт 22 Нийслэлийн туршилтын сургуулийн нэрс

Дүүрэг	Тусгай сургууль	Ердийн сургууль
Сүхбаатар дүүрэг	25-р тусгай сургууль	Ерөнхий боловсролын 16, 35 дугаар сургууль
Баянзүрх дүүрэг	55-р тусгай сургууль	Ерөнхий боловсролын 79, 111 дүгээр сургууль
Хан-уул дүүрэг	63-р тусгай сургууль	Ерөнхий боловсролын 26, 34 дүгээр сургууль
Баянгол дүүрэг	70-р тусгай сургууль	Ерөнхий боловсролын 28, 113 дугаар сургууль

2016 оны 11 дүгээр сард төслийн аймгаар сонгогдсон Хөвсгөл аймагт туршилтын сургууль сонгон шалгаруулах талаар аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын даргатай зөвшилцөн хамтдаа сургуулиудтай танилцсаны үндсэн дээр “Ирээдүй 21-р зуун” цогцолбор сургууль, “Титэм” 2 дугаар сургуулийг сонгосон. Тус 2 сургуульд өмнө нь НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хөгжлийн төв” байгуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч сургадаг байсан. Төвтэй танилцах үед сургуулийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах арга зүйн талаар сургалт

авах хэрэгцээтэй байгаа, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга зүйд суралцах, судалгаат хичээл зааж үзэх сонирхолтой байгаа тухайгаа илэрхийлсэн зэргийг үндэслэн төслийн туршилтын сургуулиар сонгосон.

c) Ажлын хэсэг байгуулав.

Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах 10 орчим гишүүнтэй ажлын хэсгийг сургууль тус бүр дээр байгуулсан. Ажлын хэсгийг жил бүр захирлын тушаалаар томилж байсан.

Тусгай сургуулиудын ажлын хэсгийн гишүүдийн тоог жил бүрээр доорх хүснэгтэд үзүүлэв. Төслийн эхний жилд социализмын үед хуучнаар Зөвлөлт холбоот улсад согог зүйч мэргэжил эзэмшсэн багш нар ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байсан. Тэдгээр туршлагатай багш нар өөрийн сургуулийн залуу багш нарт заах, төслөөс санал болгож буй мэргэжил арга зүйн дэмжлэгийг ажлын хэсгийн гишүүдтэйгээ хамтран бусад багш нартаа нэвтрүүлэхээр ажилласан. Мөн төслийн хугацаанд тэтгэвэрийн насны гишүүд олон байсан бөгөөд сургалтын менежер, нийгмийн ажилтнаас бусад гишүүд нь өөрчлөгдсөн. Ажлын хэсэгт шинээр МУБИС-ийн 1 жилийн тусгай хэрэгцээт боловсролын багшийн хөрвөх анги төгссөн багш болон ажиллах сонирхолтой залуу багш нар орсон.

Хүснэгт 23 Тусгай сургуулийн ажлын хэсэг

Хичээлийн жил	Сургуулийн ажлын хэсгийн гишүүдийн тоо			
	25-р тусгай сургууль	55-р тусгай сургууль	63-р тусгай сургууль	70-р тусгай сургууль
2015-2016	11	7	8	11
2016-2017	10	9	9	8
2017-2018	10	10	5	10
2018-2019	10	10	5	10

Туршилтын ердийн сургуулиуд мөн сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн эмч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн анги удирдсан багш нараас бүрдсэн 10 орчим гишүүнтэй ажлын хэсэг байгуулсан. 2018-2019 оны хичээлийн жилийн ажлын хэсгийн гишүүдийн тоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 24 Туршилтын ердийн сургуулийн ажлын хэсэг

Сургуулийн нэр	Харьяалагдах дүүрэг	Ажлын хэсгийн гишүүпийн тоо
16-р сургууль	Сүхбаатар дүүрэг	7
35-р сургууль		5
28-р сургууль	Баянгол дүүрэг	8
113-р сургууль		8
79-р сургууль	Баянзүрх дүүрэг	4
111-р сургууль		9
26-р сургууль	Хан-Уул дүүрэг	7
34-р сургууль		11
Ирээдүй 21-р зуун ЦС	Хөвсгөл аймаг	11
Титэм 2-р сургууль		11

1-3-3-2 Тусгай сургуулийн багшийн ур чадварыг сайжруулах

Тусгай сургуулийн багш нарт зориулж a) Хүүхдийн бодит байдлын судалгаа хийх, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавхыг сайжруулах, b) Хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцсэн арга зүйн дэмжлэг үзүүлэх чадавхыг сайжруулах, c) Туршилтын ердийн сургуульд зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах чадавхыг сайжруулах талаар төслийн сургалт эхлэхээс өмнөх байдал болон дараах гарсан үр дүнг бичлээ. Тусгай сургууль дээр хэрэгжүүлсэн бүх төрлийн сургалтын товчоог Хавсралт 11-д үзүүлэв.

a) Хүүхдийн бодит байдлын судалгаа хийх, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавхыг сайжруулах

Хүүхдийн бодит байдлын судалгаа хийх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавхыг сайжруулахын тулд туршилтын тусгай сургуультай хамтран Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар болон түүнийг боловсруулах аргачлалыг боловсруулж ажилласан.

<u>Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар болон</u>
<u>түүнийг боловсруулах аргачлалыг боловсруулах (2015 оноос)</u>

“Төслийн үйл ажиллагаанаас өмнөх байдал”

Төслийн хэрэгжиж эхлэхээс өмнө тусгай сургуулиуд тус бүр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулдаг байсан боловч агуулга ба загварын хувьд харилцан адилгүй байсан. Хүүхдийн хувийн мэдээлэл болон бодит байдлын судалгааг тэмдэглэх хүснэгт байхгүй тул багш бүр тухайн үеийн байдлаар бичих ба багш нар хүүхдийн тухай мэдээллийг солилцох боломжгүй байсан. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилгыг хичээлийн агуулгад тулгуурладаг байсан бөгөөд хүүхдийн бодит байдалд нийцүүлдэггүй байсан байна.

Хүснэгт 25 Төсөл хэрэгжихийн өмнөх ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний жишээ

<table>
<tr><td colspan="2">Хүүхдийн нэр</td><td>■■■■</td><td>Хүйс</td><td>Эрэгтэй</td><td>Анги</td><td>7А</td><td>Онош</td><td>Аутизм</td></tr>
<tr><td colspan="9">Урт хугацааны зорилт</td></tr>
<tr><td colspan="9">Хөгжмийн хичээлд идэвхтэй оролцдог болох</td></tr>
<tr><td colspan="9">Богино хэмжээний дууг анхааралтай сонсож чаддаг болох</td></tr>
<tr><td colspan="2"></td><td>Хичээлийн зорилго
(Богино хугацаа)</td><td colspan="4">Хичээлийн агуулга, бэлтгэл</td><td colspan="2">Хичээлийн явц, үнэлгээ, засан сайжруулах</td></tr>
<tr><td>Хүрээ
(Судлагдахуун)</td><td>Хөгжим</td><td>・Хөгжмийн хичээлд бүтэн суудаг болох
・Богино хэмжээний дууг анхааралтай сонсож чаддаг болох</td><td colspan="4">・Сонирхолтой богино дуу бэлдэх, видео
・Хүүхдийн дуу. 10 гэж юу вэ? Дууг сонсгох
・1-2 минут анхааралтай сонсгох</td><td colspan="2"></td></tr>
<tr><td colspan="2" rowspan="2">Хариуцсан багш：
■■■■</td><td>Боловсруулсан огноо</td><td colspan="6">2015.01.06</td></tr>
<tr><td>Үнэлгээ хийсэн огноо</td><td colspan="6"></td></tr>
</table>

“Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа”

2015-2016 оны хичээлийн жилд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний нэгдсэн загварын төслийг боловсруулан туршиж үзэх үйл ажиллагаа голлон явагдсан. Мэргэжил арга зүйн багийн хурлаар Япон улсын сургуулиудад одоо хэрэглэгдэж буй ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загварыг танилцуулан, Монголын тусгай сургуулиудын боловсруулж байгаа загваруудтай харьцуулан судалж, нэгдсэн загвар боловсруулах зорилгоор хэлэлцүүлэг өрнүүлсэн. Боловсруулсан загварыг 4 тусгай сургуульд туршиж үзэн, цуврал сургалтуудаар дамжуулан загвар дээр бодит хүүхдийг сонгон ажиллаж, боловсруулалт хийж үзсэн. Туршилтаар зөвхөн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулаад зогсохгүй төлөвлөгөөг үндэслэн ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, судалгаат хичээл зааж үзсэн. 2015-2016 болон 2016-2017 оны хичээлийн жилд нийт 10 удаагийн цуврал хэлэлцүүлэгт сургалт зохион байгуулж, 5 удаа ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан судалгаат хичээл заасан. Түүнчлэн Хэлэлцүүлэгт сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудалтай холбоотой бодлого, тогтолцооны талаар БСШУСЯ-ны хариуцсан мэргэжилтэн тайлбарлаж, хөгжлийн бэрхшээл гэж юу болох, түүний ангилал, бага насны хүүхдийн хөгжлийн үе шатны талаар төслийн япон мэргэжилтнүүд хичээл заасан.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний шинэ загварт хүүхдийн хувийн мэдээлэл болон одоогийн байгаа бодит байдлын тухай бичих хүснэгт оруулж өгсөн. Тухайн хүүхдийн хөгжлийн ай тус бүрээр нь байдлыг бичиж тэмдэглэн бодит байдалд нь тохирсон урт хугацааны зорилт дэвшүүлэх алхмыг хэлэлцүүлэгт сургалтын дадлагын хичээлээр хэвшүүлсэн. Багш нар ажиглалтын явцад хүүхдийн бодит байдлыг үнэлэх арга зүйд суралцсан.

Хүснэгт 26 Шинэ загварын дагуу боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний жишээ

<table>
<tr><td>Анги</td><td>3 анги А бүлэг</td><td colspan="2">Анги удирдсан багш: Д. Идэрхүү</td><td>Боловс-руулсан он</td><td>2017 он 09 сар 12 өдөр</td></tr>
<tr><td>Овог нэр</td><td>Буйданбаатар Мөнх - Оргил</td><td>Хүйс</td><td>1.эр</td><td>Төрсөн огноо /нас/</td><td>2009. 03. 17</td></tr>
<tr><td>Эцэг эхийн нэр</td><td>■■■■</td><td>Гэр бүлийн байдал</td><td>Аав, ээж, эгч, дүү</td><td>Нэмэлт мэдээлэл</td><td>■■■■</td></tr>
<tr><td>Гэрийн хаяг</td><td>■■■■</td><td>Холбоо барих утас</td><td>■■■■</td><td>E-mail</td><td>■■■■</td></tr>
<tr><td>Эрүүл мэндийн байгууллагын оноштой эсэх</td><td>Оюун ухааны бэрхшээл</td><td>Оношт тавьсан ЭМ-ийн байгууллагын нэр</td><td>Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв</td><td>Сургуульд элсэн орсон нас</td><td>6 настай</td></tr>
<tr><td rowspan="2">Оношилгоо үнэлгээ хийгдсэн эсэх</td><td colspan="2">Сургуулийн комиссын үнэлгээ (нийслэлд)хийгдсэн эсэх
<u>Тийм</u> (хугацаа 2015.08.25)</td><td rowspan="2">☑Оюун ухааны хөгжлийн бэрхшээл
□Тулах эрхтний бэрхшээл
□Аутизмын хүрээний эмгэг
□Дауны синдром
☑Хэл ярианы бэрхшээл</td><td colspan="2" rowspan="2">□Суралцах бэрхшээл
□Сэтгэл хөдөлгөөний эмгэг
□Харааны бэрхшээл
□Сонсголын бэрхшээл
□Бусад（ ）</td></tr>
<tr><td colspan="2">Салбар комиссын оношилгоо, хөгжлийн үнэлгээ хийгдсэн эсэх
<u>Үгүй</u></td></tr>
<tr><td>Хавсарсан бэрхшээлтэй эсэх /уналт таталт, зүрхний өвчин, арьсны өвчин г.м/</td><td>Тийм</td><td>Гадаад, дотоодын байгууллагаар оношилгоо, үнэлгээ хийлгэж байсан эсэх</td><td>Гадаадад болон дотоодод оношилгоо, үнэлгээ хийлгэсэн үр дүн
(үгүй)
Бусад( )</td><td>Эрүүл мэндийн байгууллагатай холбоотой байгаа эсэх</td><td><u>Тийм</u> /дэлгэрэнгүй бичих/
Эх нялхас эрүүл мэндийн төв</td></tr>
<tr><td rowspan="3">Хүүхдийн хувийн онцлог, бодит байдал /дуртай зүйл-давуу тал дургүй зүйл – бүдрэлт саад г.м /</td><td colspan="5">1.Төрсний дараа /0-12 сар хүртэл//Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглаж болно/
・Төрөхдөө тархины харвалт өгсөн
・Зүрхний цоорхой, Солонгос улсад нөхүүлсэн.
Зөөлөн тагнай сэтэрхий, эх нялхсын эрүүл мэндийн төвд хагалгаанд орсон</td></tr>
<tr><td colspan="5">2. Сургуульд орохоос өмнөх байдал /2-5 нас
Цэцэрлэгт явж байсан эсэх /<u>тийм</u> / үгүй/ /Цэцэрлэгийн нэр: 10-р цэцэрлэг
Яваагүй бол шалтгааныг бичнэ үү / /</td></tr>
<tr><td colspan="5">3. Сургуульд орсон цагаас эхлэн өнөөг хүртэлх хүүхдийн байдал /тэргэнцэртэй эсэх, ганцаараа сургуульдаа ирж очдог эсэх гэх мэтийг оруулан бичих/
・Өөртөө үйлчлэх энгийн чадвар
✓ Аяганд цай болон жүүс хийж өгөхөд, бие дааж аяагаа бариад асгалгүйгээр ууж чадна. Харин хоолыг халбагдаж идэж чадахгүй.
✓ Анги болон цайны газарт бие даан очиж чадна.
・Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол</td></tr>
</table>

	✓ Өөрийн хэрэгцээ шаардлагаа орилон дугарч эсвэл дохио зангаагаар илэрхийлдэг. ✓ Өгөгдсөн дүрсийг ихээс нь бага уруу эрэмбэлэж хийж чадахгүй, гарт тааралдсан дүрсээ хийдэг. ✓ Цифр, дүрс, өнгө ялгаж чаддаггүй. ・Нийгэмшихүй ✓ Ангийн сурагчидтайгаа жигсаалаар явж бие засах газарт очиж чадна. ✓ Завсарлагаанаар Төрийн дуу дуулахад нэг эгнээнд бусад хүүхдийн адил зогсож чадна. ✓ Найз нөхөдөөрөө хөтлүүлж явдаг болсон. ・Хөдөлгөөн Анх сургуульд орохдоо хөдөлгөөн нь удаан, заавал хөтлүүлж явдаг байсан бол одоо анги танхим болон цайны газраар чөлөөтэй явдаг болсон.
Хүүхдийн өөрийн хүсэл, зорилго	Өөрийн дураар тэнэж явах сонирхолтой.
Эцэг эхийн хүсэл, зорилго	Нийгэмших, бусадтай харилцах, өөртөө үйлчлэх чадварыг нэмэгдүүлэх
Багшийн хүсэл, зорилго	Өөртөө үйлчлэх чадварт суралцуулах

Анги	3 анги а бүлэг	АУБ	■■■■	Боловсруул сан огноо	2017 он 9 сар 12 өдөр
Овог нэр	■■■■	Хүйс	1.эр	Төрсөн огноо (Нас)	2009 он 03 сар 17 өдөр (8)
Урт хугацаа ны зорилт	Өөртөө үйлчлэх энгийн чадвар	Бие даан гадуур хувцасаа өмсөж, товчоо товчилж сурах.		Дэмжлэгий н орчин буюу хэзээ, хаана, ямар үед	Сургууль дээр ирэх, явах үед
	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	Авиан сонсгол хөгжүүлэх, эгшиг авиаг дагаж хэлэх А, О, У авиаг таниулах Юмсыг өнгө хэлбэр дүрсийг ижлээр нь олох			Математик Хэл яриа, Монгол хэл
	Нийгэмшихүй	Суух чадварыг 5–10 минут нэмэгдүүлж зөв суулгаж сургах			Бүх хичээл дээр суух чадварыг нэмэгдүүлнэ.

2017оны 01 дүгээр сард Япон дахь сургалтад тусгай сургуулиас оролцсон багш нар төслийн мэргэжилтэнгүүд хамтарч “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын төслийг боловсруулж мэргэжил арга зүйн баг болон сургуулиудын ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлэн засан сайжруулж эцэслэн “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсан загвар” болон түүнийг боловсруулах аргачлалыг сайдын тушаалаар батлуулах хүсэлтийг Боловсролын хүрээлэнгээс БСШУСЯ-нд гаргасан. Ирүүлсэн төслийг БСШУСЯ–ны холбогдох мэргэжилтнүүд хянан үзэж сайжруулан, БСШУС-ын сайдын 2018 оны 03 дугаар сарын 29-ны А/155 дугаар тушаалаар батлагдсан.

“Төслийн үр дүн”

Хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадварын тухайд уламжлалт аргаар хүүхдийн

“чадахгүй зүйл” болон “дургүй зүйл” дээр төвлөрч ажилладаг байсан багш нар “чаддаг зүйл”, “дуртай зүйл”–ийг анхаарч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тусган боловсруулж сурсан. Судалгаат хичээлийн хувьд төслөөс санал болгосон ээлжит хичээлийн хөтөлбөрийн сайжруулсан загварыг ашиглан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний агуулгаас тусган ээлжит хичээлийн хөтөлбөрөө боловсруулж, тус хичээлийн зорилго, зорилт болон хүүхдийн үйл ажиллагааны агуулга, багшийн дэмжлэг арга зүйн төлөвлөлт хийж чаддаг боллоо. Мөн судалгаат хичээлийн дараа “Хэрэглэгдэхүүн сонгох, ашиглах арга зүй”, “Хүүхдийн бодит байдал”, “Багшийн дэмжлэг арга зүй” гэсэн чиглэлээр хичээлээ эргэн дүгнэж, хэрэглэгдэхүүн нь хүүхдэд тохирсон эсэх, багшийн үг яриа ойлгомжтой байсан эсэх, хүнд хэлбэрийн бэрхшээлтэй болон их дэмжлэг шаардлагатай хүүхдүүд хичээлдээ оролцож чадсан эсэх зэрэг асуудлаар хичээл заасан багш болон ажиглалт хийсэн багш нар хамтран хэлэлцүүлэг хийсэн. Эдгээр туршлагуудаар дамжуулан багш нар хүүхдийн бодит байдал, хичээлийн оролцоог илүү сайн ажиглаж, тохирсон арга зүйг хэлэлцүүлж чаддаг болсон.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан төслийн багаас ажлын хэсэгт зориулж 3 удаа ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах дадлага ажил зохион байгуулав. Эхлээд “Хэт их бичиж тэмдэглэх зүйл байна”, “Зөвхөн урт хугацааны зорилт дэвшүүлдэг байвал яасан юм” гэх мэт бэрхшээсэн саналууд гарч байсан боловч бодитоор хэрэглэж үзээд нэгдсэн нэг загварын ач холбогдолтой талыг ойлгох болсон. Зорилго, зорилт дэвшүүлэхдээ энгийн ойлгомжтой биелэгдэхүйц байдлаар дэвшүүлэхийн чухал, багшийн дэмжлэг арга зүйн хувьд “Багш” буюу үйлийн эзнийг эхэлж бичих зэрэг анхаарах зүйлүүд мөн судалгаа хийх болон бусад багш нар ч харахад ойлгомжтой байдлаар боловсруулдаг болсон. Одоогийн байдлаар туршилтын тусгай сургууль дээр нэгдсэн сургалтын хөтөлбөрөөр сургахад хүндрэлтэй хүүхдүүдийг сонгон авч, үлгэрчилсэн загварын дагуу ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж байна. 2018-2019 оны хичээлийн жилд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажилласан хүүхдийн тоог доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 27 Туршилтын тусгай сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн тоо (2018-2019 оны хичээлийн жилд)

Сургуулийн нэр	Хүүхдийн тоо
25–р тусгай сургууль	24
55–р тусгай сургууль	212
63–р тусгай сургууль	35
70–р тусгай сургууль	50
Нийт	321

*2018 оны 12-р сарын 01-ний өдрийн байдлаар

Дээрх үзүүлэлтээс харахад, багш нарын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар дээшилсэн гэж дүгнэх боломжтой байна.

b) Хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нь нийцсэн дэмжлэг, арга зүйгээр ажиллах чадварыг сайжруулах талаар

Туршилтын тусгай сургуулийн багш нарын хүүхэд бүрийн хэрэгцээнд нь нийцсэн сургалтын арга зүйг сонгон хэрэгжүүлэх чадварыг дээшлүүлэхийн тулд судалгаат хичээл болон туршилтын сургуулийн жишээ туршлагаар хичээл зааж, сургууль дотроо хэлэлцүүлэг хийв. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага”, “Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог” зэргийг боловсруулан гаргасан.

Судалгаат хичээл болон туршилтын сургуулийн жишээний эмхэтгэл боловсруулав. (2015-2016 оны хичээлийн жилээс)

“Төслийн өмнөх байдал”

Төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө, тусгай сургуулиудад хэрэглэгдэж байсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар нь зөвхөн мэдлэг олгох, суралцахуйд суурилсан зорилго, зорилт дэвшүүлсэн хичээлийн агуулга ч унших бичих болон сурах бичгийн агуулгыг ойлгуулахад төвлөрч байлаа. Гэтэл нэг ангид хөгжлийн хүнд, хөнгөнөөр ялгаатай бэрхшээлтэй хүүхдүүд байгаа, ангийн бүх хүүхэд ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ойлгож, жигд оролцох хичээлийг явуулахад үнэхээр хүнд, боломжгүй хэрэг юм.

“Төслийн дэмжлэг, сургалт”

Дээр дурдсанчлан багш нар тухайн хүүхдийн бодит байдлыг судлан дүгнээд, түүндээ тохируулан боловсруулдаг төлөвлөгөөг ээлжит хичээлийн хөтөлбөртөө ч тусган 2017-2018 оны хичээлийн жилд судалгаат хичээлийг бэлтгэн заасан. Туршилтын тусгай сургуулиас бие эрхтний бэрхшээлтэй, бусадтай харилцах тал дээр хязгаарлагдмал хүүхэд болон танин мэдэхүйн хоцрогдолтой хүүхдийн талаар түлхүү суралцах хэрэгцээтэй гэсэн хүсэлтийн дагуу төслийн мэргэжилтнүүд тэдгээр хүүхдийн бодит байдал болон дэмжлэг үзүүлэх арга зүйн талаар сургалт зохион байгуулсан. Судалгаат хичээлийн хувьд бусад багш нартаа санаа өгөх үүднээс “Туршилтын сургуулийн хичээлийн жишээ”-гээр видео бичлэг хийж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, ээлжит хичээлийн хөтөлбөр, хичээлийн бичлэгийн эмхэтгэлийг хэвлүүлсэн.

“Гарсан үр дүн”

Судалгаат хичээлд зориулсан ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах үед нэг сэдвийн хүрээнд ангид байгаа хүнд, хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй ялгаатай хүүхдийн хувьд хичээлийг хэрхэн яаж зохион байгуулах вэ, ямар даалгавар өгөх вэ, хүүхэд бүрийн оролцоог хангахын тулд юу хийх вэ гэдэг асуудал дээр багш нар их цаг зарцуулж удаан хэлэлцэн туршиж үзсэний үр дүнд багаараа тоглох тоглоом оруулах, хүүхэд нэг бүрийн хөгжлийн үе шатад тохирсон тараах материал бэлдэх зэргээр санаачилж, ялгаатай хүүхэдтэй ажиллах арга зүйгээ сайжруулсан. Сургууль дээр судалгаат хичээл зохион

байгуулах, туршилтын сургуулийн жишээний эмхэтгэл боловсруулан гаргах зэргээр хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлэх багш нарын чадавх бэхэжсэн.

Сургууль бүрийн сонгосон хүүхдийн хэлэлцүүлэгт сургалт (2018.09 сараас)

“Төсөл эхлэхээс өмнөх байдал”

Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хуучин Зөвлөлт холбоот улсын их дээд сургуульд суралцан мэргэжил эзэмшсэн ахмад багш нар голлон залуу багш нарт арга зүйн зөвлөгөө өгдөг байсан. Ахмад багш нарын ихэнх нь төсөл хэрэгжих хугацаанд тэтгэвэртээ гарсан ба олон багш нар шинээр ажилд орж, МУБИС-ийн 1 жилийн тусгай хэрэгцээт боловсролын хөрвөх ангид ажиллангаа сурч төгссөн багшийн тоо нэмэгдэж, багш нарын бүтцэд өөрчлөлт орсон. Сургууль дээрээ багш нар туршлагаа солилцох, арга зүйн талаар санал бодлоо солилцох боломж багатайн дээр залуу багш нарыг ахмад туршлагатай багш нар зааж сургаж явах уламжлалт тогтолцоог хэвээр хадгалж үлдэхэд хүндрэлтэй болж ирсэн.

“Төслийн дэмжлэг, сургалт”

Дээрх нөхцөл байдал болон “Төслийн дэмжлэг, сургалт” дуусаны дараа үр дүнг цаашид үргэлжлүүлэн авч явах боловсон хүчнийг бэлдэх үйл ажиллагааны хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд сургууль дээр нь сонгосон хүүхдийн хэлэлцүүлэг сургалт зохион байгуулсан. Энэ сургалтын жишээгээр сонгогдсон хүүхдэд ямар бэрхшээл байгааг яаж шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх вэ гэдгийг хэлэлцэн сайжруулах арга замуудыг гаргаж ирэх, сайн жишээг бусадтайгаа хуваалцах, болохгүй байгаа тохиолдлыг сайжруулахаар хэлэлцэх 1-2 хүүхдийг сонгон авч, анги удирдсан багш хүүхдийн бодит байдлыг танилцуулан, оролцогч багш нар багт хуваагдан шийдвэрлэх арга зам, гарцыг хэлэлцүүлсэн. 2018.10, 2019.01, 03 сард нийт 3 удаа хэлэлцүүлэгт сургалтыг зохион байгуулсан.

“Төслийн үр дүн”

Дээр гарсанчлан тусгай сургууль дээр хуучин зөвлөлт холбоот улсад мэргэжил эзэмшсэн тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн багш нар тэтгэвэртээ гарч харьцангуй залуу багш нар олноор нэмэгдсэн. Хэлэлцүүлэгт сургалтын үеэр ахмад туршлагатай багш нар залуу багш нар хамтарч санал бодлоо солилцон мөн бага анги, дунд ангийн багш нар хамтарч арга зүйн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх боломж гарсан. Уг хэлэлцүүлэгт оролцогч багш нарын зүгээс ганцаараа байсан бол шийдвэрлэж чадахааргүй оон сайхан санаануудыг гаргаж ирж чадлаа, урьд нь анзаарч харж байгаагүй зүйлээмэдэж авсан сайн сургалт боллоо гэж хэлж байсан. Тус хэлэлцүүлэгт сургалт нь тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн хэрэгцээнд нь нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлэх, багшлах ур чадвараа сайжруулахад хувь нэмрээ оруулсан сайн сургалт болсон.

Бусад

Хүүхэд нэг бүрийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн дараах арга зүйн гарын авлагуудыг боловсруулан гаргасан.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага”

  Төсөл эхлэх үед туршилтын сургуулиудад явагдаж байсан хичээлүүд хүүхдийн гараас нь барьж хүчээр бичүүлэх, тоо цээжлүүлэх зэргээр явагддаг байсан. Унших, бичих, тооцоолон бодохыг ойлгож сурахын өмнөх эзэмших танин мэдэхүйн чадвар суугаагүй хүүхдүүдтэй ажиллах арга зүйд суралцаагүй, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, мэдлэг чадвартай багш нарын хэрэгцээ шаардлага байсан. Энэ мэтийн асуудлууд, хэрэгцээнд нь нийцүүлэн ажиллахын тулд хөгжлийн үе шатыг илүү нарийн тодорхой болгож, зааврын дагуу ашиглах боломжтой гарын авлагыг боловсруулсан. Тус гарын авлагад 1) Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгт, 2) Хөгжлийн төвшин бүрд тохирох даалгавар, 3) Багшлах арга зүйн дэлгэрэнгүй жишээг оруулсан. Дараах хүснэгтийн дагуу хүүхдийн хөгжлийн айг “Өөртөө үйлчлэх энгийн чадвар”, “Хөдөлгөөн, үйл ажиллагаа”, “Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол”, “Харилцаа, нийгэмшихүй” гэсэн 4 айд хуваж, 1-5 дугаар түвшинд ангилсан. Хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгтийг хүүхдийн хөгжлийн бодит байдлыг тодорхойлоход ашиглан, даалгаврын жишээ болон шаардлагатай орчин, хэрэглэгдэхүүний бэлтгэл хийх дараалал зэргийг оруулсан. Тусгай сургуульд тус гарын авлагыг танилцуулж, бодитоор хэрэглэж, сайжруулах ажил хийгдсэн. Гарын авлагын агуулгыг доорх хүснэгтэд тодорхой ойлгомжтой байдлаар оруулаа.

Хүснэгт 28 Хөгжлийн төвшинг тодорхойлох хүснэгт

Агуулга	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 4	Түвшин 5
I - 1 Цэвэрлэж хураах		1. Даалгавараа хийж дуусаад хэрэглэсэн зүйлээ хураах	2. Хоолоо идэж дуусаад аяга таваг зэрэг хэрэглэсэн зүйлээ хураах		
I - 2 Гараа угаах		3. Цоргоноос гоожиж буй усаар гараа норгох	4. Бусдын зааврын дагуу гар угаах дараалыг зөв гүйцэтгэх	5. Бие дааж дараалын дагуу гараа угаах	
II - 1 Бөмбөг тоглох		6. Бай руу бөмбөг шидэх			
		7. Бөмбөг шидэх, өнхрүүлэх	8. Том бөмбөг барьж авах	9. Жижиг бөмбөг барьж авах	
II - 2 Хэвнээс гаргах, хийх	10. Хэвнээс дугуй дүрсийг гаргах	11. Дугуй дүрсийг хэвэнд хийх	12. Дүрсүүдийг хэвэнд тохируулж хийх		

II - 3 Өрдөг модон шоо	13. Хоёр гартаа барьсан модон шоог хооронд нь нийлүүлэх	14. 3 хүртэл модон шоог өрөх	15. Модон шоог эвлүүлж ямар нэг дүрс хийх		
II - 4 Сав болон багаж хэрэгсэл, эд юмс	16. Саванд байгаа эд юмсыг гаргаж авах	17. Саванд эд юмс хийх	18. Халбага, хавчаар зэргийг ашиглаж эд юмсыг савнаас гаргах, буцааж хийх		
II - 5 Цагираг ба уяа	19. Уяанд хэлхсэн шүрийг сугалах	20. Нэг ширхэг шүр бүдүүн уяа сүвлэх	21. 5 ширхэг цагирагт бүдүүн уяа сүвлэх		
II - 6 Цахилгаан, товч, цаас		22. Уутны цахилгааныг нээх, хаах	23. Том товч тайлах		24. Цаасыг дундуур нь нугалан дугтуйд хийх
II - 7 "Пэг" суурин тоглоом, наалт	25. "Пэг" сууринаас модон дүрсээ сугалж авах	26. "Пэг" сууринд модон дүрсээ хийх	27. Хүрээний хязгаар дотор наалт наах		
II - 8 Гар ажиллагаа		28. Дүрсээ цавуудаж хүрээ дотор наах		29. Хайчаар шулуун болон муруй шугамын дагуу хайчлах	30. Муруй шугам болон өнцөг гарган өөгүй хайчлах
III - 1 Дүрс, өнгө, тохирох, эс тохирохыг ялгах		31. Ижил зүйлүүдийг нэгтгэх, ангилах	34. Хэлбэрээр нь ижилсүүлж нэгтгэх	37. Ижил хэлбэр дүрсээр нь ангилах	
		32. Ижил зургуудыг нэгтгэх			
			35. Зургаар үзүүлсэн эд зүйлийг олох	38. Дүрс өөр боловч, нэг төрлийн зүйлийг ангилах	
		33. Өнгөөр нь ижилсүүлж нэгтгэх	36. Ижил өнгөтэй эд юмсыг нэгтгэх	39. Эд зүйлсийг зориулалтаар нь ангилах	
III - 2 Дүрс, үсэг бичих		40. Сараачих	41. Бусдын зурсныг дуурайн хөндлөн, босоо зураас зурах	43. Бусдын зурсныг дуурайн нэмэх, дөрвөлжин дүрс, ташуу зураас зурах	45. Бусдын зурсныг дуурайн гурвалжин дүрс, хялбар үсэг зурах
			42. Том хүн дуурайж дугуй дүрс зурах	44. Шулуун болон нуман зураасыг балаар зурах	46. Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсүүдийг балаар зурах
III - 3 Үсэг унших				47. Өөрийнхөө нэрэнд ордог	48. Өөрийн нэрийнхээ бүх

				үсгийг олох	үсгийг олох
					49. Бүх тоог олох
					50. 4 хүртэл үсэгтэй үгийг харж ойлгон, тохирох зүйлийг олох
III - 4 Тоо ширхэг, хэмжээ			51. 3 хүртэл тоотой ижил зүйлүүдийг нэгтгэх	54. 3 ширхэг зүйл хүссэнийг авч өгөх	56. 10 ширхэг зүйл хүссэнийг авч өгөх
			52. 1 тооны утгыг ойлгох	55. 5 ширхэг зүйлийг чанга дуугаар зөв тоолох	57. 10 ширхэг зүйлийг чанга дуугаар зөв тоолох
			53. 1 тооны утгыг ойлгон, 1 ширхэг зүйл тавьсан тавгийг сонгох		58. 5 хүртэл тоотой юмсыг, тохирох цифртэй харгалзуулах
III - 5 Эд юмсын харьяалал				59. Ижил 2 зүйлээс том, жижгийг нь сонгох	60. Ижил 2 зүйлээс урт, богиныг сонгох
III - 6 Эд юмсын зориулалт				61. Эд юмсын зориулалтын нэршлийг ойлгох	62. Эд юмсын зориулалтыг тайлбарлах
IV – 1 Санаа бодлоо илэрхийлэх		63. 2 ширхэг зүйлээс 1-ийг нь зааж, хүрч сонгож авах	64. 2 зурагнаас өөрт таалагдах зүйлийг сонгох	66. Өөрт хэрэгтэй байгаа үйлдлээ зургаар заах	
			65. "Надаа" гэдэг үгийг үйлдэл эсвэл үгээр илэрхийлэх		
IV – 2 Хэл ярианы ойлголт, асуух, хариулах				67. Ээлж дараалыг ойлгуулах тоглоом тоглох	
					68. "За, май", "Баярлалаа", "Уучлаарай" зэрэг үгийг хэрэглэх

- “Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог”

Тусгай сургуульд хичээлийн явцад зурган карт өргөн хэрэглэгдэдэг бөгөөд төслийн мэргэжилтнүүдээс зохион байгуулсан сургалтын үеэр ч энэ аргын үр дүнтэй болохыг ярьж ирсэн. Нөгөөтэйгүүр судалгаат хичээл зэрэгт багш нарын хэрэглэж байгаа зурган картын зураг нь интернетээс авсан байх нь нийтлэг байдаг ба Монголын соёл, зан заншилд нийцээгүй, оновчтой бус, хүүхдийн эрэлт хэрэгцээг хангахгүй, зургийн чанар

муу гэх зэрэг олон асуудал байсан. Төслийн баг эдгээр байдлыг үндэслэн өдөр тутамд хэрэглэгддэг үгсийн зурган цомог боловсруулах ажлыг мэрэгжил арга зүйн багийн гишүүдтэй хамтран үгсийн жагсаалтыг гарган зургийн сонголтыг хийсэн. Уг зурган цомгийг CD-ROM-ыг хавсаргасан байдлаар хэвлэж, төслийн тайлангийн “Туршлага солилцох семинар” дээр тараасан бөгөөд боловсролын яамаар дамжуулан Монгол Улсын нийт сургуулиудад тараасан. Мөн түүнчлэн зурган цомог шаардлагатай багш нар хэн бүхэн чөлөөтэй татаж авч ашиглах зорилгоор БМДИ-ийн онлайн сургалтын болон багшийн хөгжил портал сайтад байршуулсан болно.

c) Туршилтын ердийн сургуулийн багш нарт чиглэсэн дэмжлэгийн үр дүн ба чадавх бэхжүүлэх сургалт

Монгол Улсын Засгийн газар цаашид тусгай сургууль нэмж байгуулах төлөвлөгөөгүй бөгөөд цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрийн хамрагдаж буй тойргийн сургуульдаа тэгш хамрагдан боловсрол эзэмших бодлого барьж байна. Тиймээс одоо ажиллаж байгаа тусгай сургуулиуд нь арга зүйн лавлагаа төв нь болж, ердийн сургуулийн багш нарт зөвлөн туслах тогтолцоо бүрдүүлэх шаардлага гарч байна. Төслийн багаас туршилтын тусгай сургууль нь ердийн сургуульдаа дэмжлэг үзүүлэх чадавхыг сайжруулах зорилгоор Туршилтын ердийн сургуульд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Туршилтын ердийн сургуульд зориулсан зөвлөн туслах үйл ажиллагаа

“Төсөл эхлэхээс өмнөх байдал”

Төсөл эхлэхийн өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургуульд тодорхой хэмжээгээр суралцдаг хэдий ч багш нарын арга зүй дутмаг, хүүхдийн бодит байдлыг тодорхойлж тохирсон дэмжлэг үзүүлэх чадвар муу байсан. Мөн тусгай сургуулийн багш нараас ердийн сургуулийн багш нарт зориулж зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулдаг тогтолцоо байхгүй байсан.

Хөвсгөл аймгийн багш нарын хувьд Нийслэлийн сургуулийн багш нартай харьцуулахад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт муу, ялангуяа илт харагдахгүй бэрхшээлийн (Оюуны хөнгөн хэлбэрийн бэрхшээл болон хөгжлийн хоцрогдол) тухай мэдээлэл, арга зүй дутмаг асуудлууд асуудлууд байсан. Тиймээс хүүхэд нэг бүрийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн багшлах арга зүй, боловсролын үйлчилгээ явуулж чадахааргүй байсан.

“Төслөөс үзүүлсэн дэмжлэг ба сургалтууд”

Нийслэлийн туршилтын ердийн сургуулиудын багш нарт зөвлөн туслах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулав .

- 2015 оны 12 дугаар сард туршилтын тусгай сургуулийн ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ердийн сургуулийн хэрэгцээг тодорхойлох, зөвлөн туслах үйл ажиллагаа

зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан. Тус төлөвлөгөөний дагуу 2015-2016 оны хичээлийн жилд ердийн сургууль тус бүрд 6-7 удаа зөвлөн туслах үйл ажиллагаа явуулсан. Энэ ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлийн төрлүүд, хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар лекц, сургалт орсноос гадна ЕБС-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон суралцахуйн бэрхшээлтэй, сурлагын хоцрогдолтой хүүхдийн хөгжлийн үнэлгээг хийсэн. 2016 оны 03 дугаар сард ердийн сургуулийн багш нарыг тусгай сургуулийн судалгаат хичээл дээр ажиглалт хийлгэж, хичээлийн дараах хэлэлцүүлэгт оролцуулж тэдний туршлагыг сайжруулсан. Лекц сургалт болон хүүхдийн үнэлгээ хийх ажлыг тусгай сургуулийн багш нар хариуцсан ба төлөвлөгөө гаргах, хяналт (мониторинг) хийх ажлыг төслийн мэргэжилтнүүд зонхилон хариуцав. Мониторинг хийх үеэр “Ердийн сургуулийн багш нар завгүй”, “Төлөвлөгөөний дагуу зөвлөн тусалж чадахгүй”, “Өөрийн хичээл заадаг ангид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байхгүй багш нар оролцохдоо цааргалдаг”, “Ердийн сургууль хүртэл хол учраас унааны зардал байхгүй” зэрэг олон асуудлуудыг тогтоов. 2016 оны 03 дугаар сараас тусгай сургууль бүрээс тус бүр гурван багшийг Нийслэлийн боловсролын газрын “Сургагч багш”-аар томилон сарын бүр цалингийн 5%-ийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн. Эдгээр багш нар Нийслэлийн боловсролын газраас зохион байгуулсан багш нарын сургалтад ч сургагч багш хийж, мөн зөвлөн тусалдаг болсон.

- 2016-2017 оны хичээлийн жилд туршилтын тусгай сургууль, туршилтын ердийн сургуулийн дунд зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах явуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжих хугацааг товлосон. Ердийн сургууль тус бүр дээр хэрэгцээнд нь нийцсэн, оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн ердийн сургуулийн багш нарын баг тусгай сургуультай танилцах аялал хийж туршлага судалсан.

- 2017-2018 оны хичээлийн жилээс БСШУСЯ-аас зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулж буй тусгай сургуулийн багш нарт сургагч багшилсан хөлс олгох шийдвэр гаргасан. Ердийн сургуулийн багш нараас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон сурлагын хоцрогдолтой хүүхдэд хөгжлийн үнэлгээ хийлгэх хүсэлт олон ирж байсан. Тусгай сургуулийн мэргэжлийн багш нар хүүхдийн хөгжлийн үнэлгээг гардан хийснээр тухайн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдын ойлголтыг сайжруулахад сайн нөлөөтэй гэж төслийн мониторингхийх үед багш нар хэлж байсан.

- 2018-2019 оны хичээлийн жилд сургууль бүрийн ажлын хэсэгтэй уулзалт хийж, төслийн хэрэгжиж дуусаны дараа ч зөвлөн туслах үйл ажиллагааг үргэлжлүүлэн улиралд 1 удаа зохион байгуулж байхаар зөвшилцсөн болно.

Хөвсгөл аймгийн туршилтын ердийн сургуулийн хувьд, туршилтын тусгай сургуулийн багш Нийслэлээс очиж зөвлөгөө өгөх нь хүндрэлтэй байсан тул 2017оны 10 дугаар сард аймгийн туршилтын ердийн сургуулийн 14 багшийг (Туршилтын ЕБС-ийн ажлын хэсгийн тав таван гишүүн, сумын сургуулийн багш 3, “Далай ван” хувийн дунд сургуулийн 1 багш) Нийслэлд урьж ирүүлэн тусгай сургуулиудын үйл ажиллагаатай танилцуулав. Оролцогчдын томилолтын зардал, замын зардал, тусгай сургуулийн сургагч багшийн ажлын хөлсийг БСШУСЯ-аас төсөлтэй хамтран ажиллахад зориулсан үйл ажиллагааны төсвөөс санхүүжүүлсэн. Оролцогчид тус сургалтаар дамжуулан арга зүй болон сургуулийн орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах талаар мэдлэг ойлголттой болж буцаж очоод өөрийн сургууль дээрээ семинар зохион байгуулж, бусад багш нар болон эцэг эхчүүдэд сурч мэдсэн зүйлээ танилцуулж, сургуулийн нийт анги танхимд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойлгомжтой хаягжилт хийх, шинээр хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэг ажлуудыг хийсэн.

“Төслийн үр дүн”

Төслийн эцсийн шатны төлөв байдлын судалгаагаар, тусгай сургуулийн багш нар зөвлөн туслах үйл ажиллагаар дамжуулан, туршилтын ердийн сургуулийн багш нарын мэдлэг, чадвар, сонирхлын ялгаатай байдлыг мэдрэн туршилтын ердийн сургуулийн багш нарыг тэдний ойлголт хандлагыг сайжруулах сургалтад цаашид хамруулж байх хэрэгцээ шаардлага байгаа нь тодорхой байсан. Мөн ердийн сургуулийн багш нарын хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор тэдний ойлголт сонирхолд тохирсон зөвлөн туслах үйл ажиллагаа явуулах талаар тусгай сургуулийн багш нарын чадавх ч сайжирсан.

1-3-3-3 Ердийн сургуулийн багш нарын чадавхыг сайжруулах

Туршилтын ердийн сургуульд тодорхой тооны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа ч багш нар эдгээр хүүхдүүдтэй ажиллах, бодит байдлыг тодорхойлох арга зүй дутмаг, тохирох дэмжлэгийг үзүүлж чадахгүй байсан. 2015-2016 оны хичээлийн жилд туршилтын тусгай сургуулиас үзүүлж буй зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулснаар мэргэжил арга зүйн багийн гишүүдээс “Сургууль бүхэлдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээж авах, амжилттай сургах тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах хүсэлт гарсан.

Үүнтэй уялдуулан 2017 оны 02 дугаар сард мэргэжил арга зүйн баг, туршилтын тусгай сургууль, Нийслэлийн туршилтын ердийн сургуулийн холбогдох хүмүүстэй уулзаж, сургуулийн өнөөгийн байдал, хэрэгцээг тандах уулзалт зохион байгуулсан. Сургууль бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авахад тулгамдаж байгаа асуудлыг багаараа тодруулж, асуудлыг шийдвэрлэх, сайжруулахад шаардлагатай дэмжлэгийн талаар хэлэлцүүлэг хийсэн. 8 сургуулиас гаргасан асуудлуудыг нэгтгэсэн байдлаар доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 29 Туршилтын ердийн сургуулиудад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх дэмжлэгийн агуулга

Тулгамдсан асуудал	
Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн талын тулгамдсан асуудал	• Бие засах өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах боломжгүй. • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон ширээ, сандал байхгүй. • Налуу замгүй, хичээлийн байрны шат, хичээлийн байрны үүд нарийхан. • Танхимыг 1-р давхарт тохируулж өгсөн ч, цахилгаан шатгүй тул 2-р давхраас дээш байрлах бие засах өрөө болон дуу хөгжмийн кабинет, биеийн таимрын заал руу явахад бэрхшээлтэй. • Сурах бичиг, суралцахад нь хэрэгтэй ном байхгүй.
Багшлах арга зүй, мэргэжлийн мэдлэг дутагдах зэрэг тулгамдсан асуудал	• Багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах ур чадвар дутагдалтай. • Багш нар нь төгссөн сургуульдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох боловсролын талаар сураагүй. • Сургуульд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдийн боловсролоор мэргэшсэн хүн байхгүй. • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд-ийн оношилгоо, хөгжлийн үнэлгээ хийгддэггүйн улмаас ямар хөгжлийн бэрхшээлтэй болохыг нь мэддэггүй. • Сургалтын материалууд нь хүүхдэд тохиромжгүй. Тусгай сургуулийн сургалтын материалуудыг ердийн сургуульд ч ашиглах боломжтой байвал сайн. • Багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч сургах сэтгэл зүйн бэлтгэл байхгүй.
Байгууллагын дотоод зохион байгуулалтын тулгамдсан асуудал	• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон сурлагын үнэлгээний стандарт ашиглах шаардлагатай. • Хүүхдийн сурлагын үнэлгээ нь багшийн ажлын үнэлгээнд нөлөөлдөг. • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургаж буй багшид урамшуулал олгодоггүй. • Сургаж чиглүүлэх цаг хангалтгүй байдаг. 2-оос дээш ээлжтэй сургуулиудын хувьд хүндрэлтэй асуудал болдог. • 1 ангийн хүүхдийн тоо олон тул хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахад цаг зарцуулах боломжгүй. • Дундаас дээш ангид орохоороо олон багш нартай холбогддог тул хүндрэл нь ихэсдэг. • Туслах багш шаардлагатай. • Хөгжлийн бэрхшээлгүй хүүхдийн асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдийг ялгаварлаж үздэг. • Асран хамгаалагч нь хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийг хүлээн зөвшөөрдөггүй.
Шаардлагатай дэмжлэгүүд	
БСШУСЯ болон НБГ-т хандан	• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд-ийг хүлээн авч сургах орчин бүрдүүлэхэд зориулсан төсөвтэй болох. • Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдийг сурлагын үнэлгээг ялгаж салгах. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан сурлагыг нь үнэлдэг болбол сайн. • Хүүхдийн сурлагаар багшийг үнэлэх бус хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургаж буй багш нарыг илүү өндөр үнэлдэг болох. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан, хичээл заасан цагийн тоогоор үнэлдэг болох. • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургаж байгаа багшийн цалинг 20-30 хувиар нэмэгдүүлэх. • Багш нарт зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах мэргэжлийн

	талын мэдлэг олж авах боломжтой сургалт зохион байгуулах. • Сурах бичиг, гарын авлагаар хангах. • Багшлах эрхийн үнэмлэх авахтай холбогдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах арга зүйн талаарх лекцийг заавал судлах хичээлийн тоонд оруулж өгөх. • Хөгжлийн үнэлгээ хийдэг багийг сургууль дээрээ урьж авчрах. • Мэргэжлийн багш хуваарилах. • Ердийн сургуулиас Япон дахь сургалтад оролцуулах.
Төсөл болон туршилтын тусгай сургуульд хандан	• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах арга зүйн зөвлөгөө авах. • Асран хамгаалагчдын туслалцааг авахын тулд яах ёстой талаар зөвлөгөө авах. • Тусгай сургуульд ердийн сургуулийн багш нар дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх. • Тусгай сургуулийн багш нар ердийн сургуулийн багш нарыг чиглүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх. • Хөгжлийн үнэлгээ хийдэг багийг сургууль дээрээ урьж авчрах.

Туршилтын ердийн сургуулийн багш нарт зориулсан 1) Хүүхдийн бодит байдлыг тодорхойлох, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн багшлах арга зүйн чадавхыг бэхжүүлэх, 2) Тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх, хэрэглэгдэхүүн боловсруулах чадавхыг сайжруулах, “Төслийн дэмжлэг, сургалт”ын өмнөх байдал болон дараах буюу үр дүн гарсан байдлыг тэмдэглэн оруулсан.

а) Хүүхдийн бодит байдлыг тодорхойлох, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн багшлах арга зүйн чадавхыг бэхжүүлэх

Хүүхдийн бодит байдлыг тодорхойлох, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцүүлэн багшлах арга зүйн чадавхыг бэхжүүлэх зорилгоор <u>туршилтын тусгай сургуулиас зөвлөн туслах үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ төслийн мэргэжилтнүүдээс сургалт</u> зохион байгуулсан.

<u>Зөвлөн туслах үйл ажиллагаа, сургалт зохион байгуулсан</u>

“Төсөл эхлэхийн өмнөх байдал”

Төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө туршилтын ердийн сургуулийн багш нар бие эрхтний бэрхшээлийг хараад мэддэг хэдий ч оюуны хөгжлийн бэрхшээл, хэл ярианы бэрхшээл зэргийн талаар нарийн ойлголт мэдлэггүй, хүүхдэд шаардлагатай дэмжлэгийг тодорхойлж чадвар хомс байсан. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж байсан туршлагагүй, ангийн бусад хүүхэдтэй харьцуулахад хөгжлийн хоцрогдолтой болон ялгаатай хүүхдэд зориулж, хичээлийг яаж удирдаж явуулах, тохирох хэрэглэгдэхүүнийг боловсруулах мэдлэггүй байсан. Мөн ердийн сургуульд эмнэлгийн байгууллагаар тодорхойлогдоод ирсэн оноштой хүүхэдтэй хэрхэн ажиллах, эсвэл тодорхой оношгүй атлаа суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн асуудалтай хүүхэдтэй

ажиллах арга зүйн талаар суралцах хэрэгцээ нийтлэг аль ч сургуульд байсан.

“Төслийн дэмжлэг, сургалт”

Төслийн багаас нийслэлийн туршилтын ердийн сургуулиудын багш нарт зориулж сургалт явуулсан. 4 дүүргийн туршилтын тусгай сургууль нь дүүргийнхээ ердийн сургуульд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд тухайн сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд хөгжлийн үнэлгээ хийж, бэрхшээлийн төрөл, ангилал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад юуг анхаарах зэрэг сэдвээр сургалт явуулж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалыг танилцуулах зэргээр зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Мөн ердийн сургуулийн багш нарын баг тусгай сургуулийн үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлуулах, судалгаат хичээлд ажиглагчаар оролцуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. Хөвсгөл аймгийн туршилтын ердийн сургуулиуд дээр 2017 оны 03 дугаар сард болон 2018 оны 04 дүгээр сард Нийслэлийн тусгай сургуулийн багш нарын төлөөлөл ажиллаж, хүүхдэд үнэлгээ хийж, багш нарт зөвлөгөө өгч, сургалт явуулсан. Дээр дурдсанчлан туршилтын ердийн сургуулийн 14 багш нар багаараа Нийслэлд туршлага судалж, тусгай сургуулийн үйл ажиллагаатай танилцсан.

2017 оны 03 дугаар сард төслийн мэргэжилтэн, сургуулиудын хэрэгцээ, хүсэлтийг үндэслэн багшлах арга зүй болон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах талаар сургалт, семинарыг зохион байгуулсан. Үүнд: хөгжлийн бэрхшээлийн төрлийн ялгаатай байдлыг ойлгож багшлах арга зүйгээ сайжруулах сургалтыг сургууль тус бүр өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн аутизм, даун, бие эрхтний бэрхшээл гэх мэтээр сурагчдын онцлогоос хамаарсан сэдэв сонгон Япон мэргэжилтнүүдээс сургалт семинар авч дадлага хийсэн. Сургууль тус бүр хамгийн тулгамдаж буй асуудлаа сэдэв болгон сонгосон тул сайжруулах санал, зөвлөгөө өгч чиглүүлэхэд боломжтой байсан. Сургуулийн багш нарын ойлголт хандлага адилгүй тул сургалтын менежерүүдтэй холбогдон ажлын хэсгээрээ зөвлөлдөж, сургалтуудад явуулсан. Зарим хүсэлт гаргасан сургуулиудтай хамтран ажиллаж ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон улмаар ээлжит хичээлийн төлөвлөгөө боловсруулан судалгаат хичээл зааж байсан.

Хөвсгөл аймгийн туршилтын сургууль нь 2016-2017, 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд 3 жилийн турш ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан, судалгаат хичээл заах үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж хэвшсэн. Энэ үйл ажиллагааг тухайн сургуулийн ажлын хэсэг хариуцаж, төслийн багтай хамтран ажилласан ба сургууль дээр байгуулагдсан хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж буй багш нар хүүхдийн ялгаатай байдал, хүсэл сонирхолд нийцүүлэн хичээлийн хэрэглэгдэхүүн хийх зэргээр хамтран ажиллаж зөвлөн тусалж байсан. Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын хариуцсан мэргэжилтний хүсэлтийг хүлээн

авч, туршилтын бус 7 ердийн сургуулийн багш нарын төлөөлөлд зориулсан [7] мөн хөгжлийн бэрхшээлийн төрөл, ангилал, тус бүрийн онцлогтой хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, боловсруулах аргачлалыг танилцуулах сургалт зохион байгуулсан.

“Төслийн үр дүн”

Багш нарын хүүхдийн бодит байдлыг судалж үнэлэх чадавх дээшилсэн, туршилтын ердийн сургуулийн багш нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлага сайжирсан үр дүн гарсан. Төсөл хэрэгжихээс өмнө харааны шил зүүсэн хүүхдийг харааны бэрхшээлтэй гэж тоолдог, өөртөө үйлчлэх энгийн чадвар нь хөгжөөгүй хүүхдийг ар гэрийн хүмүүжил муу гэж үздэг багш нар ч байсан. Төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн төрөл ба түүний онцлогуудын талаар сургалт явуулан сургуулийн ажлын хэсгийн гишүүд болон тэдний үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага өгч, ойлголтыг сайжруулж чадсан. Ингэснээр ажлын хэсгийн гишүүн багш нарын дунд хуучин ойлголттой багш огт байхгүй болсон.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавхын тухайд туршилтын ердийн сургуулиуд дээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн тоог доорх хүснэгтэд үзүүлэв. Ерөнхий боловсролын 16, 113, Титэм, Ирээдүй 21 зуун цогцолбор сургуулиуд нь ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, судалгаат хичээл зааж, хэлэлцүүлэг үйл ажиллагаанд 4 удаа хамт олноороо ажилласнаар ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар нь нэлээд сайжирсан гэж үзэж байна.

Хүснэгт 30 Туршилтын сургуулийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн тоо (2018-2019 оны хичээлийн жил)

Сургуулийн нэр	Хүүхдийн тоо	Сургуулийн нэр	Хүүхдийн тоо
16-р сургууль	2	79-р сургууль	3
26-р сургууль	1	111-р сургууль	3
28-р сургууль	5	113-р сургууль	0
34-р сургууль	12	Титэм сургууль	7
35-р сургууль	1	Ирээдүй 21 зуун ЦС	24
Нийт			58

*2018.12.01 өдрийн байдлаар

Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн арга зүйг сонгон хичээл сургалтыг зохион байгуулах чадавхын хувьд ердийн сургууль дээр боловсролын стандарт, хөтөлбөрт тулгуурлан хичээллэж байгаа тул өдөр тутмын хичээлийг төлөвлөдөг. Ялангуяа оюуны хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн хоцрогдолтой хүүхэд тус хөтөлбөрийг гүйцэхэд маш хүндрэлтэй байдаг. Төслийн үйл ажиллагаа, дэмжлэг эхлэхээс өмнө хичээл дээр тийм хүүхдийг багшийн ойрхон суулгаад өөр зүйл хийлгэж байсан боловч, тухайн хүүхдийн

[7] Нутгийн аваргууд, Авъяас, Сод эрдэм, Дэлгэрмөрөн цогцолбор сургууль, Гурван –Эрдэнэ, Эрдмийн далай, Далай ван хувийн дунд сургууль/

чадвар, боломжийг үнэлж, дэмжлэг болж чадах даалгавар мөн эсэхийг бүрэн тогтоож чаддаггүй байсан. Тусгай сургуулиас үзүүлж буй зөвлөн туслах үйл ажиллагаа болон төслийн мэргэжилтнээс явуулсан сургалтын үр дүнд туршилтын ердийн сургуулийн багш нар арга зүйгээ сайжруулах туршилт хийж үзэн, тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх ашиглах оролдлого хийдэг болсон.

Хүснэгт 31 Багш өөрчлөгдөхөд хүүхэд өөрчлөгдөнө –Хөвсгөл аймгийн сайн жишээнээс

Хөвсгөл аймгийн “Ирээдүй 21 зуун” цогцолбор сургууль дээр 2017-2018 оны хичээлийн жилд 5 дугаар ангид дэвшин суралцах хүүхдийг сонгон авсан. 2 дугаар ангид байхдаа хүүхэд, хичээл дундуур дураараа босч явдаг, ангиас гарч гүйдэг, багшийн үгийг сонсдоггүй маш тогтворгүй хүүхэд байсан. Сурлагын хувьд гэвэл унших тал дээр асуудалгүй боловч тоо бодохдоо, чээж бичиг хийхэд их алддаг, муухай бичдэг, хуулж бичихдээ ч алддаг хүүхэд байсан. Багш энэ хүүхдийн хийж чадах чадвараас илүү давсан даалгавар өгч байснаа арга зүйгээ сайжруулах явцдаа анзаарсан. Хүүхдийн хувьд хичээлийн сүүл үед анхаарал нь суларчихсан, эргээд бодоход даалгавар хүндэдсэн байж болох талтай. Тусгай сургуулийн багшаас ганцаарчлан зөвлөгөө авч, ээлжит хичээлийн хөтөлбөрөө засан сайжруулсан. Тэр үеэс хойш охины чадвар, сонирхолд нийцсэн дасгал даалгавар өгөхийг хичээдэг болсон. Жишээлбэл: Охин хуулж бичихдээ дуртай боловч өмнө нь нэлээд урт эх өгч бичүүлж байсан тул дундуур нь уйдахдаа ангиас гараад гүйчихдэг байсан. Богино эхийг гоё сайхан хуулж бичих даалгавар өгдөг болсноор анхааралтай сайн бичдэг болж, хүүхдэд ахиц гарч байгаа нь мэдэгддэг болсон. Түүний үр дүнд, гэнэт суудлаасаа босч явах, ангиас гарч гүйх нь эрс багассан. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах тухайд залуу багш нараас тусламж хүсч асууж ирдэг, өөрийн туршлагадаа үндэслэн, тодорхой зөвлөгөө өгдөг болсон. Ингэснээр багшийн хувьд ч өөртөө итгэлтэй болсон. Цаашид сургууль дээрээ багшлах чадвараа сайжруулахаар чадлаараа хичээж ажиллана гэж бодож байна.

<u>Бусад</u>

Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн арга зүйгээр хичээл удирдахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах гарын авлагуудыг боловсруулан гаргасан.

- “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж”

Сургалтаар дамжуулан оюуны хөгжлийн хувьд хоцрогдолгүй боловч сурлагын хоцрогдолтой эсвэл зан үйлийн хувьд асуудалтай хүүхэд сургуулийн анги бүрд 2-3 хүүхэд суралцаж байгаа бөгөөд багш нар “Тэдгээр хүүхдүүдтэй хэрхэн яаж ажиллах вэ” гэдэг асуултыг их тавьж байсан. Төслийн багаас эхний удаад сургуулийн амьдралд хэвийн оролцоход бэрхшээлтэй хүүхдийн хувийг хэд хэдэн хөгжлийн айд хуваж, судалгаа хийхээр болсон. Үүний үр дүнд “Сонсох”, “Ярих”, “Унших”, “Бичих”, “Тооцоолон бодох”, “Цаг хугацаа, орон зай, учир зүйн холбоо хамаарлыг ойлгох”, “Булчингийн хөдөлгөөн”, “Хүнтэй харилцах харилцаа”, “Үйлдэл хийх” гэсэн эдгээр 9 хөгжлийн айд хуваасан шалгах хуудсыг боловсруулсан.

Хүснэгт 32 “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж”-ийн хүүхдийн онцлог хэрэгцээг таних асуулга

Анги:					
	АГУУЛГА	Хүүхэд 1	Хүүхэд 2	Хүүхэд 3	Хүүхэд 4
	I. Сонсох				
1	Анхаарлаа төвлөрүүлэн харилцагчийн яриаг сонсож чадна				
2	Сонссон зүйлээ мартахгүй тогтоож чадна				
3	Ганцаарчлан эсвэл хамт олон багаар нь даалгавар, заавар өгөхөд ойлгож гүйцэтгэж чадна				
4	Ангид яригдаж байгаа зүйлийг сайн ойлгож, идэвхтэй оролцоно				
	II. Ярих				
1	Ангийн хүүхдүүдийн түвшинд эсвэл тэднээс илүү үгийн сантай				
2	Хэл зүйн дүрмийн хувьд алдаагүй бүтэн өгүүлбэрээр ярина				
3	Дараалал, учир шалтгааны холбоо хамаарлыг тогтоож, өөрийн туршлага болон санал бодлоо илэрхийлж чадна				
4	Ye тэнгийн хүүхдүүдтэй яриа өрнүүлж чадна				
	III. Унших				
1	Цагаан толгойн үсэг бүрийг мэднэ (Жишээлбэл: А үсгийг хараад А гэж уншдаг)				
2	Цагаан толгойн үсгийн дуудлагыг нэг нэгээр нь мэднэ. (Жишээлбэл: А үсгийн А гэсэн дуудлагыг хэлж чадна), (Авиан дуудлагын бэрхшээлийг тооцохгүй)				
3	Урт, хос эгшиг, Я-гийн төрлийн үсэг орсон үе болон үгийг алдаагүй уншина.				
4	Үсэг алгасах, тааж унших зэрэг алдаа гаргалгүй чанга дуугаар түгдрэлгүй уншина. (Ээрдэг хүүхдийг тооцохгүй)				
5	Бичмэл болон дармал үсэгнээс зөв уншиж чадна.				
	IV. Бичих				
1	Цагаан толгойн үсгийг сонсоод зөв бичиж чадна				
2	Үг, өгүүлбэрийг сонсоод зөв бичиж чадна				
3	Урт, хос эгшиг, Я-гийн төрлийн үсэг орсон үе, үгийг сонсоод алдаагүй бичнэ				
4	Бичиглэл төстэй үсгүүдийг хольж солихгүйгээр зөв бичиж чадна. (Жишээлбэл: н-п, бичмэлээр том Р-Г)				
5	Үсэгнүүдийг бичмэл, дармалаар зөв бичиж чадна				
	V. Тоо бодох				
1	Хуруугаараа тоолохгүйгээр 10-ын дотор нэмж, хасч чадна				
2	Орон хэтрүүлэн нэмэх, орон шилжүүлэн хасах үйлдлийг ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд бодож чадна				
3	Ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд өгүүлбэртэй бодлого бодож чадна				
4	Хүрдээ цээжилсэн				

VI. Цаг хугацаа, орон зай, учир шалтгааны холбоо хамаарлыг ойлгох					
1	Яагаад ийм зүйл болсон тухай шалтгааныг зөв ойлгож чадна				
2	Байрлал, орон зайг илэрхийлсэн үг хэллэг (баруун зүүн тал, зүүн баруун өмнөд хойд зүг гэх мэт)-ийг зөв ойлгодог				
3	Дүрсийг зөв хуулж зурж чадна				
4	Цаг хараад зөв хэлж чаддаг, цаг хугацаа заасан үг хэллэгийг зөв ойлгодог				
VII. Булчингийн хөдөлгөөн					
1	Хайч барих, товч товчлох зэрэг гарын жижиг булчингийн хөдөлгөөнөөр хийдэг үйлдлийг эвлэг хийж чаддаг				
2	Үсэг, үгийг элементийн дагуу сайхан бичиж чаддаг				
3	Дээс тоглох, бөмбөг шидэхдээ ангийн хүүхдүүднйн ижил түвшинд хийж гүйцэтгэж чадна				
4	Турник болон матраас дээр хийдэг дасгалуудыг ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд хийж чадна				
VIII. Хүнтэй харилцах харилцаа					
1	Завсарлагааны үеэр болон хичээлийн дараа найзуудтайгаа тоглоно				
2	Дурмийг мөрдөж тоглож чадна				
3	Харилцаж байгаа хүүхэддээ санаа тавьж, хамтран үйл ажиллагаа хийж чадна				
4	"Түр өгч байгаач", "Баярлалаа", "Уучлаарай" зэрэг үгийг зөв хэрэглэж чадна				
IX. Үйлдэл хийх					
1	Зорилгодоо хүрэх төлөвлөгөө гаргана, заавар аваагүй ч зохих ёсоор нь үйлдэл хийж чадна.				
2	Сонирхлоо бууруулахгүй, биеэ зайлах зэрэг хөдөлгөөн хийлгүй асуудалд төвлөрч чадна.				
3	Мартаж эсвэл алдаж гээлгүйгээр эд юмсаа авч явах, эргэн тойрондоо тараахгүйгээр юмаа цэгцэлж чадна.				
4	Өөрийн дураар, эмх замбараагүй ярихгүй, эсрэг хүний яриаг дуустал сонсож чадна.				
5	Сэтгэлийн хөөрөлд авталгүй тайван байж үйлдэл хийж чадна.				
6	Гэнэтийн үйл явдал тохиолдоход сэтгэл санаагаа удирдаж, өөрчилж чадна.				
НИЙТ					

Энэ шалгах хуудсыг туршилтын 3 ердийн сургуулийн 1-5 дугаар анги буюу бага боловсролын багш нарт өгч өөрийн даасан ангийн хүүхдүүдээс сонгон “Чадна (4 оноо)”, “Бага зэрэг чадна (3 оноо)”, “Бараг чадахгүй (2 оноо)” “Огт чадахгүй (1 оноо)” гэсэн үнэлгээгээр үе тэнгийн хүүхдүүдийн дундажтай харьцуулах шалгууураар дүгнэсэн. Нийт 702 сурагч судалгаанд оролцсоноос бүх асуултыг гүйцэд дүгнэсэн бол түүвэрлэн авч, дутуу бөглөсөн бол хассан дүнгээр 686 хүүхдийн судалгааны дүнд боловсруулалт хийв. Тэмдэглэл хөтөлсөн багш нарын хүүхдэд өгсөн үнэлгээ ялгаатай тул доорх хүснэгтэд үзүүлсэн дүгнэлтүүд зөрүүтэй байгаа бөгөөд тухайн хүүхэд сурлагын хувьд эсвэл бие бялдарын хөгжлийн хувьд мэдэгдэхүйц ялгаатай байдаг нь харагдаж байна.

Хүснэгт 33 Аль нэг чадварын хувьд доголдолтой хүүхдийн тоо, дундаж (“Бараг чадахгүй”, “Огт чадахгүй”–д хамаарна)

Тооцоолон бодох	Бичих	Унших	Үйлдэл хийх	Ярих	Сонсох	Танин мэдэхүй	Хүнтэй харилцах	Булчингийн хөдөлгөөн
28	20	19	13	10	10	8	7	5
4.08%	2.92%	2.77%	1.90%	1.46%	1.46%	1.17%	1.02%	0.73%

Төслийн багаас шалгах хуудас боловсруулж хүүхдийн хөгжлийн ай тус бүрээр тухайн асуудлын шалтгаан, тэдэнтэй ажиллах арга зүйн санаануудыг оруулан “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж” боловсруулсан. 2018 оны 10 сард тус гарын авлагыг танилцуулах, зөвлөмж өгөх сургалтыг туршилтын ердийн 10 сургуулийн багш нарт зохион байгуулсан ба сургууль бүр нэг хүүхдийг сонгон арга зүйн сургалт хийсэн. 2019 оны 03 дугаар сард багшлах арга зүйг сайжруулах сургалтаар сонгосон хүүхдэд гарсан өөрчлөлтийн талаар тайлант хэлэлцүүлэг явуулж, сонгосон жишээг гарын авлагад оруулсан.

b) Ердийн сургууль дээрх тохирох хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх чадавхыг сайжруулах

“Төсөл эхлэхээс өмнөх байдал”

“Төслийн дэмжлэг, сургалт” эхлэхээс өмнө туршилтын ердийн сургуулиуд суралцаж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог доорх хүснэгтэд үзүүлэв .

Хүснэгт 34 Нийслэлийн туршилтын ердийн сургуульд суралцаж байсан өгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо (2017 оны 02-р сарын байдлаар)

Сургуулийн нэр	Дүүргийн нэр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
16-р сургууль	Сүхбаатар дүүрэг	10
35-р сургууль		11
28-р сургууль	Баянгол дүүрэг	20
113-р сургууль		10
79-р сургууль	Баянзүрх дүүрэг	111
111-р сургууль		12
26-р сургууль	Хан-Уул дүүрэг	12
34-р сургууль		74
Нийт		260

Нийслэлийн туршилтын ердийн сургуулиудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг таатай хүлээж авдаг, цааргалж хүлээж авдаг зэргээр сургууль бүр харилцан адилгүй хандлагатай байв. Хамран сургах тойргийн сургуульдаа сурах хүсэлтээ илэрхийлж байвч төвөгтэй талаас нь харж гэрийн ойролцоох тусгай сургуульд суралцахыг санал болгох сургуулийн жишээ гарч байсан. Хөвсгөл аймгийн ердийн сургуулийн хувьд орон нутагт тусгай сургууль байхгүй учир голдуу НҮБ-ийн Хүүхдийн сангийн төслийн хүрээнд байгуулсан хүүхэд хөгжлийн төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч байсан. Сургууль хүлээн авч сургах сонирхолтой хэдий ч сургуулийн орчин, тохирох хэрэглэгдэхүүн бүрдэж чадаагүй байсан. Тухайлбал: тэргэнцэртэй хүүхэд суралцдаг ч

биеийн тамирын хичээлд оролцох боломжгүй, ангидаа хүлээж өнгөрүүлэхээс аргагүй, эсвэл өөрийн ангийн хичээлийн хөтөлбөрөө гүйцэж чадахгүй бол дэвтэртээ ямар нэг өөр сэдвээр хуулан бичлэг хийхгүй бол болохгүй зэрэг асуудлууд тулгардаг байсан.

“Төслийн дэмжлэг, сургалт”

Төслийн багаас сургуулийн орчинг сайжруулах тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, хүүхэд хөгжлийн төв байгуулах, сургуулийн дэмжлэгийн баг байгуулах, сургуульд хамрагдалтыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулсан.

- Сургуулийн орчинг сайжруулах тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн

Дээр дурдсанчлан 2017 оны 02 дугаар сард мэргэжил арга зүйн баг, туршилтын тусгай сургууль, Улаанбаатар хотын туршилтын ердийн сургуулийн төлөөлөл, холбогдох хүмүүсийг цуглуулан, ердийн сургуулийн өнөөгийн байдал, тэдний хэрэгцээг дахин нягталж, хуралдсан. Тус хурлаар тодорхой болсон хэрэгцээг хэлэлцэж, БСШУСЯ, Нийслэлийн боловсролын газартай зөвлөлдөн, 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, туршилтын ердийн сургуулийн багш нарыг дадлагажуулах ажлаар тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх гэдэг нь чухам ямар агуулгатай гэдгийг ойлгож, өөрсдийн сургуульдаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан. Эхлээд Япон дахь ЖАЙКА Ёкохама сургалтын төвд 2015 онд зохион байгуулсан “Тэгш хамруулан сургах, тусгай хэрэгцээт боловсролын чанарыг сайжруулах” сэдэвт сургалтын оролцогч МУБИС, БоСС-ийн багш Э.Мөнхбат өөрийн сурсан зүйл, сургалтын талаар танилцуулж тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд анхаарах зүйлийн талаар мэдээлэл өгсөн ба дараа нь сургууль тус бүр хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхэд хүлээн авч, тусгай сургуулийн багш нараас зөвлөгөө авч, хүүхдэд тулгараад байгаа асуудлууд болон түүнийг шийдвэрлэх арга замуудыг хамтран хэлэлцэж, сайжруулах төлөвлөгөө боловсруулсан. Төслийн багаас хэрхэн дэмжих боломжтой, сургуулийн зүгээс юу хийх, хүүхдийн өөрийн болон ар гэрийн зүгээс юу хийх боломжтойг хөтөлбөрт тусган оруулсан. Жишээ болгон 35 дугаар сургуулийн сурагчийн төлөвлөгөөг оруулав.

Хүснэгт 35 СБД-ийн 35-р сургуулийн сонгосон хүүхдэд тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх төлөвлөгөө

Зорилтот хүүхэд: 4-р анги, эрэгтэй хүүхэд				
Тэргүүлэх дараалал	Тулгамдаж буй асуудал	Хэрхэн шийдвэрлэх вэ?	Шийдвэрлэхэд сонголт хийх боломжтой саналууд	Хэрэгжүүлэх үе
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах орчин болон туршлага дутагддаг	Төсөлтэй хамтран Хүүхэд хөгжүүлэх төв байгуулж, тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн багш, оюутнууд сайн дураар хамтран ажиллах.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэн, хичээлийн дараа Хүүхэд хөгжүүлэх төвд (Кабинет) давтлага өгөх. Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн сайн дурын багш, оюутнуудыг ажиллуулах.	2017.05 сар
2	Хичээлийн үед босч яван бусад хүүхдэд саад болдог	Зорилтот хүүхэд сонирхохоор сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, эсвэл худалдаж авах. (Машины зурагтай карт, эвлүүлдэг зураг, төрөлжүүлдэг болон эвлүүлдэг, наах, будах боломжтой сургалтын хэрэглэгдэхүүн)	Хүүхдийн сонирхолд нийцүүлэн машины зурагтай карт, тоглоом зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг худалдаж авах.	2017.05 сар
3	Зорилтот хүүхдийн ХБ-ийн талаар нарийн мэддэггүй тул арга зүйгээ сайн мэдэхгүй	Зорилтот хүүхдийн ХБ-ийн онцлог болон хүндрэлтэй талыг мэдэж авах.	Төсөлтэй хамтран “Тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан хэрэглэгдэхүүн”-ийг турших.	2017.09 сар
4	Зан төлвийн асуудалтай (Ангид орилж хашгирдаг, хичээлийн дундуур суудлаасаа босч явдаг, үймүүлдэг)	Зорилтот хүүхдийг эргэн тойрны дуу чимээнээс зайдуу суулгах.	Ангид тайван суух боломжтой, чимээ багатай булан бий болгох.	2017.11 сар

5	Богино өгүүлбэрээр /үг/ ярих.	Зорилтот хүүхдэд ойлгомжтой бүтэн өгүүлбэрээр ярьж сургах. Харилцан ярилцаж сургах.	Зураг, бичгийг тааруулдаг сургалтын хэрэглэгдэхүүн худалдаж авах. Сайн сонсоод зөв өгүүлбэр, буруу өгүүлбэрийг ялгаж сургах. Зурагтай карт ашиглан өгүүлбэр зохиох.	2017.09.01-12.25
6	Бусдын эд зүйлийг дураар авах.	Эзнээс нь зөвшөөрөл авч хэрэглэхэд сургах. Зөвшөөрөл авч байж хэрэглэх ёстой болохыг ойлгуулах.	Бусдын эд зүйлийг дураар авч болохгүй гэдгийг ойлгуулах зураг болон бичлэг үзүүлэн, үлгэр сонсгож ойлгуулах.	2017.12 сар

2017-2018 оны хичээлийн жилд сургууль тус бүрийн боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдсан. Тус төлөвлөгөөг бодитоор хэрэгжүүлэхэд шаардагдах төсөвийн санал авсны, үндсэн дээр төслийн багаас тус бүр 2 сая төгрөгийн[8] дэмжлэг үзүүлэн сургалтын хэрэглэгдэхүүн авах, орчин бүрдүүлэх засварын ажил зэргийг хийсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө, хана, шатны бариул, гадаа налуу зам хийх зэрэг сургууль бүр төлөвлөгөөнийхөө дагуу ажлыг хийж гүйцэтгэсэн. 2018 оны 06 дугаар сард тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлсэн сургуулиудын тайлан уулзалтыг зохион байгуулж, харилцан туршлагаа солилцох боломжийг бүрдүүлсэн.

- Хүүхэд хөгжлийн төв байгуулсан

  Дээрх тохирох хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх төлөвлөгөөнд 8 сургуулийн 4 нь “Хүүхэд хөгжлийн төв” байгуулах асуудлыг төлөвлөгөөндөө тусгасан. Хүүхэд хөгжлийн төв нь ердийн сургуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хичээлийн бус цагийг ашиглан сурлагын хоцрогдлыг арилгах, эсвэл бэрхшээлийнх нь онцлогт нь тохирсон дэмжлэг үзүүлэх зориулалтаар байгуулсан. 4 сургууль нь өрөө тасалгаагаа сонгон, доторх тохижилт, хэрэглэгдэхүүн бэлдэх болон тэнд багшлах багш нарыг сургах зэргээр бэлтгэл ажлуудыг хийж 2017 оны 11 дүгээр сард төвийн үйл ажиллагаагааг эхэлсэн. Зөвхөн анги удирдсан багш ажиллахад хүндрэлтэй гэсэн санал гарч байсантай холбоотой төслийн мэргэжил арга зүйн багийн гишүүн МУБИС-ийн багш болон БСШУС-ын яамтай зөвшилцсөн МУБИС-ийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхмийн 10 оюутныг төвийн туслах багшаар ажиллуулав. 2017 оны 11 дүгээр сараас 2018 оны 03 дугаар сар хүртэл төслөөс оюутан туслах багшийн зардлыг төлж байсан ба 2018 оны 10 дугаар сараас хойш БСШУСЯ хариуцаж эхэлсэн. Мөн 2018 оны 06 дугаар сард зохион байгуулсан

[8] 2019 оны 06 дугаар сарын валютын ханшаар 83,700 иен

тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх үйл ажиллагааны тайлан уулзалтад Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа багш нарын илтгэлийг сонссон ХУД-ийн 34 дүгээр сургуулийн захирал өөрийн сургууль дээрээ 2018 оны 10 дугаар сард хүүхэд хөгжлийн төвийг нээсэн. 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд, сургуулийн хүүхэд хөгжлийн төвд хамрагдсан хүүхдүүдийн тоог доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 36 Хүүхэд хөгжлийн төвд хамрагдсан хүүхдийн тоо

Сургуулийн нэр	2017/2018 оны хичээлийн жилд	2018/2019оны хичээлийн жилд
16-р сургууль	11	16
28-р сургууль	4	4
34-р сургууль	-	13
35-р сургууль	4	2
79-р сургууль	2	7
Нийт	21	42

- Сургуулийн дэмжлэгийн баг байгуулсан

2018 оны 01 дүгээр сард зохион байгуулсан Япон дахь сургалтад, зорилт 2-ын холбогдох оролцогчид Канагава мужийн Фүжисава хотын сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл болон сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагаатай танилцан, туршлагаас нь суралцсан. Сургалтад оролцсон Нийслэлийн туршилтын ердийн 4 сургууль (26, 28, 35, 79) болон Хөвсгөл аймгийн 2 сургууль, өөрийн сургуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй болон боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургуулийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангах зорилгоор “Сургуулийн дэмжлэгийн баг” байгуулахыг Монголд буцаж ирээд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан.

2018 оны 04 дүгээр сард төслийн мэргэжилтнүүд Хөвсгөл аймгийн туршилтын 2 сургууль дээр ажиллан, Японы сургуулийн дэмжлэгийн багийн тогтолцооны талаар хичээл заан, дэмжлэгийн багийн зорилгыг хэрхэн тодорхойлох, хэн юу хариуцаж ажиллах жилийн ажлын төлөвлөгөөний хуваарь гаргах гэх мэт бэлтгэл ажлын талаар хэлэлцэж зөвшилцөв. 2 сургууль дээр 04 дүгээр сарын эцсээр сургуулийн дэмжлэгийн баг байгуулах захирлын тушаал гарч, гишүүдийг томилон жилийн ажлын төлөвлөгөөг баталсан. Жишээ болгон Хөвсгөл аймгийн Ирээдүй 21 зуун цогцолбор сургуулийн захирлын тушаалаар батлагдсан гишүүд болон жилийн ажлын төлөвлөгөөг хүснэгт 37-д үзүүлэв.

Хүснэгт 37 Сургуулийн дэмжлэгийн багийн гишүүд болон үйл ажиллагааны төлөвлөгөө

Гишүүд	
Захирал	Сургалтын менежер /бага анги/
Сургалтын менежер /дунд анги/	Мэдээллийн технологийн багш
Сургуулийн эмч	Хөгжүүлэх төвийн 2 багш
Биеийн тамирын багш	Технологийн багш
Хөгжмийн багш	Бага ангийн багш
БАЗАН-ийн ахлагч	
Жилийн ажлын төлөвлөгөө	
Дэмжлэгийн баг байгуулах	2018.04
Дэмжлэг шаардлагатай хүүхдийн жагсаалт гаргах	2018.05
1-р хурал	2018.05
Бодит байдлын судалгаа хийх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах	2018.05
2-р хурал	2018.08
Төлөвлөгөөнд хяналт тавих	2018.08
Шинээр ирсэн хүүхдийн судалгаа хийх	2018.09
3-р хурал (шинэ хүүхдэд)	2018.10
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах	2018.10
4-р хурал	2018.11
Төлөвлөгөөнд хяналт тавих	2018.11
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд мониторинг хийх	2018.12
5-р хурал	2019.01
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийх	2019.01

2018 оны 06 дугаар сард тохирох хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлсэн талаар тайлангийн уулзалт зохион байгуулахад Хөвсгөл аймгийн туршилтын ердийн сургуулийн “Сургуулийн дэмжлэгийн баг” байгуулсан тухай хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулсан. Үүний үр дүнд Нийслэлийн 8 ердийн сургууль 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн дэмжлэгийн багийг ээлж дараагаар байгуулсан.

- Сургуульд хамрагдалтыг дэмжих

Туршилтын ердийн сургуулийг түшиглэн, сургуулийн насны сургуульд хамрагдаагүй хүүхдүүд болон 1 дүгээр ангид элсэн орох хүүхдүүдийн сургуульд ороход нь дэмжлэг шаардлагатай байгаа тохиолдолд шийдвэрлэвэл зохих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

- Хан-Уул дүүргийн 26-р дунд сургууль нь төвөөс 35 км алслагдсан сургууль юм. Сургуулийн ойролцоо амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамгийн ойрхон 63 дугаар тусгай сургуульд хамрагддаг, гэхдээ 63 дугаар сургууль хүртэл 20 км зайтай, нийтийн тээвэр, автобус ховор шалтгаанаас үүдэн бүртгэлтэй боловч өдөр тутам сургуульдаа ирж, очиж чаддаггүй байсан. 26 дугаар сургууль нь 2015 онд хорооны хэмжээнд сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн судалгаа хийхэд хөгжлийн бэрхшээлийн улмаас сургууль завсардсан 6-18 насны

9 хүүхэд байгааг тогтоосон ба тэдгээр хүүхдүүд болон эцэг эх нь ойрхон сургуультай болоосой гэсэн сэтгэгдлээ илэрхийлж байсан. Сургууль, эцэг эх, асран хамгаалагч, төслийн хооронд хэлэлцэж, хуралдсаны үндсэн дээр 2016 оны 03 дугаар сараас, сар бүр 2 удаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтыг явуулахаар болсон. Сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээж авах байр, танхим бэлдэх боломжтой бөгөөд БСШУСЯ болон Хан-уул дүүргийн Боловсролын хэлтэстэй уулзалт хийсэн. Үүний үр дүнд 2018 оны 02-р сард 63 дугаар сургуулийн нэг салбар бүлэг 26-р сургууль дээр нээгдсэн. 2019 оны 03 дугаар сарын байдлаар 12 хүүхэд суралцаж байгаа бөгөөд үндсэн 1 багш, орон тооны бус 1 туслах багш 1 ажиллаж байна.

- Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар 2018 оны 09 дүгээр сараас 1 дүгээр ангид элсэн орох бүх хүүхдийг сургуульд хамруулах зорилт тавин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бодит байдлыг судалж үзсэн. Салбар комиссоос элсэн орох сургуулийг шийдвэрлэж өгч байгаа боловч шийдвэрийн дагуу элсэн орж, өдөр тутам ирж, очих боломжгүй тохиолдол гарч байсан тул салбар комисс, цэцэрлэг, сургууль хамтарч сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж эхэлсэн. Эхний удаагийн хурлыг 2018 оны 05 дугаар сард хийсэн. 2018 оны 09 дүгээр сараас шинээр сургуульд элсэх эмэгтэй хүүхдийг сонгон, Салбар комиссын гишүүд болон тойргийн сургуулийн нийгмийн ажилтан, сонгогдсон хүүхдийн харьяалагддаг багийн засаг дарга, Мөрөн сумын нийгмийн ажилтан зэрэг хүмүүс хамтран сургуульд хамрагдахад гарч буй хүндрэл бэрхшээл, аль салбараас яаж дэмжлэг үзүүлэх, зэрэг асуудлыг шийдвэрлэх талаар хэлэлцсэн. 02 дугаар хурал 2018 оны 06 дугаар сард зохион байгуулж, хүлээн авах сургуульд хэрхэн суралцах, ариун цэврийн өрөө хэрхэн бэлдэх гэх мэт орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах талаар хэлэлцэв. 2019 оны 09 дүгээр сараас эхлэн сонгогдсон хүүхэд Титэм 2 дугаар сургуулийн хүүхэд хөгжлийн төвд суралцаж, биеийн тамир, хөгжмийн хичээл зэрэгт бүртгэлтэй ангидаа очиж бусад хүүхдүүдтэй хамт оролцдог тогтолцоо бүрдээд байна. 2019 оны 03 дугаар сард тухайн жилдээ 1 дүгээр ангид элсэн орох хүүхдүүдийн дотор, дэмжлэг шаардлагатай гэж үзсэн хүүхдүүдийг сургуульд хамруулан, өдөр тутамд хичээлд явж чадах боломжоор хангах талаар Салбар комисстой хамтран хурал зохион байгуулсан.

“Төслийн үр дүн”

Тохирох хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулах, хүүхэд хөгжлийн төв байгуулах, сургуулийн дэмжлэгийн баг байгуулах, сургуульд хамрагдалтыг дэмжих тогтолцоогоор дамжуулан туршилтын ердийн сургуулиудад тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх, чадавх бэхэжсэн гэж болно. Тухайлбал:

- Хэд хэдэн багш нар нийлээд тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх асуудлыг

хэлэлцсэнээр, тулгамдсан асуудалтай хүүхдийн бодит байдлын талаар улам сайн мэдээлэлтэй болж нэгдсэн ойлголттой болсон.

- Сонгосон хүүхдийн хэрэгцээт орчин бүрдүүлснээр сурлагад нь ч бие даах энгийн чадварт нь ч ахиц гарсан.
- Салбар комисс болон багийн нийгмийн ажилтан зэрэг хүмүүс хамтран зөвлөлдөж шийдвэрлэх арга зам, гарцыг эрэлхийлдэг болсон.

Туршилтын ердийн сургуульд тохирох хэрэглэгдэхүүн боловсруулсан, сургуулийн дэмжлэгийн баг байгуулсан жишээг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага”-д тусгав.

Мөн сургуульд хамрагдалтыг дэмжихдээ жил бүр ямар хугацаанд аль байгууллага хариуцан хуралдах, дэмжлэг шаардлагатай хүүхдийн асуудлыг шийдвэрлэхдээ хэн хэрхэн хэрэгжүүлэх гэх мэт тогтолцооны асуудал байсаар байна. Хөвсгөл аймагт 05 дугаар сарын 23, 06 дугаар сарын 24-ний өдөр Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж туршив. Энэ туршлага дээр үндэслэн хурал зохион байгуулах журам зэрэг баримт бичгийг аймгийн засаг даргын захирамжаар батлахаар төлөвлөж байна.

05 дугаар сарын 03-нд Баянгол дүүргийн засаг даргаас дүүргийн хэмжээнд сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг хуралдуулах, сургууль бүр “Сургуулийн дэмжлэгийн баг”-ийг байгуулж үйл ажиллагааг эхлүүлэх чиглэл өгсөн ба 08 дугаар сарын 25-ны өдөр Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн анхдугаар хуралдаан зохион байгуулагдах төлөвлөгөөтэй байна.

1-3-4 Зорилт 3-ын үйл ажиллагаа

Зорилт 3 : Бичил төсөл хэрэгжүүлэх замаар тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төрөл бүрийн боловсрол, сургалтын арга хэлбэрийг туршин хэрэгжүүлж, үр дүнг судална.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсролын шинэчлэлийн бодлогыг бичил хэмжээний туршилтын үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх зорилгоор 2016-2017 болон 2017-2018 оны хичээлийн жилд 2 удаа бичил төсөл шалгаруулахаар зарлан тэнцсэн байгуулагыг сонгон төсөл хэрэгжүүллээ.

Анх 2016.04.08-нд сонгон шалгаруулалтыг хийсэн. Төсөл шалгаруулахад тавигдах шаардлагыг дор үзүүлэв.

- Бичил төслийн үр өгөөжийг хүртэгч нь тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай (0-16 нас) хүүхдүүд байх.
- Тухайн орон нутагтаа бичил төслийг хэрэгжүүлэх нөөц боломжтой нөөцтэй байх.
- Бичил төслийн хугацаа дуусанаас хойш үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлсэн байх.
- Бичил төсөл хэрэгжиж дуусаны дараа үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх

боломжтой, хөрвөх чадвартай байх

Нийслэл болон орон нутгаас нийт 35 төслийн санал хүлээн авсан Эдгээрээс дээрх шаардлагыг хангасан 8 төслийг эцсийн жагсаалтад оруулан 2016 оны 05-06 дугаар саруудад эдгээр 8 төслийг ирүүлсэн байгууллагуудаар тойрч уулзалт хийсний эцэст 3 төслийг сонгон шалгаруулсан. Тус 3 төслийн хэрэгжилт болон үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 38 Эхний удаагийн бичил төслийн хэрэгжилтийн агуулга, үр дүн

1	Төслийн нэр	“Оюуны бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд боловсролын тэгш оролцоог хангах нь” төсөл
	Хэрэгжүүлсэн байгууллага	Монголын Дауны холбоо ТББ
	Хэрэгжүүлсэн орон нутаг	Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг
	Хэрэгжсэн хугацаа	2016.06.17-2017.05.23
	Санхүүжилт	10, 000, 000 төг
	Үр өгөөжийг хүртэгч	Монголын Дауны холбооны хүүхдүүд болон ерөнхий боловсролын 130 дугаар сургуульд хамрагдсан хүүхдүүд
	Төслийн агуулга	Нийслэлийн Хан-Уул дүүргийн 130 сургуульд туршилтын бүлэг нээж, Монголын Дауны холбооны дэргэдэх “Хөгжил” сургалтын төвд хамрагдсан хүүхдүүдийг сурган, ердийн ангийн хүүхдүүдтэй биеийн тамир, дуу хөгжим, зургийн хичээлд хамтдаа ордог.
	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	➢ Туршилтын бүлгийн 10 сурагч, 130 дугаар сургуулийн 3А, 4А, 5А ангийн хүүхдүүдтэй биеийн тамир, дуу хөгжмийн хичээлд хамт ордог. ➢ 2 долоо хоногт 1 удаа бямба гаригт туршилтын бүлгийн анги удирдсан багш нь бүжгийн дугуйлан хичээллүүлж, ердийн ангийн хүүхдүүдийг хамруулан хамтдаа бүжиглэдэг болсон. ➢ 2017.03 дугаар сард эцэг эхчүүдэд зориулж “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан. Бага боловсролын нийт 10 бүлгийн бүх эцэг эхчүүдийг урьж, Монголын Дауны холбооноос танилцуулга хийж, даунтай хүүхдүүдийн онцлогийг ойлгон, тэгш хамруулан сургахын чухлыг онцолж уулзалт хийсэн. 130 дугаар сургуулийн багш нар бэлтгэл ажилд тусалж хамтран хэрэгжүүлсэн. ➢ Тус туршилтын бүлгийн хүүхдүүдийг 130 дугаар сургуульд албан ёсоор сурагчаар бүртгэн, нийслэлийн боловсролын газраас үдийн хоолны хөтөлбөрт хамруулсан.
	Гарсан үр дүн	➢ 130 дугаар сургуулийн багш, эцэг эхчүүд эхэндээ дауны хам шинжтэй, оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар ойлголт нимгэн байсан боловч туршилтын бүлгийн багш сургалт хийж тогтмол ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулж тайлбарлан тусалсны үр дүнд аажмаар дасч тэднийг ойлгодог болсон. ➢ Төсөл хэрэгжиж дууссаны дараа Монголын Дауны холбоо үргэлжлүүлэн үйл ажиллагаагаа явуулж, багшийн цалинг асран хамгаалагчдын төлбөрөөс гаргаж байсан хэдий ч, 2018.02 сард 63-р тусгай сургуулийн харьяа анги болгосон.
2	Төслийн нэр	“Бид чадна” (Албан бус сургалтаар насан туршийн боловсрол олгох төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах төсөл)
	Хэрэгжүүлсэн байгууллага	Орхон аймаг, “Албан бус сургалтаар насан туршийн боловсрол олгох төв”
	Хэрэгжүүлсэн орон нутаг	Орхон аймаг, Баян-Өндөр сум
	Хэрэгжсэн хугацаа	2016.06.20-2017.05.23
	Санхүүжилт	10, 000, 000 төг

	Үр өгөөжийг хүртэгч	“Насан туршийн боловсрол олгох төв”-д суралцах хүүхдүүд
	Төслийн агуулга	Сургуульд хамрагдаж чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд албан бус боловсролоор боловсрол олгох. Сургалтын төвд ирж сурах боломжгүй хүүхдүүдийн гэрээр очиж явуулын сургалт зохион байгуулна.
	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	➢ Тус төвд албан ёсны бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхэд хамрагддаг ба бэрхшээлийн хүнд, хөнгөн, ар гэрийн амьдралын бололцооноос хамаарч гэрээр нь очиж сургалт явуулах тохиолдол бий. ➢ Төвийн сургалтыг 3 багш хариуцан, унших, бичих, өөртөө үйлчлэх энгийн чадваруудыг эзэмшүүлэх талаар түлхүү заадаг. ➢ 2016 оны 10 дугаар сард дээрх 3 багш Нийслэлийн тусгай сургуулийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалж, багшлах арга зүй нь дээшилсэн. ➢ Эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж, гэрийн нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах талаар заасан. ➢ Нийгэмшихүйн чадварыг хөгжүүлэх зорилгоор музей үзэх, олон нийтийн үйл ажиллагаан дээр дуу дуулуулах гэх мэт үйл ажиллагаа зохион байгуулсан. ➢ Насан туршийн боловсролын төвийн 25 хүүхдээс 1 хүүхэд бүрэн дунд, 4 хүүхэд суурь боловсролын гэрчилгээ авч төгссөн.
	Гарсан үр дүн	➢ Ямар нэг хүндэтгэх шалтгаанаар сургууль завсардсан хүүхдүүдийг албан бус боловсролд хамруулан, боловсролын гэрчилгээ албан ёсоор олгосон. ➢ Суурь боловсролын гэрчилгээтэй хүүхдүүд дараагийн шатны сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцах боломжтой болсон.
3	Төслийн нэр	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй хүүхэд харах үйлчилгээ”
	Хэрэгжүүлсэн байгууллага	Хүүхдийн хөгжил мэдээллийн “Учрал төв” ТББ
	Хэрэгжүүлсэн орон нутаг	Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг
	Хэрэгжсэн хугацаа	2016.06.17-2017.05.23
	Санхүүжилт	10, 000, 000 төг
	Үр өгөөжийг хүртэгч	Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа, мөн шинээр хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний асран хамгаалагчид, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх хүмүүс
	Төслийн агуулга	“Хүүхдийн төлөө үндэсний газар”-аас 2016.01 сараас хэрэгжүүлж эхэлсэн “Хүүхэд харах үйлчилгээ” нь 2-5 насны хүүхдийг харах шинэ бүтэц юм. 18-65 насны хүмүүс (Хүйс харгалзахгүй) болон төрийн бус байгууллага хүүхэд харах үйлчилгээ эрхлэхийг хүсвэл сургалтад хамрагдан, шалгалт өгч, харьяа засаг даргын тамгын газар болон хүүхдийн төлөө үндэсний газарт хүсэлт гарган, зөвшөөрөл авч хувийн болон байгууллагын байрандаа ойр орчмын хүүхдүүдийг харах үйлчилгээ үзүүлнэ. Энэ үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулахаар заасан боловч, одоогийн сургалтын агуулгад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харьцах, тэднийг хэрхэн сургах, заах аргын талаар заавар зөвлөмж байхгүй тул энэхүү бичил төслөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг харж асрахад шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэх сургалтын модул боловсруулж, төсөл хэрэгжүүлэх дүүргүүдэд сургалтууд зохион байгуулна.
	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	➢ Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж байгаа хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хардаг эцэг, эхийг оролцуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, харах, талаар мэдлэг, хандлагыг тандах судалгааг зохион байгуулж, түүнийхээ дүгнэлтэд үндэслэн хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан сургалтын модул

		боловсруулсан. ➢ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй хүүхэд харах үйлчилгээний “Хүүхэд харагчийн ур чадвар” сургалтын 6 модуль боловсруулж, 2017.03 сард 16 цагийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтад Нийслэлийн төвийн 6 дүүргийн хүүхэд харагч 55 хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ хардаг 25 эцэг, эхийн төлөөлөл, нийт 80 хүн оролцсон. ➢ Мөн Нийслэлийн төвийн 6 дүүргийн хариуцсан мэргэжилтнүүдийн хамтаар эцэг эх, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд зориулж, хүүхдийн эрх, хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн мэдлэг олгох мэдээлэл өгөх үйл ажиллагаа зохион байгуулсан.
	Гарсан үр дүн	➢ Хүүхэд харах үйлчилгээнд одоогийн байдлаар 18 нас хүртэлх хүүхдийг хамруулах боломжтой бөгөөд эцэг эхийн холбооноос явуулдаг өдөр өнжүүлэх үйлчилгээнд мөн хамруулдах боломжтой. ➢ Баянзорх, Баянгол, Хан-уул дүүргийн хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд зориулж, тус бүр нэг удаа сургалт зохион байгуулсан. Хүүхэд харах үйлчилгээний хүний нөөц өөрчлөгдөх тохиолдол их байдаг тул дахин давтан сургалтуудыг явуулсаар байна.

2 дахь жилийн бичил төслийн сонгон шалгаруулалтыг 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс, 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл зарлан Нийслэл болон орон нутгаас нийт 101 төсөл хүлээн авсан. Эхний шатанд төслүүдийн баримт бичгийг уншиж хянан, шалгаруулсны дараа 2 дахь шатанд баримт бичгийн талаар утсаар, цахим шуудангаар тодруулга хийж шалгаруулан, 3 дахь шатанд ярилцлага хийсний эцэст 3 төслийг сонгосон. 2 дахь жилийн төсөл хэрэгжүүлэх үед төгрөгийн ханшийн өөрчлөлтийг тооцон, төслийн санхүүжилтийг 12, 000, 000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Шалгарсан 3 төслийн хэрэгжилт, гарсан үр дүнг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 39 2 дахь удаагийн бичил төслийн хэрэгжилтийн агуулга, үр дүн

1	Төслийн нэр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрт оролцооны хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах
	Хэрэгжүүлсэн байгууллага	“Сонсголгүйн боловсрол” ТББ
	Хэрэгжүүлсэн орон нутаг	Үндэсний хэмжээнд (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)
	Хэрэгжсэн хугацаа	2017.10.17-2018.06.15
	Санхүүжилт	12, 000, 000 төг
	Үр өгөөжийг хүртэгч	Сонсголын бэрхшээлтэй хүүхэд болон оюуны бэрхшээлтэй хүүхдүүд
	Төслийн агуулга	Оюуны бэрхшээлтэй хүүхэд, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан зурагт карт, үсгийн картын иж бүрдэл боловсруулан тараана. 1 картад зураг, дохионы хэлний хурууны үсэг, кирил үсэг орно.
	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Дараах 3 төрлийн картыг боловсруулсан. - Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дохионы хэлний үгийн карт (1000 үг) 10 хайрцаг ➢ Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дохионы хэлний өгүүлбэрийн карт (300 өгүүлбэр) 10 хайрцаг ➢ Оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үгийн карт (200 үг) 10

		хайрцаг. Үйл үг, бие эрхтэн зэрэг сэдвүүдэд хуваан сэдэв тус бүрийг өнгөөр ялган хийсэн. Боловсруулсан нийт зардал: 1ш 800 төгрөг (12, 000, 000 төг÷15, 000ш) ➢ Төслөөр картын загвар хийгдсэн, картыг зүсэгч машин худалдаж авсан тул дараагийн хэвлэл илүү хямд байх боломж бүрдсэн. ➢ “Сонсголгүйн боловсрол” ТББ-ын сонсголын бэрхшээлтэй гишүүдээс бүрддэг онцлогтой ба тэд 29 дүгээр тусгай сургууль дээр хичээлийн дараа хүүхдүүдэд дохионы хэл заах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цаашид сонсголын бэрхшээлтэй иргэдэд боловсролын үйлчилгээ үзүүлдэг нөөц байгууллага болж өргөжих боломжтой. ➢ Оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан картыг Монголын дауны холбоо болон Монголын аутизмын холбоотой хамтран картад оруулах үгүүдийг сонгож орууласан. Цаашид бусад байгууллагатай хамтран картыг улам боловсронгуй болгох юм.
	Гарсан үр дүн	➢ Төслөөр хийсэн картыг 1) 29-р тусгай сургууль, 186 дугаар цэцэрлэгийн зарим ангид хэрэглэж туршихад багш, хүүхдүүд ойлгомжтой, авч явахад хялбар карт гэж үнэлсэн байв. Цаашид дохионы хэл мэдэхгүй эцэг эхчүүд ч хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломжтой. ➢ Тус картыг Facebook–ээр нийтэд мэдээлэхэд авах хүсэлтээ илэрхийлсэн хүмүүс олон байсан. Бичил төслийн хугацаанд картын загвар боловсруулж, карт зүсэгч машин худалдаж авсан тул олон тоогоор хэвлэж чадаагүй. Түүний дараа төслийн хэрэгжилтийн хугацаа дуусч эцсийн бүтээгдэхүүн хэвлэх үеэр “1000 үгтэй дохионы хэлний карт”-ын сайжруулсан хувилбарыг 500 багц хувиар хэвлэж, боловсролын холбогдох байгууллагуудад хүргүүлэв.
2	Төслийн нэр	“Сургуулийн өмнөх насны хүүхдийг боловсролд тэгш хамруулах төсөл”
	Хэрэгжүүлсэн байгууллага	МУБИС-ийн харьяа 249-р цэцэрлэг
	Хэрэгжүүлсэн орон нутаг	Нийслэлийн Баянгол дүүргийн 17-р хороо
	Хэрэгжсэн хугацаа	2017.10.18 - 2018.06.15
	Санхүүжилт	12, 000, 000 төгрөг
	Үр өгөөжийг хүртэгч	Баянгол дүүрэгт амьдарч буй сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
	Төслийн агуулга	Цэцэрлэгт явдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бүлгийн сургалтыг долоо хоногт 1 удаа зохион байгуулна. Мөн цэцэрлэгийн ангид хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдийг хамруулан сургаж багш нарын заах аргыг сайжруулна.
	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	➢ Төслийн хүрээнд 1) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд аюулгүй байхаар цэцэрлэгийн орчинг тохижуулсан. Ханын бариул болон бие засах өрөөг засч сайжруулсан. 2) Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бага боловсролын салбарт олон жил ажилллаж буй Япон улсын зөвлөх багш бүлгийн сургалт зохион байгуулсан. 3) Цэцэрлэгийн багш нар болон МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн оюутнуудад зориулан хөгжлийн

		бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт хүлээн авч ажиллах арга зүй, гарын авлага боловсруулах нөлөөллийн ажлыг хийсэн. ➢ Төслийн хугацаанд долоо хоногт 1 удаагийн бүлгийн сургалтад 3 хүүхэд, холимог бүлэгт 3 хүүхэд хүлээн авч 249 дүгээр цэцэрлэгийн багш нар төдийгүй МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн 18 оюутан дадлага хийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцсан. ➢ Баянгол дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран тус дүүргийн цэцэрлэгийн багш нарт зориулсан сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Энэ сургалтад ашигласан сургалтын материал болон бүлгийн сургалтын заах аргыг нэгтгэсэн гарын авлагыг төсөл 300 ширхэг хэвлүүлж оюутан, цэцэрлэгийн багш нарт тарааж өгсөн.
	Гарсан үр дүн	➢ Тус цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо олон бус боловч СӨБС-ийн оюутнуудын дадлагын хичээлийн бааз, бусад цэцэрлэгийн багш нарыг дадлагажуулах нөөц төвийн үүргийг гүйцэтгэж байгаа тул ердийн цэцэрлэгт тэгш хамруулах чиглэлээр тусалж дэмжих зорилготой. ➢ МУБИС, СӨБС-ийн сургуулийн багш нар бичил төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэгт орж, төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах тохиолдолд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. ➢ МУБИС, СӨБС-ийн номын санд төслийн эцсийн бүтээгдэхүүнүүдийг хуваарилж хүргүүлэв.
3	Төслийн нэр	“Хөгжлийн бэрхшээл - Хөгжих саад биш”
	Хэрэгжүүлсэн байгууллага	Ховд аймгийн 7-р бүрэн дунд сургууль
	Хэрэгжүүлсэн орон нутаг	Ховд аймаг, Жаргалант сум, Баатархайрхан баг
	Хэрэгжсэн хугацаа	2017.11.06-2018.06.15
	Санхүүжилт	12, 000, 000 төгрөг
	Үр өгөөжийг хүртэгч	Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар бүрэн дунд сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй сурагчид
	Төслийн агуулга	Сургуулийн 1 танхимыг хүүхэд хөгжлийн төв болгон тохижуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хичээлээс гадуурх үйл ажиллагаанууд, дугуйлан зэрэгт хамрагдах боломжийг бүрдүүлнэ. Урлаг спортын арга хэмжээ, хичээлээс гадуурх зохион байгуулж буй арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамрагдах боломжийг бүрдүүлснээр сурагчдын харилцан ойлголцлыг сайжруулж тэдний өөртөө итгэлтэй болоход тусална.
	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Бичил төслөөр 7 дугаар сургуульд хамрагддаг 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүдүүд хичээлээс гадуур үйл ажиллагаа болон дугуйлан зэрэгт хамрагдах боломжийг бүрдүүлсэн. Дэлгэрэнгүйг хүснэгтээс үзнэ үү.

№	Дугуйлангийн нэр	Хүүхдийн тоо	Үйл ажиллагааны агуулга	Багшийн тоо
1	Хараа засал	5	Хараа зүйн бэрхшээлтэй сурагчдад хараа сайжруулах хялар засах дасгалуудыг заасан.	2

2	Сонсгол засал	7	Сонсголын бэрхшээлтэй сурагчдад сонсгол засах дасгалуудыг заалаа.	2
3	Хөдөлгөөн засал	11	Хөгжимт хөдөлгөөнүүдийг зааж сурагчдын эв дүйг сайжруулж тодорхой түвшинд хөдөлгөөний хурдыг нэмэгдүүллээ.	2
4	Хэл засал	23	Ярианы бэрхшээлтэй сурагчдад авиа засах, уруулын, хэлний амьсгал зөв авах, үлээх дасгалуудыг заалаа.	
5	Хөгжим	23	Урлаг, гоо зүйн зохих мэдлэгтэй болгох, би хийж бүтээж чадна гэсэн чин хүсэлтэй болгох энгийн хөгжмийн зэмсгээр 3 дуу тоглож сургалаа	
6	Цаасан урлал/	12	Хүүхдийг бүтээлээр нь дамжуулан хөгжүүлэх зорилгоор цаасан урлалын дугуйланг хичээллүүллээ.	2
7	Ном уншигчдын клуб	23	Бүтэн өгүүлбэрээр ярьж сургах эмх цэгцтэй өөрийгөө илэрхийлж сургах үйл ажилгаануудыг зохион байгуулаа.	1
8	Амьдрах чадварт сургах	23	Амьдралд хэрэгтэй өөрт нь тус болохуйц зүйлүүдийг сурагчдад зааж сургах зорилгоор үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Хүүхэд бүр шүрээр түлхүүрийн оосор, ээмэг бугуйвч, үзэг харандааны сав зэргийг хийж сурлаа.	1
9	“Бид сэтгэж, бодож, бүтээж чадна”	23	Угсардаг тоглоомоор дамжуулан сурагчдад өнгө дүрс ялгах эвлүүлэх, бүтээх чадваруудыг эзэмшүүллээ.	1

*1 хүүхдийн хамрагдсан дугуйланг давхардсан тоогоор үзүүлэв.

- Гэрээнд заасан санхүүжилтийг төслийн үйл ажиллагаа явуулах танхимыг тохижуулах болон багш нарын сургалтад зарцуулсан. 25 сурагчтай. 1 хүүхдэд оногдох зардал нь 480,000 төгрөг болсон.
- Дугуйлангийн үйл ажиллагаанаас гадна гадагш гарах боломж нь хязгаарлагдмал хүүхдүүдийг нийгмийн үйл ажиллагаатай танилцуулах аялал зохион байгуулсан.
- Хичээлийн бус цагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг 8

		багшид сургуулийн захирлын тушаалаар үндсэн цалингийн 5-20 хувийн нэмэгдэл хөлсийг олгодог. ➢ Төслийн хугацаанд 4 багш Нийслэлийн тусгай сургуулиудад зочилж, хичээлд оролцож, хэрэглэгдэхүүн боловсруулах аргатай танилцан туршлага судалсан.
	Гарсан үр дүн	➢ Тус төсөл эхлэхийн өмнө 2017.09 сард сургуультай танилцахад хөгжлийн бэрхшээлийг тэгш хамруулан сургадаг эцэг эхчүүд болон ангийн хүүхдүүд тэднийг маш их дэмждэг сургууль байсан. Хичээлээс гадуур дугуйлан, секцэд хамруулдаг болсноор шинээр хөгжим тоглодог, дуудлага сайжирсан зэрэг олон сайн үр дүн гарсан, хүүхэд бүр илүү өөртөө итгэлтэй болсон байхыг эцэг эх болон хүүхдийн ярианаас нь мэдрэгдэж байсан. ➢ Ховд аймаг нь баруун бүсийн тулгуур төв бөгөөд зөвхөн өөрийн аймаг төдийгүй баруун бүсийн бусад сургуулиудад энэ сайн жишээгээ түгээн дэлгэрүүлнэ гэдэгт найдаж байна.

1-3-5 Зорилт 4 үйл ажиллагаа

Зорилт 4: Зорилт 1-3-ын холбогдох байгууллагууд харилцан туршлага солилцож, үр дүн нь үндэсний тогтолцоо бодлогод тусгагдана.

Зорилт 4-ийн хүрээнд Зорилт 1-3-ын хүрээнд хэрэгжсэн туршлагыг солилцох семинар зохион байгуулах, Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгыг сайжруулах, Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар нийтийг хамарсан арга хэмжээ өрнүүлэх ажлуудыг зохион байгуулсан. Төслийн хугацаанд БСШУСЯ, Боловсролын хүрээлэнгээс оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөрийг сайжруулах ажлыг төлөвлөөгүй тул төслийн зүгээс тусгай сургуулийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх ажил хийгдээгүй.

1-3-5-1 Зорилт 1-3-ын туршлагыг солилцох семинар зохион байгуулах

Төслийн үйл ажиллагааны үр дүнг түгээх зорилгоор дараах сургалт семинаруудыг зохион байгуулсан. Төслийн туршилтын Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгаар хязгаарлагдахгүй Нийслэлийн төвийн 6 дүүргийн боловсролын хэлтэс болон сургуулиудын төлөөллийг “Туршлага солилцох семинар”-таа урьж оролцуулсан.

Хүснэгт 40 Эхний жилийн туршлага солилцох семинар

д/д	Огноо	Оролцогч	Сэдэв
1	2017.05.15	• БСШУСЯ • ХНХЯ • ЭМЯ • Салбар комисс, 9-н дүүргийн салбар комисс • Үр дүн 1 - Ажлын хэсэг • Үр дүн 2 - МАЗБ	• Баянгол дүүргийн Салбар комиссын үйл ажиллагааны үр дүнгийн тайлан • 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн тайлан • Төслийн үнэлгээний хэрэглэгдэхүүний гарын авлагын танилцуулга • Туршилтын сургуулийн хүүхэд нэг бүрийн

			хэрэгцээнд нийцсэн багшлах арга зүйг сайжруулах үйл ажиллагаа • Бичил төслийн үйл ажиллагааны тайлан
2	2017.05.16	• Сүхбаатар дүүргийн боловсролын хэлтэс • Сүхбаатар дүүргийн ердийн сургууль • Чингэлтэй дүүргийн боловсролын хэлтэс • Чингэлтэй дүүргийн ердийн сургууль	• ТХБ, тэгш хамруулан сургахтай холбоотой хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр • Төслийн үйл ажиллагааны танилцуулга, япон улсад хэрэгжүүлж буй аргуудыг танилцуулах • Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, гарын авлагын танилцуулга, аргазүйн санаа, хэрэглэгдэхүүний танилцуулга • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тохирох хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх тухай танилцуулга
3	2017.05.16	• Баянзүрх дүүргийн боловсролын хэлтэс • Баянзүрх дүүргийн ердийн сургууль	
4	2017.05.17	• Баянгол дүүргийн боловсролын хэлтэс • Баянгол дүүргийн ердийн сургууль • Сонгинохайрхан дүүргийн боловсролын хэлтэс • Сонгинохайрхан дүүргийн ердийн сургууль	
5	2017.05.17	• Хан-Уул дүүргийн боловсролын хэлтэс • Хан-Уул дүүргийн ердийн сургууль	
6	2017.05.16	• Хөвсгөл аймгийн БСУГ • Хөвсгөл аймгийн салбар комисс • Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын холбогдох хүмүүс • Хөвсгөл аймгийн туршилтын сургуулийн холбогдох хүмүүс	• Хөвсгөл аймгийн эхний шатны төлөв байдлын судалгааны тайлан • Хөвсгөл аймгийн салбар комиссын цаашдын төлөвлөгөө • Бичил төслийн үйл ажиллагааны тайлан • Үнэлгээний хэрэглэгдэхүүний гарын авлагын танилцуулга • Хөвсгөл аймгийн туршилтын сургуулиуд дээр хэрэгжүүлж буй хичээлийн чанарыг сайжруулах үйл ажиллагаа

Хүснэгт 41 Хоёрдох жилийн туршлага хуваалцах семинар

	Огноо	Оролцогчид	Сэдэв
1	2019.05.24	• Хөвсгөл аймгийн БСУГ • Хөвсгөл аймгийн салбар комисс • Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын холбогдох хүмүүс • Хөвсгөл аймгийн туршилтын сургуулийн холбогдох хүмүүс	• Хөвсгөл аймгийн эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнгийн тайлан • Хөвсгөл аймаг дахь хөгжлийн дэмжлэгийн тогтолцоог сайжруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ • Хөвсгөл аймгийн туршилтын сургууль болон Мөрөн сумын бусад ердийн сургуулиуд дээр хэрэгжүүлж буй багшлах арга зүйг сайжруулах үйл ажиллагаа
2	2019.05.28	• БСШУСЯ • ХНХЯ • ЭМЯ • Салбар комисс, 9-н дүүргийн салбар комисс	• Төслийн хүрээнд хөгжлийн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа • Эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнгийн тайлан • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас

		• Үр дүн 1 - Ажлын хэсэг • Үр дүн 2 – МАЗБ • Туршилтын сургууль	хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулж хэрэгжүүлж буй арга хэмжээ • Баянгол дүүрэгт хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ • БСШУСЯ болон ХНХЯ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандаж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа • Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага • Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж • Туршилтын сургуулийн жишээний эмхэтгэл • Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог

2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Туршлага солилцох семинар”-ын үеэр 8 телевиз, 1 радио, 1 сонины газраас сурвалжлага авсан бөгөөд тухайн өдрийн орой мэдээний цагуудаар семинарын талаар мэдээ цацагдсан. “Монгол Ньюс” сонины 5 дугаар сарын 29-ний дугаарын эхний нүүрэнд төслийн тухай мэдээлэл хэвлэгдэн гарсан.

1-3-5-2 Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулгыг сайжруулах

Монголын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг хариуцдаг БМДИ-ийн мэрэгжилтнүүдтэй хамтарч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

- Ердийн сургуулийн захирал, удирдах ажилтнуудад зориулсан сургалт

2016 оны 03 дугаар сарын 05-ны өдөр БМДИ-ээс зохион байгуулсан захирлуудын сургалтыг 1 өдрөөр сунгаж, 25 захирлыг оролцуулан сургалт зохион байгуулав. Энэ сургалтын үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудалд хамаарах бодлого, чиглэл, тэгш хамруулан сургах боловсролын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тусгай сургуулийн туршлагыг хэрэгжүүлэх зэрэг асуудлаар сургууль тус бүр өөрийн одоогийн байдлын талаар танилцуулга хийсэн.

- Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг сайжруулах

2016 оны 03-05 дугаар сард, БМДИ-ээс зохион байгуулсан тусгай сургуулийн багш болон туслах багш нарт зориулсан сургалтад төслийн мэргэжилтэн багш нараас лекц уншиж, дадлага ажлыг удирдан явуулсан.

• БМДИ-ийн арга зүйчдэд зориулсан сургалт

БМДИ-ийн арга зүйчид тэгш хамруулах боловсролын чиглэлээр мэдлэг, туршлага дутмаг гэж үзсэн тул хандлага, ойлголтыг сайжруулах зорилгоор 2016 оны 12 дугаар сард сургалт зохион бйагуулав. Сургалтын агуулгыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 42 БМДИ-ийн арга зүйчдэд зориулсан сургалт

	Огноо	Оролцогчдын тоо	Агуулга	Хариуцсан ажилтан
1	2016.12.02	18 хүн	Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт ба тэгш хамруулан сургах боловсрол	Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн Тэрүяа мэргэжилтэн
2	2016.12.09	16 хүн	• Аутизмын хүрээний бэрхшээлийн ойлголт • Дауны хам шинжийн тухай ойлголт • ГСТ-ний хэлэлцүүлэг	• Д.Байгалмаа（28-р сургуулийн ажлын баг） • Сургалтын бодлого хариуцсан мэргэжилтэн • Багшийн мэргэжил дээшлүүлэх/багш бэлтгэх сургалт хариуцсан мэргэжилтэн
3	2016.12.16	16 хүн	• ГСТ-ний хэлэлцүүлэг • Тусгай сургуулийн арга зүйн • Суралцах бэрхшээлийн тухай ойлголт • Тэгш хамруулах боловсролын олон улсын чиг хандлага, тохирох хэрэглэгдэхүүний бүрдүүлэх түүний ач холбогдол	• Б.Энхцэцэг（25-р сургуулийн сургалтын менежер） • Сургалтын бодлого хариуцсан мэргэжилтэн • Багшийн мэргэжил дээшлүүлэх/багш бэлтгэх сургалт хариуцсан мэргэжилтэн

• Төслийн боловсруулсан бүтээгдэхүүн, зайн сургалтын хичээлүүдийг БМДИ-ийн цахим хуудас дахь болон багшийн хөгжил портал сайтад байршуулан нийт багш нар үзэж, танилцах боломжийг бүрдүүлсэн.

Хүснэгт 43 Багшийн хөгжил портал сайтад байршуулсан бүтээгдэхүүний жагсаалт

Нийтэлсэн хугацаа	Жагсаалт
2018.10.23	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хүснэгт, сургалтын загвар боловсруулах аргачлал
2019.05	Туршилтын сургуулийн сайн хичээлийн жишээ, видео хэрэглэгдэхүүн (6 хичээл)
2019.05	Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог

• 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын өмнөх онлайн сургалтын хэрэглэгдэхүүнийг хамтран боловсруулсан.

1, 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт нь сургалтын өмнөх, дараах, танхимын сургалт гэсэн 3 хэсгээс бүрддэг. Үүнээс сургалтын өмнөх ба дараах сургалт нь зайн сургалтаар явагддаг тул тус сургалтын нийт оролцогчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, хандлагыг сайжруулах, нэгдсэн ойлголтыг бий болгох зорилгоор “Багшийн мэргэжил дээшлүүлэх зайн сургалт, Тэгш хамруулан сургах боловсрол (Видео хичээл)” шинээр боловсруулан гаргаж, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын Youtube суваг болон БМДИ-ийн цахим хуудас, багшийн хөгжил портал сайтад байршуулав. Видео хичээл нь 3 модул 9 хичээлээс бүрдэх ба тус бүр ойлголтоо бататгах сорилын сантай. Зайн сургалтын цахим хуудсанд 2019 оны 01-03 дугаар сар хүртэл хугацаанд 127 багш орсон байна.

Хүснэгт 44 Зайн сургалтын бүтэц

Эхлэл хэсэг (Сургалтын зорилго ба бүтэц)
https://www.youtube.com/user/JICAMongolia/videos[9]

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудалд хамаарах хууль, эрх зүйн орчин

	Агуулга	Багш	Хугацаа
Хичээл 1	Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ? https://youtu.be/Y4AbOA1dpUI	Монгол Улсын DET Forum, сургагч багш Б.Энхням	10:56
Хичээл 2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдий боловсролын олон улсын чиг хандлага (Саламанкагийн тунхаглал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Тэгш хамруулан сургах боловсролын үзэл, баримтлал) https://youtu.be/QTFG5dqEtlo	МУБИС, БоСС, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхмийн багш Э.Мөнхбат	13:50
Хичээл 3	Монгол Улс дахь хууль эрх зүйн орчин, үндэсний хөтөлбөр, холбогдох байгууллагууд https://youtu.be/zzyR1lrWlpU	БСШУСЯ Ерөнхий боловсролын бодлогын газрын мэргэжилтэн Б.Гэрэлтуяа	15:03
Бататгах тест			

2. Тэгш хамруулан сургах сургууль болохын төлөөх тогтолцоог бий болгох

	Агуулга	Багш	Хугацаа
Хичээл 4	Сургууль дээр дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх -Сургууль дээр хэрэгжүүлэх боломжтой дэмжлэгийн агуулга	Хөвсгөл аймаг, БСУГ-ын мэргэжилтэн Д.Баасансүрэн	14:08

[9] Үндсэн сургалтын оролцогчид БМДИ-ийн сургалтын талбарт http://esurgalt.itpd.mn/ хаягаар нэвтрэн, өөрийн нэвтрэх эрх, нууц үгийн тусламжтойгаар орж, суралцах ба бататгах тест бөглөнө. YouTube сувагт JICA Монгол дахь төлөөлөгчийн газрын хаягаар байршуулсан.

	-Сургуулийн дэмжлэгийн зөвлөл -Жишээ танилцуулах (Хөвсгөл аймаг) https://youtu.be/m7V0JPGsjDE		
Хичээл 5	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний талаар ойлголт -Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гэж юу вэ? -Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал https://youtu.be/01YwoQMgSvU	ЕБС-ийн 25 дугаар тусгай сургууль, согог зүйч багш М.Батмөнх	14:47
Хичээл 6	Тохируулгат хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх тухай https://youtu.be/KXD9p7x-umQ	БМДИ, Тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан арга зүйч Ч.Жаргал	23:26
Бататгах тест			

3. Хөгжлийн бэрхшээлийн онцлог

	Агуулга	Багш	Хугацаа
Хичээл 7	Хөгжлийн бэрхшээлийн онцлог- Хүүхдийн хөгжил, Оюуны бэрхшээл, Дауны хам шинж, Тархины саажилт https://youtu.be/jlIfVFqZ_8M	ЕБС-ийн 70 дугаар тусгай сургууль, согог зүйч багш Б.Энхтуяа	11:15
Хичээл 8－1 Хичээл 8－2	Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн онцлог Харааны бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн онцлог https://youtu.be/61tIDTrsjkg	ЕБС 29 дүгээр тусгай сургууль, согог зүйч багш Н.Бурмаа Ахмад согог зүйч багш Д. Хорлоо	25:15
Хичээл 9	Анхаарал дутмагших, хэт хөдөлгөөнтөх эмгэг, сурлагын хоцрогдолтой, суралцах бэрхшээлтэй хүүхдийн онцлог, тэдэнтэй ажиллах арга зүй https://youtu.be/n_-SijH-o1Q	МУБИС, БоСС, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхмийн эрхлэгч Г.Батцэнгэл	29:02
Бататгах сорил			

1-3-5-3 Багш бэлтгэх сургуулийн хөтөлбөрийг сайжруулах

2016 оноос МУБИС дээр Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим байгуулагдсанаас хойш төслийн холбогдох 6 багш цагийн багшаар ажиллаж байна. Тэдгээр багш нар нь төслийн сургалт, семинар, япон мэргэжилтнүүдтэй хамтарч боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон ээлжит хичээлийн төлөвлөгөөний загварыг ашиглах талаар сургалтын агуулгад оруулан зааж байна. Төслөөс БМДИ-тэй хамтран боловсруулсан багшийн мэргэжил дээшлүүлэх зайн сургалтын видеог оюутнуудын хичээлд хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна. Тус тэнхмийн үйл ажиллагааны эхэн үед “Тусгай боловсролын түүх, философи” гэдэг хичээл ордог байсан ба энэ хичээл нь 2018-2019 оны хичээлийн жилээс “Хүүхдийн оношлогоо, үнэлгээ” гэдэг хичээлээр солигдон агуулгад нь ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалыг оруулан зааж байна.

Хүснэгт 45 МУБИС, БоСС-ын ТХБ-ын тэнхмийн оюутнуудад хичээл ордог сургагч багш нарын хичээлийн агуулга (2017-2019)

	Хичээлийн нэр	Сургагч багшийн нэр	Кредитын тоо
1	Урлаг, хөдөлмөр сургалт заах арга зүй	25-р тусгай сургуулийн багш М.Мөнхбат （2017/2018 оны хичээлийн жилд）	2 кр
2	Монгол хэл заах арга зүй	63-р сургуулийн менежер О.Мөнхцэцэг	3 кр
3	Аутизмтай хүүхдийн боловсрол	Монголын Аутизмын холбооны захирал Л. Алтангэрэл	2 кр
4	Тэгш хамруулах боловсрол	БМДИ-ийн арга зүйч Ж.Жаргал	2 кр
5	Нийгэм ахуйн баримжаа	70-р тусгай сургуулийн багш Б.Гэрэлтуяа (Одоо БСШУСЯ-ны Боловсролын бодлогын газрын мэргэжилтэн) (2017-2018 оны хичээлийн жилд)	2 кр
6	Хэл яриа харилцааны бэрхшээлтэй хүүхдийн боловсрол	70-р тусгай сургуулийн согог зүйч багш Б. Энхтуяа	3 кр
7	Хүүхдийг судлах, оношлох	55-р сургуулийн захирал Ч. Ганбилэг (2017/2018 оны хичээлийн жилд)	2 кр

1-3-5-4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар нийтийг хамарсан арга хэмжээ өрнүүлэх

Жил бүр a) Эрт илрүүлгийн өдөр (05.13), b) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрүүдийг (12.03) тохиолдуулан дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

a) Эрт илрүүлгийн өдөр

• Сонин зэрэг өдөр тутмын хэвлэлд гаргаж, БСШУСЯ, ХНХЯ болон тусгай сургуулиуд дээр үзэсгэлэн гаргасан. Мөн календар, зурагт хуудас хэвлүүлэн, холбогдох байгууллага хүмүүст тараасан.

• 2018 он: Нийслэлийн 35-р сургуульд (туршилтын ердийн) хамрагддаг 2016 онд Төв комисстой (Хуучин нэрээр) хамтран хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхийн чухлыг сурталчилсан шторк боловсруулсан. 05 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд MYOHT, 25 дугаар суваг, UBS, TV5, Боловсрол суваг, Like, TV10 сувгуудаар цацагдсан.

• 2017 он: 05.11-14-ны өдрүүдэд Нийслэлийн төв гудамжны 2 том дэлгэцээр эдгээр шторкуудыг цацсан .

• 2018 он: Шторкийг ХНХЯ-ны цахим хуудас болон, төслийн Facebook хуудаст байршуулав.

• 2019 он: 2018 онд боловсруулсан 2 баримтат нэвтрүүлгийг MNB сувгаар бүрэн эхээр цацагдсан.

b) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдөр (12.03)

• 2015 он : Сэргээн засалтын үндэсний төвтэй хамтран боловсруулсан шторк 11.29-12.10–ны өдрүүдэд MYOHT, TV5, TV9, 25-р суваг, UBS телевизүүдээр цацагдсан.

• 2016 он: “Нийслэлийн хэмжээнд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан” зарлаж ирүүлсэн бүтээлүүдээр Шангрила Их дэлгүүрийн дэмжлэгтэйгээр гар зургийн үзэсгэлэн гаргасан ба зургийн цомог болон хуанли хэвлүүлж холбогдох байгууллага хүмүүст тараасан.

• 2017он: Туршилтын бүх сургууль, Баянгол дүүрэг ба Хөвсгөл аймгийн салбар комиссоос шалгаруулж ирүүлсэн хүүхдүүдийн бүтээлийг UB Post, Өдрийн ихэр хүүгийн тухай өгүүлдэг “Хүүхэд бүхэн хөгждөг”, Ховд аймгийн 7 дугаар дунд сургуулийн (2 дахь жилийн бичил төсөлд шалгарсан) охины тухай өгүүлсэн “Хүүхэд бүрт тэгш боломж” 2 баримтат нэвтрүүлгийг боловсруулсан. ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын Youtube сувгаар нийтэд нээлттэй байршуулж, БСШУСЯ /телевизээр/, ХНХЯ өөрийн цахим хуудаст байршуулж, MYOHT, Хөвсгөл аймгийн орон нутгийн телевизийн сувгаар нэвтрүүлсэн.

1-3-5-5 Бусад үйл ажиллагаа

a) Япон Улсын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжиж буй бага, дунд сургуулийн барилга байгууламжийг сайжруулах төсөлд хамрагдсан сургуулийн багш нарт цуврал сургалт（2018.09-2019.01）зохион байгуулав.

Япон Улсын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжиж буй бага, дунд сургуулийн барилга байгууламжийг сайжруулах төсөл түгээмэл загвар, гамшгаас хамгаалах систем бүхий сургууль шинээр барих, өргөтгөл барих үйл ажилагааг эхлүүлж, үүнд 3 сургууль хамрагдаад байна. Тус төсөлд хамрагдсан сургуулийн багш нарын ойлголт, хандлагыг сайжруулах, түгээмэл загварт үндэслэн барилга байгууламжийг барих, техник хэрэгслийг ашиглах заавар боловсруулах, тараах, багш нар болон холбогдох хүмүүст зориулсан сургалт явуулахаар төлөвлөсөн. Энэ түгээмэл загварын дагуу барилга байшин барихад багш нар, хүүхэд бүрийн хэрэгцээг тодорхойлж, тохирох хэрэглэгдэхүүн боловсруулж ажиллах ур чадвар эзэмшээгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургуульд хамрагдах нь асуудалтай хэвээр байх болно.

Төсөлд хамрагдсан сургуулиудын багш нараас авсан судалгаанаас үзэхэд хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдийг авч сургасан ч тэдэнтэй ажиллах арга зүй дутмаг, хэрэглэгдэхүүн боловсруулах, бодит байдлыг тодорхойлох мэдлэг туршлага байхгүй тул сургалт авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Эцэг эхчүүд ХБХ-тэй хүүхэддээ хэрхэн боловсрол эзэмшүүлэх талаар зөвлөгөө авахаар ирэхэд хамгийн ойрхон тусгай сургуулийг зааж өгч явуулсан жишээ гарч байсан нь илэрсэн. Тиймээс төсөлд хамрагдсан ердийн сургуулийн багш нарт зориулж төслийн баг 2018 оны 9-р сараас эхлэн сургалт зохион байгуулж байна. НБГ дээр сургуулийн захирлуудтай урьдчилж, уулзалт зохион байгуулан сургалтын талаар танилцуулан хэзээ хаана явуулах өдөр байраа хэлэлцэж тохирсон. 3 сургууль тус бүрд 2, 5-3 цагийн сургалтыг 5 удаа зохион байгуулсан. Сургалтын агуулгыг дор хүснэгтэд үзүүлэв. Эхний удаад “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн”, “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай DET сургалт”-ын сургагч багшид хүсэлт гаргаж, хөгжлийн бэрхшээлд хандах нийгмийн ухамсрыг өөрчилж, хууль дүрмийн дагуу шаардлагатай арга хэмжээг авахад чиглэсэн сургалтыг зохион байгуулсан. Бүх сургуулийн багш нар уг сургалтад идэвхтэй оролцсон хэдий ч ХБХ сургадаг туршлагатай сургуулийн багш нар, энэ талын туршлагагүй сургуулийн багш нарын ойлголт адилгүй байлаа.

Хүснэгт 46 Бага, дунд боловсролын сургуулийн барилга байгууламжийг сайжруулах төсөлд хамрагдсан сургуулийн багш нарт зориулсан цуврал сургалт

Давтамж	Агуулга	Огноо	Хамрах хүрээ
1	Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт ба тэгш хамруулан сургах боловсрол	2018.09.10	Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн багш нарт
		2018.10.16	Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн багш нарт
		2018.10.18	Хан-Уул дүүргийн 75 дугаар сургуулийн багш нарт
2	Тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлийн төрөл ба тэдгээрийн онцлог	2018.10.23	Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн багш нарт
		2018.10.24	Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн багш нарт
		2018.11.24	Хан-Уул дүүргийн 75 дугаар сургуулийн багш нарт
3	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах	2018.10.30	Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн багш нарт
		2018.11.22	Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн багш нарт
		2019.01.22	Хан-Уул дүүргийн 75 дугаар сургуулийн багш нарт
4	Суралцахуйн хоцрогдолтой болон зан үйлийн асуудалтай хүүхэдтэй ажиллах арга зүй	2018.11.20	Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн багш нарт
		2018.11.24	Хан-Уул дүүргийн 75 дугаар сургуулийн багш нарт
		2019.01.24	Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн багш нарт

5	Эцэг эхтэй харилцах талаар	2019.01.21	Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн багш нарт
		2019.01.22	Хан-Уул дүүргийн 75 дугаар сургуулийн багш нарт
		2019.01.24	Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн багш нарт

b) “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам” шинэчлэн батлах асуудлаар төслөөс санал хүргүүлэв. (2017он)

2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн боловсролын сайдын А/309 дугаар “Журам, загвар шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу Боловсролын үнэлгээний төвөөс журмыг шинэчлэн батлахтай холбогдуулан төслийн мэргэжилтнүүдээс саналаа хүргүүлсэн.

2018 онд Боловсролын үнэлгээний төвөөс “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам” хэрэгжүүлэх талаар зөвлөмж боловсруулан гаргасан. Энэ журам гарахаас өмнө ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн үнэлгээг ердийн хөтөлбөрөөр шалган дүгнэдэг байсан тул ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу хүүхдийг үнэлэх асуудал шийдэгдэж чадаагүй байсан. Тус зөвлөмжид “Ердийн сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд буюу тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан шалгуурын дагуу үнэлж, дүгнэнэ” гэж заасан тул ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон тусгай хөтөлбөрт үндэслэсэн шалгуураар суралцагчийг үнэлэх боломжтой боллоо.

Түүнчлэн 2018 оны 03 дугаар сарын 29-ний БСШУС-ын сайдын А/155дугаар[10] тушаалаар ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар болон боловсруулах аргачлалыг хамтад нь баталснаар ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллах боломж бүрдсэн. Тиймээс тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг үнэлэх үндэслэл, шалгуурыг мэргэжлийн байгууллагын үнэлгээний үр дүн болон хүүхэд нэг бүрийн хөгжлийн онцлогт нийцүүлэн сургуулийн дэмжлэгийн багийн шийдвэрийн дагуу боловсруулна. “Тусгай хөтөлбөрөөр хичээллэдэг хүүхдийн тухайд тус хөтөлбөрт үндэслэж хийгдсэн шалгуурын дагуу хүүхдийг үнэлнэ” гэсэн тул ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, тусгай хөтөлбөрөөр хичээллэж байгаа хүүхдүүд өөрсдийнх нь чадварыг харгалзан боловсруулсан хөтөлбөрийн шалгуураар үнэлэгдэх боломжтой боллоо. Ердийн сургуульд суралцдаг ХБХ бусад хүүхдийн хэмжээнд мэдлэг чадвар эзэмшсэн эсэхээр биш, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний урт ба богино

[10] 41-р хуудас “Хүүхдийн бодит байдлыг судлах болон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар дээшилнэ” гэж бичсэн дагуу төслийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан гарын авлага, зөвлөмж

хугацааны зорилт биелэгдсэн эсэхээр үнэлэгдэх эрх зүйн орчин бүрдсэн.

БСШУСЯ, БМДИ-ээс Япон дахь сургалт зохион байгуулахад үзүүлсэн дэмжлэг (2017.11)

БСШУСЯамнаас 2017 оны 11-р сарын13-20-ны өдрүүдэд, БСШУСЯ, БМДИ, тусгай сургууль, цэцэрлэгийн төлөөллөөс бүрдсэн багийг Япон улсад явуулж хөгжлийн хоцрогдолтой, зан төрхийн асуудалтай хүүхдүүдэд үзүүлдэг дэмжлэгийн талаар туршлага судлуулав.

Тус сургалтад оролцогчид буцаж ирээд салбартаа сурч мэдсэн туршлагаа нэвтрүүлнэ. Япон улсад ердийн сургууль, тусгай сургууль, мэргэжлийн боловсролын сургууль зэрэг бүх тогтолцоонд үзүүлж буй дэмжлэгийн талаар туршлага судалж ойлголтоо гүнзгийрүүлсэн ба Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой аргыг эрэлхийлж, БСШУСЯ –ны дэргэдэх Боловсролын салбарын түүхийн музей, Токио Гакугэй их сургуулийн харъяа тусгай сургууль, Сайтама мужийн мэргэжлийн сургалттай ахлах сургууль, Хувийн хэвшлийн сургууль, Токио хотын Кита дүүргийн бага сургуулиар орж ажил байдалтай нь танилцаж туршлага судалсан. Өдөр бүр тухайн өдрийн сургалтыг эргэн дүгнэж хэлэлцүүлэг хийн, сүүлийн өдөр 7 хоногийн аяллын нэгдсэн тайлан гаргав. Оролцогчид “Хүүхдэд орчин бүрдүүлэх үйл ажиллага их чухал болохыг мэдэрлээ”, “Сургуульд орохоос нь өмнө цэцэрлэгийн насанд нь сайн бэлтгэл хийдэг юм байна”, “Өөртөө үйлчлэх энгийн чадварт суралцахаас гадна тооцоолон бодох, өөртөө зорилт тавих чадварт сургах нь чухал байна” гэх мэт сэтгэгдэлтэй байв.

c) Туршилтын сургуульд онол практикийн бага хуралд илтгэл тавихад үзүүлсэн дэмжлэг (2018.01, 2018.11)

Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгээс жил бүр хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах аргазүй, туршлага солилцох, нэвтрүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд онол практикийн бага хурал зарлан, хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүйн илтгэлүүдийн төслийг хүлээн авдаг. 5 дугаар хурлаас эхлэн Тэгш хамруулан сургах боловсролын секторыг шинээр үүсгэн, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүй сэдвээр шалгарсан илтгэлүүдийг хүлээн авч салбар хуралдаанаар хэлэлцүүлдэг болсон.

2018 оны 01 дүгээр сард зохион байгуулсан 5 дугаар хурлаар, тусгай сургуулиас 5, ердийн сургуулиас 1 илтгэл хүлээн авч, салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2018 оны 11 дүгээр сарын 16-17 өдрүүдэд 6 хурал зохион байгуулагдсан 6-р хурлаар төслийн туршилтын сургуулиас 1 сургууль ханан илтгэлээр, 1 сургууль салбар хуралдаанаар

аман илтгэл хэлэлцүүлсэн. Төслийн мэргэжилтэн тусгай хэрэгцээт боловсролын салбар хуралдааны шүүгчээр ажиллан, зөвлөмж өгсөн ба тус хурлын хөтөлбөр, илтгэлийн хураангуйг хэвлэх зардлыг төслөөс хариуцав.

Энэхүү эцсийн тайлангаас гадна төслийн хүрээнд боловсруулсан дараах эцсийн бүтээгдэхүүнүүдийг хүргүүлсэн. Эдгээр оношилгоо болон боловсролын хэрэглэгдэхүүнүүдэд Номны олон улсын стандарт дугаарлалт авч, Монгол Улсын 21 аймаг болон Нийслэл дэх 5 номын санд хүргүүлсэн.

Хүснэгт 47 Техникийн хамтын ажиллагааны үр дүн, эцсийн бүтээгдэхүүн

Нэр		Эцсийн бүтээгдэхүүний нэр	Тараасан байгууллага, албан газрын нэр		
Үнэлгээний хэрэглэгдэхүүн, Боловсролын хэрэглэгдэхүүн	Үнэлгээний хэрэглэгдэхүүн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага	БСШУСЯ 50ш, БМДИ, Боловсролын хүрээлэн нийт 10ш (5ш ×2газар), МУБИС 20ш Боловсролын үнэлгээний төв 1ш	9 дүүрэг, 21 аймгийн БСУГ/ БХ 3ш, нийт 90ш (3ш ×30газар), Монгол Улсын бүх ЕБС-д 2, 409ш (3ш ×803сургууль)	Бүх Насан туршийн боловсролын төв 356ш (1ш ×356 төв)
		Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж	БСШУСЯ-Д 50ш, БМДИ, Боловсролын хүрээлэн нийт 10ш (5ш ×2газар), МУБИС 20ш Боловсролын үнэлгээний төв 1ш	9 дүүрэг, 21 аймгийн БСУГ/ БХ 3ш, нийт 90ш (3ш ×30газар), Монгол Улсын бүх ЕБС-д 2, 409ш (3ш ×803сургууль)	Бүх Насан туршийн боловсролын төв 356ш (1ш ×356)
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага	БСШУСЯ, ХНХЯ, ЭМЯ-д нийт 75ш	Бүх Салбар комисс-т (9 дүүрэг ＋21 аймаг) нийт 600ш (20ш ×30газар)	Бүх СЭМТ, ӨЭМТ-д 700ш (1ш ×700газар)
		Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглах гарын авлага	БСШУСЯ, ХНХЯ, ЭМЯ-д нийт 15ш	Бүх СЭМТ, ӨЭМТ-д 4, 200ш (6ш ×700газар)	Нийслэлийн төрөх эмнэлгүүд (4 эмнэлэг), Хувийн эмнэлгүүдэд (20 эмнэлэг) нийт 120ш (5ш ×24 газар)
		18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага (Үзлэгийн маягтын хамт)	БСШУСЯ, ХНХЯ, ЭМЯ-д нийт 15ш	Бүх СЭМТ, ӨЭМТ-д 4, 200ш 6ш ×700газар)	Нийслэлийн төрөх эмнэлэг 4 эмнэлэг), Хувийн эмнэлгүүдэд (20 эмнэлэг) нийт 120ш (5ш ×24 газар)

		Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж	БСШУСЯ, ХНХЯ, ЭМЯ-д нийт 15ш	Бүх Салбар комисст (9 дүүрэг ＋21 аймаг) нийт 300ш 10ш ×30 газар)		
	Жишээний эмхэтгэл	Туршилтын сургуулийн жишээний эмхэтгэл (тусгайсургууль+ердийн сургууль)	БСШУСЯ-Д 50ш, БМДИ, Боловсролын хүрээлэн нийт 10ш 5ш ×2газар), МУБИС 20ш Боловсролын үнэлгээний төв 1ш	9 дүүрэг, 21 аймгийн БСУГ/ БХ 3ш, нийт 90ш (3ш ×30газар), Монгол Улсын бүх ЕБС-д 2, 409ш (3ш ×803сургууль)		Бүх Насан туршийн боловсролын төв 356ш 1ш ×356)
Бусад	Видео хэрэглэгдэхүүн	“Бага насны хүүхдийн хөгжил”, “Дауны хам шинжийг эрт илрүүлэх, ойлголтыг дээшлүүлэх видео хичээл”, “ Аутизмын хүрээний эмгэгийг эрт илрүүлэх, ойлголтыг дээшлүүлэх видео хичээл”, “18 сартай хүүхдийн үзлэг зохион байгуулах жишээний видео”	Бүх СЭМТ, ӨЭМТ-д 700ш 1ш ×700газар)			
		Багшийн мэргэжил дээшлүүлэх Онлайн сургалт, Тэгш хамруулан сургах боловсрол (Видео хичээл)	БСШУСЯ -Д 50ш	БМДИ 200ш, Боловсролын хүрээлэн5ш, Боловсролын үнэлгээний төв 1ш	Монгол Улсын бүх ЕБС-д 1, 606ш 2ш ×803 сургууль)	Бүх Насан туршийн боловсролын төв 356ш 1ш ×356)
	Дохионы хэлний карт	1000 үгтэй дохион ы хэлний карт	БСШУСЯ -Д 5ш, БМДИ, Боловсролын хүрээлэн, МУБИС нийт 15ш,	9 дүүрэг, 21 аймгийн ЭМГ-т нийт 150ш 5ш ×30газар)	6 тусгай сургууль 60ш 10ш ×6 сургууль) 2 тусгай цэцэрлэг 20ш (10ш ×2цэцэрлэг)	“Сонсголгүйн боловсрол ТББ”, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоонд нийт 245ш

	Зурган цомог	Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог (CD-R-ын хамт)	БСШУСЯ 50ш, БМДИ, Боловсролын хүрээлэн, МУБИС, Боловсролын үнэлгээний төв нийт 16ш	Монгол Улсын бүх ЕБС-д 2, 409ш 3ш ×803сургууль)	9 дүүрэг, 21 аймгийн ЭМГ-т нийт 90ш 3ш ×30газар)	Бүх Насан туршийн боловсролын төвд 356ш 1ш ×356 төв)
	Зурган карт хэрэглэгдэхүүний	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага (тоо, дүрс, үсэгний зурган карт, бодит хэрэглэгдэхүүний багцын цүнх)	БСШУСЯ -Д 1ш	9 дүүрэг, 21 аймгийн ЭМГ-т нийт 30 багц	Туршилтын 14 сургууль*14 багцын цүнх)	

Дээрх байгууллага хамт олонд тарааснаас гадна дараах 2 байгууллагын хүсэлтээр техникийн хамтын ажиллагааны эцсийн бүтээгдэхүүнийг мөн хүргүүлж тараасан болно.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо”
  - “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага” 10 ширхэг
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөгжлийн төв”
  - “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага” 50 ширхэг
  - “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглах гарын авлага” 100 ширхэг
  - “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага” 100 ширхэг
  - “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж” 6 ширхэг
  - “Видео хичээл” тус бүр 3 ширхэг

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2-1 Төслийн зорилт болон шалгуур үзүүлэлт

Зорилт 1: Туршилтын аймаг, дүүрэгт холбогдох байгууллагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжинэ.

Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 48 Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт

Шалгуур үзүүлэлт	Биелэлт
1) Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулагдана.	“Биелсэн” Дараах хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулж гаргасан. • Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглах гарын авлага болон Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглалтыг сайжруулах сургагч багш бэлтгэх сургалтын модул” • 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг үзлэгийн маягт • 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага • Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглах гарын авлага”, “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн маягт”, “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага”-ыг БСШУСЯ, ХНХЯ, ЭМЯ-нд “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж”-ийг БСШУСЯ, ХНХЯ-нд танилцуулан дэмжигдсэн болно. Эдгээр гарын авлага зөвлөмжийг 2019.05.24 нд Хөвсгөл аймагт, 28-нд Нийслэлд зохион байгуулсан “Туршлага солилцох семинар”-ын үеэр түгээхийн зэрэгцээ хүснэгт 46-д үзүүлсэнчлэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглалт сургалтын модул”-ыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. “Танака Бине оюун ухааны сорил V-ын Монгол хувилбар”-ын нийт 3 удаагийн сорил судалгаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцон төслийн зүгээс 37 хүн сорил авагчаар бэлтгэгдсэн (25-р хуудсанд дурдсан). “Портеж эрт боловсролын хөтөлбөрийн Монгол хувилбар”-ын тухайд 78 хүн багшаар бэлтгэгдсэн, ба 24 байгууллага уг хөтөлбөрийг ашиглан хүүхэд, тэдний гэр бүлд хөгжлийн дэмжлэг үзүүлж байна (27-р хуудсанд дурдсан).
2) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс болон Салбар комиссын чадавх бэхжинэ.	“Биелсэн” Комисс • Комисс төслийн үйл ажиллагаанд оролцож, Монгол Улсын хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн тогтолцооны загвар бий болгоход төслийн мэргэжилтнүүдтэй зөвшилцөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-ыг хамтран боловсруулсан. Энэ заавар Комиссын хүчин чармайлтын үр дүнд 2018 оны 11 дүгээр сарын 15-ны ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын А/304, А/699, А/406 тоот хамтарсан тушаалаар батлагдсан. Комисс тус гарын авлагыг ашиглан тогтмол бүсчилсэн сургалтыг зохион байгуулснаар үндэсний хэмжээнд бүх Салбар комиссуудад хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны загварыг хэрэгжүүлэх талаар зааж, чиглүүлсээр байх төлөвлөгөөтэй байна (2017.10.11 сард зохион байгуулсан бүсчилсэн

сургалтад уг гарын авлагын төслийг ашигласан). Ийнхүү Монгол Улсын одоогийн нөхцөл байдалд үндэслэн боловсруулсан гарын авлага болон мэргэжлийн байр сууринаас Салбар комиссыг чиглэл, удирдлагаар хангах чиглэлээр Комиссын чадавх бэхэжсэн гэж хэлж болохоор байна.

Салбар комисс

Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар дараах мэдээллийг тодруулсан. Үүнд:



- “Салбар комиссын чиг үүрэг”-ийн тухай асуултын олон хувилбараас зөвийг сонгох эсэхийг шалгахад Баянгол дүүргийн Салбар комиссын гишүүдийн зөв хариутын дундаж үзүүлэлт эцсийн төлөв байдлын судалгаанд ихээхэн өссөн байгаа нь ажиглагдсан. Хамтарч ажилласан байгууллагуудын талаар чөлөөтэй тэмдэглэсэн хариултаас үзэхэд Баянгол дүүрэгт дараах ахиц, өөрчлөлтүүд гарсан байгаа нь харагдсан. Эдгээр нь:

  - Дүүргийн боловсролын хэлтэс, цэцэрлэг, тусгай сургууль, ердийн сургуулиудтай сургуульд хамрагдалтыг дэмжих чиглэлээр ч уялдаж ажилладаг болсон.
  - Асран хамгаалагч нарын ажил эрхлэлтийг дэмжиж зорилгоор Хөдөлсөр, халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтарч ажилладаг болсон.
  - Хүүхдийн бодит байдлыг тодорхойлох, хөгжлийг үнэлэх, хэрэгцээнд нь нийцсэн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулахдаа хорооны нийгмийн ажилтныг оролцуулж, хамтран ажилладаг болсон.
  - Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, ээлжит хуралдаан зохион байгуулахтай холбоотойгоор өрхийн эмч нартай холбоотой ажиллах болсон.

Хөвсгөл аймгийн Салбар комиссын тухайд мөн ялгаагүй “Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газартай хамтарч ажиллаж байгаа” гэсэн хариулт нэмэгдсэн байсан ба сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан сургах шийдвэр гаргаж, түүнд дэмжлэг үзүүлэх нь нэн чухал асуудал гэдгийг бүрэн ойлгодог болсон нь харагдсан.

Эдгээр ахиц, өөрчлөлтүүд нь Салбар комисс бусад салбарын мэргэжилтнүүдтэй уялдаж ажиллан, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бүхий л тал дээр нь дэмжлэг шаардлагатай хүүхдэд дэмжлэг үзүүлэх дэмжлэгийн чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлдэг болсон гэдэг нотолгоо гэж хэлж болно.

- Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймгийн Салбар комиссын мэдлэг, ойлголтыг “Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт”, “Эрт илрүүлэг, оролцоо”, “Хүүхдийн хөгжил”, “Хөгжлийн бэрхшээлийн ангилал”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”, “Багшлах арга зүй” гэсэн 6 үндсэн сэдвийн нийт 22 асуулттай тестээр шалгасан. Эцсийн шатны судалгаанд Баянгол дүүргийн Салбар комиссын ”Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт”, “Эрт илрүүлэг, оролцоо”, “Хөгжлийн бэрхшээлийн ангилал”, Хөвсгөл аймагт мөн “Эрт илрүүлэг, оролцоо”, “Хүүхдийн хөгжил”, “Хөгжлийн бэрхшээлийн ангилал”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”

	сэдвийн тестийн гүйцэтгэл суурь судалгаанаас илүү өндөр үзүүлэлттэй гарсан. Төслийн шат дараатай үйл ажиллагаар дамжуулан Салбар комиссын суурь мэдлэг гүнзгийрсэн байгаа нь харагдаж байна.  

“Холбогдох мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх” гэсэн Зорилт 1 нь хөгжлийн хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах замаар биелэгдэнэ гэж төлөвлөсөн бөгөөд Төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд “Хэрэглэгдэхүүн боловсруулагдана” гэдэг шалгуур үзүүлэлтээр тусгасан. Тиймээс өмнөх “1-3 үйл ажиллагаа”-д дурдсанчлан туршилтын аймаг, дүүрэг дэх холбогдох байгууллага, мэргэжилтний бэхжүүлбэл зохих чадавхыг “Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх”, “Хөгжлийн үнэлгээ хийх чадавх”, “Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавх”, “Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх” гэж 4 ангилан, чадавх бэхэжсэн эсэхийг тандаж тодруулсаныг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 49 Холбогдох байгууллагын хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх

Чадавх	Холбогдох байгууллага/мэргэжилтэн	Биелэлт
Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх	• Баянгол дүүрэг дэх эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд • Хөвсгөл аймаг дахь эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд	• Туршилтын аймаг, дүүрэг дэх эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд нь төслөөс зохион байгуулсан сургалт, арга зүйн дэмжлэгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх мэдлэг, чадварыг эзэмшин, дараах үйл ажиллагаагаар дамжуулан тэрхүү чадавх бэхэжсэн гэж хэлж болно. Үүнд: - 1-3-2-2 (а) “Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхыг бэхжүүлэх” (22-р хуудас)-д тэмдэглэсэнчлэн, Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглалтыг сайжруулах болон 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх сургагч багш бэлтгэх сургалтаар Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгаас нийт 14 эмч сургагч багшаар бэлтгэгдсэн. Энэхүү сургалт нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнүүдийг тасралтгүй мэргэжил дээшлүүлэх (CPD) зорилтот сургалтаар хүлээн зөвшөөрөгдөж, нийт оролцогчдод Баянгол дүүрэг болон Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 1 кредитийн сургалтад хамрагдсаныг тодорхойлох гэрчилгээ олгосон. - Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт эрүүл мэндийн үзлэг сар бүр тогтмол зохион байгуулагдаж байна. Анх хэрэгжиж эхлэх үеэс 2019.03 сар хүртэлх үзлэгийн хамралтын хувь Баянгол дүүрэгт 75.7%, Хөвсгөл аймагт 73.1% байна.

Хөгжлийн үнэлгээ хийх чадавх	Сэтгэл зүйч, эмч, мэргэжилтэн, багш [11]	• “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбарыг боловсруулахад чиглэсэн 3 удаагийн сорил судалгаагаар дамжуулан 37 сорил авагч, 39 тэмдэглэл хөтлөгчийг бэлтгэсэн. Тэдгээр 37 сорил авагч нь ”Танака Бине оюун ухааны сорил V”-ын сорил авах зааврын дагуу сорил авах чадварыг эзэмшсэн. 39 тэмдэглэл хөтлөгч мөн ялгаагүй тухайн оюун ухааны сорилын тухай ерөнхий мэдлэгтэй болсны зэрэгцээ сэтгэл зүй, хөгжлийн сорилын талаар гүнзгий ойлголттой болж чадсан.
	Портеж хөтөлбөрийн мэргэжилтэн	• 2 удаагийн Портеж хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх сургалтаар 78 мэргэжилтнийг бэлтгэсэн. Тус сургалтын агуулга нь Японы Портеж нийгэмлэгийн “Портеж эрт боловсролын хөтөлбөрийн анхан шатны сургалт”-тай ижил бөгөөд нийт сургалтад хамрагдсан хүмүүст төслөөс гэрчилгээ гардуулсан. • 2019.03 сарын байдлаар Нийслэлд 14 байгууллага, Хөвсгөл аймагт 10 байгууллага буюу нийт 20 байгууллага Портеж хөтөлбөрөөр дэмжлэг үзүүлж байна.
Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавх	• Баянгол дүүргийн Салбар комисс • Хөвсгөл аймгийн Салбар комисс	• 1-3-2-2 в) “Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавх бэхжүүлэх” (29-р хуудас)-д тэмдэглэсэнчлэн, Салбар комисс нь дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй хүүхдийн кэйсийг сонгон, ICF-д суурилан хөгжлийн үнэлгээ хийж, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах кэйс хэлэлцүүлгийг (Хурлын тоо: Баянгол дүүрэг, Хөвсгөл аймаг тус тус 7 удаа, кейсийн тоо: тухайн хурал бүрт 1-2 кейс) бие даан зохион байгуулж, үзүүлсэн дэмжлэгтээ хяналт, үнэлгээ хүртэл хийдэг болсон. • Кэйс хэлэлцүүлгийн туршлагаар дамжуулан ээлжит хуралдаанаар ч (2018 онд хурлаар хэлэлцсэн хүүхдийн тоо: Баянгол дүүрэгт 588, Хөвсгөл аймагт 479) Салбар комиссын гишүүд ICF-ын загварт тулгуурлан хүүхдийн нөхцөл байдалд хөгжлийн цогц үнэлгээ хийн, олон мэргэжлийн багаар хэлэлцэж хөгжлийн дэмжлэг үзүүлж чаддаг болсон.
Хөгжлийн дэмжлэг үзүүлэхчадавх	• Баянгол дүүргийн Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн багш • Хөвсгөл аймгийн Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн багш	• 1-3-2-2 г) “Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх” (32-р хуудас)-д тэмдэглэсэнчлэн, Баянгол дүүрэгт “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийн 1 дүгээр ээлж (2017.10.10–2018.03) болон 2 дугаар ээлжийг (2018.03-09) зохион байгуулсан. Тус хөтөлбөрийн багш бэлтгэх сургалтаар 3 багш бэлтгэгдсэн ба одоо Баянгол дүүрэгт 2 газар “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг тогтвортой зохион байгуулж байна. • Хөвсгөл аймагт эхний ээлжийн “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг (2018.03-09) зохион байгуулсаны дараа Салбар комиссоос “Аймгийн бүх дэмжлэг шаардлагатай хүүхдийг өргөнөөр хамруулахын тулд нийт 5 газар болгон өргөжүүлж зохион байгуулмаар байна” гэсэн хүсэлт ирсэн. 2018.10 дугаар сараас хойш Салбар комисс ерөнхий удирдлага, зохицуулалтаар ханган Мөрөн суманд 3 газар, бусад 2 суманд буюу нийт 5 газар “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг тогтвортой хэрэгжүүлж байна.

[11]Харьяалагддаг байгууллага: БГД болон Хөвсгөл аймгийн ХБХЭМБНХ-ын салбар комисс, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, БГД-ийн Эрүүл мэндийн төв, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг, БГД-ийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, тусгай цэцэрлэг, тусгай сургууль

		• Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн багш нар эцэг эхээс цэцэрлэгт хамруулах хүсэлтэй эсэхийг тодруулж, цэцэрлэгийн талаар мэдээлэл өгөхийн зэрэгцээ Салбар комисстой хамтран хамрагдах хүсэлтэй цэцэрлэгт нь холбох зэргээр дэмжлэг үзүүлсний үр дүнд ихэнх хүүхдүүд цэцэрлэгт хамрагдах боломжтой болсон.
	Портеж хөтөлбөрийн багш	• “Хөгжлийн үнэлгээ хийх чадавх”-тай ижил.

Зорилт 2: Туршилтын сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өндөр чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ.

Зорилт 2-ын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 50 Зорилт 2-ын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт

Шалгуур үзүүлэлт	Биелэлт
1) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний аргачлал боловсруулагдана.	“Биелсэн” • Мэргэжил арга зүйн баг, туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэгтэй хамтран “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ийг боловсруулж, 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн БСШУС-ын сайдын А/155 тоот тушаалаар батлуулсан.
2) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө сайжирна.	“Биелсэн” • Туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэгтэй хамтран “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”-ыг боловсруулж, 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн БСШУС-ын сайдын А/155 тоот тушаалаар батлуулсан.
3) Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн сайжирна.	“Биелсэн” Дараах хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулсан. • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж” БСШУСЯ, ХНХЯ-нд танилцуулж, 2019.05.24 өдөр Хөвсгөл аймагт, 28-ны Нийслэлд зохион байгуулсан “Туршлага солилцох семинар”-ын үеэр тараахын зэрэгцээ Хүснэгт 47-д үзүүлсэнчлэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

4) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сайн хичээл, сайн туршлагын эмхэтгэл боловсруулагдана.	“Биелсэн” Дараах жишээний эмхэтгэлийн боловсруулсан. • Тусгай сургуулиудын жишээний эмхэтгэл • Ердийн сургуулиудын тохируулгат орчин бүрдүүлэх жишээний эмхэтгэл БСШУСЯ, ХНХЯ-нд танилцуулж, 2019.05.24 өдөр Хөвсгөл аймагт, 28-ны Нийслэлд зохион байгуулсан “Туршлага солилцох семинар”-ын үеэр тараахын зэрэгцээ Хүснэгт 47-д үзүүлсэнчлэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

“Туршилтын сургуулийн чадавхыг бэхжүүлэх” гэсэн Зорилт 2-т хөгжлийн хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах замаар хүрнэ гэж төлөвлөсөн ба Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй дахь шалгуур үзүүлэлт нь “Хэрэглэгдэхүүн боловсруулагдана” юм. Тийм учраас дээр тэмдэглэсэн “1-3 үйл ажиллагаа”-д дурдсанчлан туршилтын сургуулийн бэхжүүлбэл зохих чадавхыг “Хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадавх”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавх”, “Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлж заах чадавх”, “(Тусгай сургууль) ердийн сургуульд дэмжлэг үзүүлэх чадавх”, “(Ердийн сургуульд) тохируулгат орчин бүрдүүлэх чадавх” гэж 5 ангилан, чадавх бэхэжсэн эсэхийг тандаж тодруулсаныг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 51 Туршилтын сургуулийн багш нараас хүлээгдэж буй чадавх болон биелэлт

Чадавх	Холбогдох байгууллага, мэргэжилтэн	Биелэлт
Хүүхдийн бодит байдалд үнэлгээ хийх чадавх	• Тусгай сургуулийн багш (4 сургууль) • Ердийн сургуулийн багш (Нийслэлийн 8 сургууль, Хөвсгөл аймгийн 2 сургууль)	**Тусгай сургууль** • 1-3-3-2 Тусгай сургуулийн багш нарын чадавх бэхжүүлэх а) Хүүхдийн бодит байдлыг үнэлэх болон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлэх (40-р хуудас)-д тэмдэглэсэн дагуу, өмнө нь хүүхдийн “хийж чадахгүй зүйл”, “дургүй зүйл”-д л анхаарлаа хандуулж байсан багш нар “хийж чаддаг зүйл”, “дуртай зүйл” нь юу вэ гэдгийг ажигладаг болсон. Судалгаат хичээлээр төслийн хүрээнд хамгийн сайн боловсруулсан ээлжит хичээлийн хөтөлбөрийн загварыг ашиглан, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, тухайн цагийн хичээлийн зорилго болон хүүхдийн үйл ажиллагааны агуулга, багшийн дэмжлэг, арга зүй зэргийг дэлгэрэнгүй төлөвлөж чаддаг болсон. Мөн судалгаат хичээлийн дараа “Сургалтын хэрэглэгдэхүүн сонгох, ашиглах арга”, “Хүүхдийн байдал”, “Багшийн үйл ажиллагаа” гэсэн өнцгөөс хичээлийг эргэн дүгнэх хэлэлцүүлэг хийхэд, хүүхэд сургалтын хэрэглэгдэхүүнийг анхаарч, ашиглаж чадаж байсан уу, багшийн хэлсэн үг ойлгомжтой байсан уу, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хичээлд оролцож чадаж байсан уу гэдгийг хичээл заасан багш болон ажиглагчид дүгнэн хэлэлцэж чадсан. Эдгээр туршлагаар дамжуулан хүүхдийн ажиглалт чаддаг болж, үр дүнтэй сургалт явуулж чаддаг болсон. • Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар тусгай сургуулийн ажлын хэсэгтэй ярилцлага хийхэд “Хүүхдийн бодит байдалд үнэлгээ хийж чаддаг болсон”, “Багш нарын (Хүүхдийн) харилцан мэдээлэл солилцох байдал сайжирсан” зэрэг хүүхдийн

бодит байдалд үнэлгээ хийх чадварт эерэг өөрчлөлтүүд гарч байгаа гэж дүгнэж байсан.

- Туршилтын тусгай сургуульд 2018/2019 оны хичээлийн жилд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан кэйс хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тухайн кэйсийн талаар багш нар багаараа ярилцаж, арга зүй болон асуудалтай үйлдлийг шийдвэрлэх арга хэмжээний талаар хэлэлцэх хурлыг 3 удаа зохион байгуулсан. Энэхүү кэйс хэлэлцүүлгээр ажлын хэсгийн багш нар бусад багш нарт тухайн хүүхэд ямар үед зан үйлийн хувьд асуудал гаргаж байгааг анхааралтай ажиглах шаардлагатай зэрэг бодит байдлыг зөв тодорхойлж үнэлэхийн чухлыг тайлбарлангаа хурлыг чиглүүлж зохион байгуулж байсан нь багш нарын бодит байдлыг тодорхойлж, үнэлэх чадавхыг бэхжүүлсэн гэж үзэж болно.
- Төслийн эцсийн төлөв байдлын судалгааны хүрээнд туршилтын тусгай сургуулийн багш нарын “Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт”, “Эрт илрүүлэг, оролцоо”, “Хүүхдийн хөгжил”, ”Хөгжлийн бэрхшээлийн ангилал”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”, “Багшлах арга зүй”-н мэдлэг ойлголтыг шалгах, 6 үндсэн сэдвээр 22 асуулт бүхий тестээр шалгасан. Ажлын хэсгийн гишүүдэд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” сэвдийг хасаад 5 сэдвээр, харин ажлын хэсгийг оролцуулаад нийт багш нараас “Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт”, “Эрт илрүүлэг, оролцоо” “Хүүхдийн хөгжил” сэдвээр бататгах тест авахад гүйцэтгэл нь төслийн суурь судалгааны үетэй харьцуулахад өндөр үзүүлэлттэй гарсан. Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй болон ердийн хүүхдийн хөгжлийн талаарх зөв мэдлэг ойлголтдоо тулгуурлан хүүхдийн бодит байдлыг илүү зөв тодорхойлж, үнэлгээ хийж чаддаг болсон гэж хэлж болно.



Ердийн сургууль

- 1-3-3-3 Ердийн сургуулийн багш нарын чадавхыг бэхжүүлэх а) Хүүхдийн бодит байдлыг үнэлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн багшлах ур чадварыг бэхжүүлэх (54-р хуудас)-д тэмдэглэсэн дагуу, туршилтын ердийн сургуулийн багш нар хөгжлийн бэрхшээлийн талаар зөв мэдлэг, ойлголттой болж чадсан гэж үзэж байна.
- Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар туршилтын

		ердийн сургуулийн багш нараас өмнө дурдсан мэдлэг ойлголтыг шалгах 6 сэдвийн 22 асуулттай тест авсан. Сургуулийн ажлын хэсгийн гишүүдээс “Багшлах арга зүй”-г хасаад 5 сэдэв, ялангуяа “Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт”, “Хүүхдийн хөгжил”, “Хөгжлийн бэрхшээлийн ангилал” сэдвийн тестийн гүйцэтгэл төслийн суурь судалгааны үеийнхээс өндөр үзүүлэлттэй гарсан. Үүнээс үзэхэд ердийн сургуулийн багш нар ч хөгжлийн бэрхшээл болон хүүхдийн хөгжлийн талаарх зөв мэдлэг ойлголтдоо тулгуурлан хүүхдийн бодит байдлыг илүү үнэн зөв тодорхойлж, үнэлж чаддаг болсон гэж хэлж болохоор байна. 
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавх	• Тусгай сургуулийн багш (4 сургууль) • Ердийн сургуулийн багш (Нийслэлийн 8 сургууль, Хөвсгөл аймгийн 2 сургууль)	**Тусгай сургууль** • 1-3-3-2 Тусгай сургуулийн багш нарын чадавх бэхжүүлэх (а) Хүүхдийн бодит байдлыг үнэлэх болон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлэх (40-р хуудас)-д тэмдэглэсэн дагуу, шинэчилэн боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загварын талаар анхандаа “Бичих зүйл хэт их”, “Зөвхөн урт хугацааны зорилтоо тодорхойлоход хангалттай юм биш үү” зэрэг сөрөг саналууд цөөнгүй байсан ч яг бодит байдал дээр ашиглах явцдаа тус загварыг ашигтай, давуу талуудыг ойлгодог болсон. • Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар тусгай сургуулийн ажлын хэсэгтэй ярилцлага хийхэд, “Маш тодорхой урт болон богино хугацааны зорилт дэвшүүлж, заах арга зүй, агуулгаа төлөвлөж чаддаг болсон”, “Үүгээр дамжуулж хүүхдийн ар гэртэй ярилцаж, зөвлөдөг болсон” зэрэг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадварт эерэг өөрчлөлтүүд гарч байгаа гэсэн хандлагатай байлаа. • 25 дугаар тусгай сургуулийг эс тооцвол “Төслийн оролцоо, дэмжлэгийг авснаас хойш (2015-2016 оноос хойш) ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулдаг болсон” гэж хариулсан багш нарын тоо “Боловсруулж үзээгүй”, “2014-2015 оноос өмнө боловсруулж байсан” гэж хариулсан багш нараас олон байсан. Түүнчлэн “Боловсруулж үзээгүй” гэсэн хариултыг шинээр ажилд орсон туслах багш, сургуулийн эмч, нийгмийн ажилтан зэрэг өгсөн байсан.

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>


Ердийн сургууль

• 1-3-3-3 Ердийн сургуулийн багш нарын чадавхыг бэхжүүлэх (a) Хүүхдийн бодит байдлыг үнэлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах чадавхыг бэхжүүлэх (54-р хуудас)-д тэмдэглэсэн дагуу, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахаас эхлэн судалгаат хичээл зохион байгуулах хүртэл ажилласан 16,113-р сургуулиуд, “Ирээдүй 21 дүгээр зуун цогцолбор сургууль”, “Титэм” 2 дугаар сургуулийн тухайд судалгаат хичээл зохион байгуулсан ангийн багш болон ажлын хэсгийн багш нар бусад багш нартаа ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний талаар сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгсөн. Ялангуяа “Ирээдүй 21 дүгээр зуун цогцолбор сургууль”, “Титэм” 2 дугаар сургуулиуд төсөл хэрэгжих хугацаанд 3 удаа судалгаат хичээл зохион байгуулснаас гадна, сургуулийн дэмжлэгийн багийн зорилтот хүүхдүүдэд шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах зэргээр багш нарын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавх дээшилсэн гэж үзэж байна.

• Төслийн эцсийн төлөв байдлын судалгаанаас үзэхэд туршилтын ердийн сургуульд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсан хичээллэж байгаа хүүхдийн тоог төслийн дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад нийслэлд 1-27, Хөвсгөл аймагт 1-31 болж нэмэгдсэн.
</td>
</tr>
<tr>
<td>Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн багшлах ур чадвар</td>
<td>• Тусгай сургуулийн багш (4 сургууль)
• Ердийн сургуулийн багш (Улаанбаатар хотын 8 сургууль・Хөвсгөл аймгийн 2 сургууль)</td>
<td>
Тусгай сургууль

• 1-3-3-2 Тусгай сургуулийн багш нарын чадавх бэхжүүлэх b) Хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нь нийцсэн дэмжлэг, арга зүйгээр ажиллах чадварыг сайжруулах (45-р хуудас)-д тэмдэглэсэн дагуу, судалгаат хичээл зохион байгуулах болон сайн хичээлийн жишээний эмхэтгэл боловсруулахаар дамжуулан анги нийтээрээ хамтдаа хөгжилдөх боломжтой тоглоом оруулах, хүүхэд бүрийн хөгжлийн үе шатад тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зэргээр сургалтын арга зүйг баяжуулж чаддаг болсон.

• Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар тусгай сургуулийн ажлын хэсгээс төсөл дэмжлэг үзүүлэхээс өмнөх хичээл (2016 оны) болон төслийн дэмжлэг, оролцоог авснаас хойшхи хичээлийн (2018 оны) видеог 20 орчим минут үзүүлж, хэрхэн
</td>
</tr>
</table>

		харьцуулан дүгнэж байгааг тодруулсан. Багш нар өөрсдөө ч хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн зааж чаддаг болсон, чадсан хүүхдийг магтаж, урам өгдөг болсон, туслах багш нар хүүхдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж чаддаг болсон зэрэг ахиц, эерэг өөрчлөлтүүдийг мэдэрч байгаа нь харагдаж байлаа. **Ердийн сургууль** • 1-3-3-3 Ердийн сургуулийн багш нарын чадавхыг бэхжүүлэх а) Хүүхдийн бодит байдлыг үнэлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах чадавхыг бэхжүүлэх” (54-р хуудас)-д тэмдэглэсэн дагуу, тусгай сургуулиас үзүүлдэг зөвлөн туслах үйл ажиллагаа болон төслийн мэргэжилтнүүдийн заадаг сургалтуудаар дамжуулан туршилтын ердийн сургуулийн багш нар ч сургалтын олон хэлбэрийг туршиж, олон янзаар тохирох хэрэглэгдэхүүн боловсруулж чаддаг болсон. (Кэйсийн талаар Хүснэгт 31-ийг үзэх) • Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар ердийн сургуулийн багш нараас “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлахдаа итгэлтэй байгаа эсэх”-тэй холбоотой төсөл хэрэгжихийн өмнө (2014-2015 оноос өмнө) болон дараа хэрхэн өөрчлөлт гарсан талаар тодруулав. Төсөл хэрэгжихийн өмнөх үеэс илүү дараа “Бага зэрэг итгэлтэй байна”, “Өөртөө итгэлтэй байна”, “Маш их итгэлтэй байна” гэж хариулсан багш нарын тоо өссөн байна. 
Ердийн сургуульд дэмжлэг үзүүлэх чадавх	Тусгай сургуулийн ажлын хэсэг (4 сургууль)	• Тусгай сургуулиас туршилтын ердийн сургуульд үзүүлдэг зөвлөн туслах үйл ажиллагааны ачаар 1) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үнэлгээ болон сургалтын олон хэлбэрийн талаарх зөвлөгөө зэрэг тусгай сургуулийн багш нарын туршлага дээр тулгуурласан дэмжлэгийг үзүүлж чаддаг болсон, 2) Тусгай сургуулиуд өдий хүртэл хамтарч ажиллах нь бага байсан ердийн сургууль дээр очих, эсрэгээрээ ердийн сургуулиас тусгай сургуульд очиж хичээл, сургалтын байдалтай танилцах зэргээр сургуулиудын талаар харилцан ойлголттой болсон 3) ердийн сургуулийн багш нарт төдийгүй асран хамгаалагч нарт зориулсан сургалтуудыг ч зохион байгуулсан зэрэг үр дүнгүүд гарсан. Эдгээр бодитой ажлуудаас тусгай сургуулиас ердийн сургуульд дэмжлэг үзүүлэх чадвар дээшилсэн гэж үзэж байна. • Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар туршилтын ердийн сургуульд үзүүлэх зөвлөн туслах үйл ажиллагааг зохион

		байгуулсан ажлын хэсгээс энэхүү үйл ажиллагааны талаар хэрхэн дүгнэж байгааг тодруулав. Ажлын хэсэг нь зөвлөн туслах үйл ажиллагаагаар дамжуулан ердийн сургуулийн багш нар болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаарх мэдлэг, ур чадвар, ажиллах хүсэл, эрмэлзэл харилцан адилгүй байгаа тул илүү их дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа нь харагдлаа. Мөн ердийн сургуулийн багш нарыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэн, зөв ойлголт, хандлагатай болгож чадсан гэж үзэж байлаа.
Тохируулгат орчин бүрдүүлэх чадавх	Ердийн сургуулийн ажлын хэсэг (Улаанбаатар хотын 8 сургууль • Хөвсгөл аймгийн 2 сургууль)	• 1-3-3-3 Ердийн сургуулийн багш нарын чадавхыг бэхжүүлэх b) Ердийн сургууль дээрх тохирох хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх чадавхыг сайжруулах (60-р хуудас)-д тэмдэглэсэн дагуу, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах төлөвлөгөө боловсруулах, хүүхэд хөгжлийн төвийн байгуулах, сургуулийн дэмжлэгийн багийг байгуулах, сургуульд хамрагдалтыг дэмжих зэргээр дамжуулан туршилтын ердийн сургуулийн тохируулгат орчин бүрдүүлэх чадавх бэхэжсэн гэж үзэж байна. • Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар ердийн сургуулийн багш нарт “Сургууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах бэлтгэл хангагдсан эсэх”-тэй талаар холбоотой төсөл хэрэгжихийн өмнөх (2014-2015 оноос өмнө) болон дараах үед хэрхэн өөрчлөлт гарсан талаар тодруулав. Төсөл хэрэгжихийн өмнөхтэй харьцуулахад дараа нь “Бага зэрэг хангагдсан”, “Бэлтгэл хангагдсан”, “Маш сайн бэлтгэл хангагдсан” гэж хариулсан багшийн тоо өссөн байна.  • Төслийн эцсийн төлөв байдлын судалгаагаар туршилтын ердийн сургуулийн ажлын хэсгээс тохируулгат орчин бүрдүүлэх чадварын талаар төсөл дэмжлэг үзүүлэхээс өмнө болон төслийн дэмжлэг, оролцоог авснаас хойш хэрхэн өөрчлөлт гарсан талаар тодруулах зорилгоор ярилцлага авсан. Тохирох хэрэглэгдэхүүн, дэмжлэгийн талаар (нэг жишээ) дараах хэсэгт тэмдэглэв. - Бүх багш нар хүүхдийн ойлголтод тулгуурлан сургалтын агуулгаа өөрчилж байгаа. Зурган карт болон бодит зүйл ашигладаг болсон. Тухайн өдрийн хичээлийн цагийн хуваарийг хүүхдэд ойлгомжтой үзүүлэхийн тулд шаардлагатай хүүхдэд график, зураг зэргийг ашиглаж байна. “Зааврыг ойлгомжтой хэлэх” гэдгийг бүх багш нар сайн ойлгодог болсон (28-р сургууль) - Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа

		хүүхдэд сургалтын агуулгыг өөрчилж тохируулдаг. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллээгүй, ялангуяа бага ангийн хүүхдэд ч цагийн хуваарийн хүснэгтэд фото зураг ашиглаж байна. Үүнтэй холбоотойгоор анги удирдсан багш нарт фото зураг тарааж өгсөн. (79-р сургууль) - Сар бүр зохион байгуулдаг эцэг эхийн хурлаар анги удирдсан багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд талаар тайлбарладаг. Хүүхдүүдэд ч тайлбарлаж, ойлгуулах нь анги удирдсан багшийн үүрэг. (79-р сургууль) - Тохирох хэрэглэгдэхүүнээр хангахын ач холбогдол, гарч буй үр дүн нь илт харагдаж байгаа учраас үргэлжлүүлэн анхаарч ажиллана. Хүүхэд төдийгүй багш нарт ч амар болсон. (111-р сургууль)

Зорилт 3: Бичил төслөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн олон төрлийн боловсролын үйлчилгээний хэлбэр, загвар, түүний үр дүн батлагдана.

“1-3 үйл ажиллагаа”-д тэмдэглэсэнчлэн, 6 бичил төслийг хэрэгжүүлсэн. Үр дүн нь батлагдсан боловсролын олон хэлбэрийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 52 Бичил төслүүдийн батлагдсан үр дүн

Төслийн нэр	Батлагдсан үр дүн
“Оюуны бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд боловсролын тэгш оролцоог хангах нь”	Дараах үр дүнгүүд гарсан нь батлагдсан тул энэхүү төсөл үр өгөөжтэй байсан гэж дүгнэж байна. ➢ Эхэн үедээ 130-р сургуулийн багш нар болон асран хамгаалагчдын туршилтын ангийн талаарх ойлголт хангалтгүй байсан ч, дауны хам шинж болон оюуны бэрхшээлийн онцлог шинжийн талаар туршилтын анги удирдсан багш нь хэлэлцүүлэг сургалт зохион байгуулж, хүүхдүүдийг аливаа үйл ажиллагаанд хамт оролцуулах зэргээр ажилласны хүчинд ойлголт нь дээшилсэн. ➢ Төсөл дуусаны дараа, туршилтын ангийг Монголын Дауны холбоо ТББ удирдлагаар хангаж, багшийн цалинг асран хамгаалагчдын төлбөрөөс гаргаж байсан хэдий ч, 2018.02 сард 63-р тусгай сургуулийн харьяа анги болгосон.
“Бид чадна” (Албан бус сургалтаар насан туршийн боловсрол олгох төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах төсөл)	Дараах үр дүнгүүд гарсан нь батлагдсан тул энэхүү төсөл үр өгөөжтэй байсан гэж дүгнэж байна. ➢ Ямар нэг шалтгаанаар сургуульд явахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг албан бус сургалтад хамруулах замаар хүүхдүүдэд боловсрол эзэмшсэн гэрчилгээ олгодог болсон. ➢ Ийм гэрчилгээтэй болсноор МСҮТ, техник мэргэжлийн сургууль зэрэг дараагийн түвшний боловсрол эзэмших боломж бүрдсэн.
“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй хүүхэд харах үйлчилгээ”	Дараах үр дүнгүүд гарсан нь батлагдсан тул энэхүү төсөл үр өгөөжтэй байсан гэж дүгнэж байна. ➢ Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 18 нас хүртэл нь хүлээн авах боломжтой байдаг бөгөөд эцэг эхийн холбоо зэрэг байгууллагын ажиллуулдаг өдөр өнжүүлэх төвүүд ч энэ үйлчилгээг эрхлэхээр зөвшөөрөгдсөн. ➢ Баянзүрх, Баянгол, Хан-Уул дүүргийн хүүхэд харах үйлчилгээ

	үзүүлэгчдэд тус бүр 1 удаа сургалт зохион байгуулсан. Хүүхэд харагчид заримдаа өөрчлөгдөж солигдох явдал гардаг тул шинээр орж ирсэн хүүхэд харагчдад зориулан сургалт зохион байгуулсан.
“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрт оролцооны хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүн бүтээх”	Дараах үр дүнгүүд гарсан нь батлагдсан тул энэхүү төсөл үр өгөөжтэй байсан гэж дүгнэж байна. ➢ Боловсруулсан картнуудаас, 1)-ийг 29-р тусгай сургууль, 186-р тусгай цэцэрлэгийн зарим ангид ашиглаж байгаа ба багш нар болон хүүхдүүд ойлгомжтой, авч явахад амар гэх зэргээр сэтгэгдлээ хэлж байсан. Цаашид дохионы хэл сураагүй байгаа асран хамгаалагчдад зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн болгож ашиглах ч боломжтой. ➢ Картнуудын талаар төслийн Facebook хуудсанд нийтлэхэд, маш олон хүмүүс сонирхож авахыг хүсч байсан. Уг төслийн хугацаанд эх бэлтгэх, тоног төхөөрөмж худалдаж авах төсөв хуваарилсан ч картыг хангалттай тоогоор хэвлүүлж чадаагүй тул 2019.05 сард тус төсөл 500 хувь хэвлүүлж туршлага солилцох семинарын үед холбогдох байгууллагуудад тараасан.
“Сургуулийн өмнөх насны хүүхдийг боловсролд тэгш хамруулах”	Дараах үр дүнгүүд гарсан нь батлагдсан тул энэхүү төсөл үр өгөөжтэй байсан гэж дүгнэж байна. ➢ Уг цэцэрлэгт явдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төдийлөн олон биш боловч МУБИС-т сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр мэргэшиж буй оюутнууд болон бусад цэцэрлэгийн багш нарын нөөц болох үүргийг гүйцэтгэж байгаа тул ердийн цэцэрлэгт тэгш хамрагдалтыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан. ➢ МУБИС-т сургуулийн өмнөх боловсрол хариуцсан багш ч энэхүү бичил төслийн ажлын хэсгийн гишүүнээр ажилласан бөгөөд цаашид илүү олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авснаар туршлага хуримтлуулсан. ➢ МУБИС-ийн сургуулийн өмнөх боловсролын сургуулийн номын санг багш нарт зориулсан сургалтын зөвлөмжөөр хангасан.
“Хөгжлийн бэрхшээл - Хөгжих саад биш”	Дараах үр дүнгүүд гарсан нь батлагдсан тул энэхүү төсөл үр өгөөжтэй байсан гэж дүгнэж байна. ➢ Төсөл эхлэхийн өмнөх 2017.09 сард анх уулзсан үеэс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн ангид сурдаг, асран хамгаалагчид болон ангийнх нь хүүхдүүд ч тусалж дэмждэг тийм сургууль байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцуулж ирсний ачаар хөгжим тоглож сурсан, авиа дуудах чадвар нь сайжирсан зэргээр хөгжил нь янз бүр боловч, бүгд өөртөө итгэх итгэл нь нэмэгдсэнийг багш нар, асран хамгаалагчид болон хүүхдүүдээс авсан ярилцлагын үед онцолж байсан. ➢ Ховд аймаг нь баруун бүсийн төв бөгөөд зөвхөн аймагтаа биш, баруун бүсийн бусад сургуулиудад ч энэ үйл ажиллагаагаа өргөжүүлнэ гэдэгт итгэж байна.

Зорилт 4: Зорилт 1-3-ын холбогдох байгууллагууд харилцан туршлага солилцож, үр дүн нь үндэсний бодлого тогтолцоонд тусгагдана.

Шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 53 Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт

Шалгуур үзүүлэлт	Биелэлт
1) Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын үндсэн сургалтын чанар сайжирна.	“Биелсэн” • БМДИ -ийн 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багшийн онлайн сургалтын талбарт “Тэгш хамруулан сургах боловсролын хичээл”-ийг нэмж оруулсан. 2019.01 сараас онлайн сургалт зохион байгуулж, 03.29 өдрийг хүртэл 127 хүнийг хамруулсан. • “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Туршилтын тусгай сургуулийн хичээлийн туршлага видео (6 ангийн)”, “Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог”-ийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын цахим хуудсанд нийтэлсэн.
2) Багш бэлтгэдэг сургуулийн хөтөлбөр сайжирна.	“Биелсэн” • Төслийн хүрээнд хамтарч ажилласан туршилтын тусгай сургуулийн 7 багш МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимд сургалт явуулж байна. • Төслөөс зохион байгуулсан сургалтууд болон япон мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, ээлжит сургалтын хөтөлбөрийн загварыг сургалтандаа ашиглахаас гадна эдгээрийг хэрхэн боловсруулж ашиглах талаар ч зааж байна. • Төсөл БМДИ-тай хамтран боловсруулсан онлайн сургалтын хэрэглэглэхүүнийг ч оюутнуудад зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна. • 2013.10 сараас нээгдсэн одоо ажиллаж буй багш нарт зориулсан тусгай хэрэгцээт боловсролын 1 жилийн ангид дээр дурдсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон ээлжит сургалтын хөтөлбөртэй холбоотой агуулгыг заадаг. • 3.5 жилийн анги суралцдаг оюутнууд тусгай сургуульд дадлага хийх болон хичээлийн үйл ажиллагаатай танилцахдаа төслөөс зохион байгуулсан судалгаат хичээл болон кейс хэлэлцүүлэгт ч дадлага хийж байгаа оюутнууд оролцохоос гадна төслийн туршилтын ердийн сургуульд байгуулагдсан хүүхэд хөгжүүлэх төвд багшаар ажилладаг.
3) Тусгай сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр сайжирна.	“Төсөл хэрэгжих хугацаанд сургалтын хөтөлбөрийг сайжруулах хэрэгцээ байхгүй” • Төсөл хэрэгжих хугацаанд БСШУСЯ, Боловсролын хүрээлэннь оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулж сургалтын хөтөлбөрийг (бага ангийн хөтөлбөрийг 2015 онд боловсруулсан) сайжруулж, шинэчлэх талаар төлөвлөөгүй байсан.
4) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд	“Биелсэн” Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн өдөр (05.13) болон ”Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр” (12.03)-ийг

зориулсан аян хэрэгжинэ.	тохиолдуулан аян зохион байгуулсан. • Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн өдөр: 2016 онд Комисстой хамтран хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн чухлыг тайлбарласан телевизийн шторк боловсруулж телевизийн 6 сувгаар нэвтрүүлсэн. Уг шторкийг 2017 онд гудамжны 2 том дэлгэцээр цацсан бөгөөд 2018 онд ХНХЯ-ны цахим хуудас болон төслийн Facebook хуудсанд байршуулсан. 2018 онд бэлтгэсэн байсан мэдээлэл, сурталчилгааны 2 видеог 2019 онд МҮОНРТ-ээр нэвтрүүлсэн. • “Олон улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр: 2015 онд Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн үндэсний төвийн (Хуучнаар) шторк бэлтгэхэд туслалцаа үзүүлж, телевизийн 5 сувгаар нэвтрүүлсэн. 2016 онд нийслэлийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулж, үзэсгэлэн гаргаснаас гадна, гар зургийн цомог болон хуанли хэвлэн тараасан. 2017, 2018 онд ч хүүхдүүдийн бүтээлийг хэвлэсэн хуанли тараасан. 2018 онд нийслэлийн 35-р сургууль болон Ховд аймгийн 7-р сургуульд сурдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай баримтат нэвтрүүлэг бэлтгэсэн. ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын Youtube сувагт байршуулж, БСШУСЯ телевизээр нэвтрүүлэн, ХНХЯ цахим хуудсандаа байршуулж, Хөвсгөл аймгийн орон нутгийн телевизээр нэвтрүүлсэн.

2-2 Төслийн зорилго болон шалгуур үзүүлэлтүүд

<u>Төслийн зорилго</u>: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох.

Төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, боловсролын тогтолцоо бүрдүүлэхээр зорьж, Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт олон төрлийн туршилтын үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн. Туршилтын үйл ажиллагааны явцад боловсруулсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар” болон “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг БСШУС-ын сайдын 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/155 тоот тушаалаар, “Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл” болон “Сургуулийн дэмжлэгийн баг”-ийг БСШУС-ын сайдын 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/292 тоот тушаалаар тус тус батлуулсан.

Эдгээр шат дараалсан туршилтын үйл ажиллагааны үр дүнг тусгаж, хөгжлийн дэмжлэгийн ерөнхий чиглэл болон агуулга, холбогдох байгууллагын чиг үүрэг зэргийг нэгтгэсэн нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага” бөгөөд, уг гарын авлагад Бүдүүвч, зураг 3-т үзүүлэх хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны загвар тэмдэглэгдсэн. Энэхүү гарын авлага нь 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан “Заавар, маягт батлах тухай” А/304, А/699, А/460 тоот тушаалаар батлагдсан. Цаашид энэ нь Монгол Улсад хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх тодорхой ерөнхий чиглэл болно гэдэг найдаж байна.



Бүдүүвч, зураг 3 Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, боловсролын тогтолцоо

Төслийн зорилго дахь шалгуур үзүүлэлт ба биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 54 Төслийн зорилго дахь шалгуур үзүүлэлтийн биелэлт

Шалгуур үзүүлэлт	Биелэлт
Төслийн хүрээнд боловсруулсан хэрэглэгдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны яам (Одоогийн БСШУСЯ), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (Одоогийн ХНХЯ)-аар батлуулсан байна.	“Биелсэн” • “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар” болон“Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/155 дугаар тушаалаар батлуулсан. • “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. • 2019 оны 05 дугаар сард БСШУС-ын сайдын А/292 тоот тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-д “Сургуулийн дэмжлэгийн зөвлөл” болон “Сургуулийн дэмжлэгийн баг”-ийг баталсан.

2-3 Төслийн хүрэх үр дүнгийн хураангуйг сайжруулах өөрчлөлтүүд

Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй дахь Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт (1)-ийг “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний гарын авлага сайжирна” гэж төлөвлөсөн ч тухайн үед заавар байгаагүй тул “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний гарын авлага боловсруулагдана” гэж өөрчлөхийг 2015 оны 11 дүгээр сар 02-ны өдөр зохион байгуулсан Хамтарсан зохицуулах зөвлөлийн анхдугаар хурлаар зөвшөөрч өөрчилсөн болно. Дахин өөрчлөөгүй.

2-4 Бусад

- Орчин, нийгмийн нөхцөл байдлыг харгалзсан хэрэгжилт

Харгалзах зүйл байхгүй.

- Хүйсийн тэгш байдлыг хангах, энх тайвныг сахин хамгаалах, ядуурлыг бууруулахад чиглэсэн хэрэгжилт

Харгалзах зүйл байхгүй.

Төслийн эцсийн үр шимийг хүртэгч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бөгөөд хүйсийн тэгш байдлыг хангах, энх тайвныг сахин хамгаалах, ядуурлыг бууруулахад сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Түүнчлэн төсөл 2018 оны 02 дугаар сар 14-ний өдөр Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимаас “Торгоны зам шагнал”-аар шагнуулсан. Торгоны зам шагнал гардуулах ёслол нь 2 жилд 1 удаа, Монгол орны эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа олон улсын байгууллагууд, хоёр талын техникийн туслалцааны болон бусад гадаадын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүд, дипломат төлөөлөгчийн газрууд, гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын иргэдийг онцлон шалгаруулдаг ёслол юм. Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Монгол Улсын нийгэмд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан тул “Ядуурлыг бууруулах, тогтвортой амьжиргааг бий болгох” салбарын шилдгээр тодорч, шагнуулсан билээ.

БҮЛЭГ 3. 5 ҮЗҮҮЛЭЛТЭЭР ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3-1 5 үзүүлэлтээр хийсэн үнэлгээний үр дүн

Нийцэмж, үр дүнтэй байдал, үр ашиг, үр нөлөө, тогтвортой байдлыг дараах байдлаар тооцсон бөгөөд “Өндөр”, “Дунд зэрэг”, “Доогуур” гэсэн 3 шатанд хуваан үнэлсэн.

3-1-1 Нийцэмж

Тус төсөл нь Монгол Улсын төр засгийн бодлого, хэрэгцээ шаардлагад нийцсэн бөгөөд нийцэмжийг “Өндөр” гэж тооцсон.

“Монгол Улсын үндэсний бодлого, төлөвлөгөөнд нийцэж буй байдал”

2017 оны 11-р сард Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн Зорилт 1 дэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүний алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд хүртэл эргэн сэргээнэ” болон Зорилт 2 дахь “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны боловсролд тэгш хамруулна” гэсэн зорилтууд нь төслийн зорилттой яв цав тохирч байна. Мөн 2018 оны 05 дугаар сарын 21-нд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны баталсан “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд ЭХЭМД-ийг ашиглах, 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэг хийх, салбар комиссын чадавхыг бэхжүүлэх, ICF-д суурилан кэйсд судалгаа хийх, ICF-ийн сургалт зохион байгуулах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар, аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаануудад төслийг хамтран ажиллах байгууллагаар тэмдэглэсэн тул бодлогод нийцэмжийг “Өндөр” гэж үзсэн.

“Хөгжлийн хэрэгцээнд нийцэж буй байдал”

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны судалгаанаас үзэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт 40% орчим, дунд боловсрол хүртэл дэвшин суралцсан хүүхдүүд 14% (“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”) байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын үйлчилгээ авах хүртээмжийн асуудал тулгамдаж байгааг илтгэж байна. 2013 онд ЖАЙКА-аас хийсэн “Монгол Улс дахь тусгай хэрэгцээт боловсролын холбогдолтой мэдээлэл цуглуулах тандалт судалгаа”-нд сургалтын агуулга нь хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд тохирдоггүй, багш нарын ур чадвар дутагддаг зэргээр чанарын тал дээр ч тулгамдсан асуудлууд тодорхой байсан. Тиймээс тус төслийн үр дүн, үйл ажиллагааны үр өгөөжийг хүртэгчдийн эрэлт хэрэгцээ өндөр байсан.

3-1-2 Үр дүнтэй байдал

Төслийн үр дүнтэй байдлыг гол нь төслийн зорилго биелсэн байдлаар үнэлдэг. 103-р хуудас дахь Хүснэгт 54-т үзүүлсэнчлэн, төслийн зорилгын шалгуур үзүүлэлт биелсэн

бөгөөд үр дүнтэй байдлыг “Өндөр” гэж үзэж байна.

Тус төслийн зорилго “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох” явдал бөгөөд Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт хэрэгжүүлсэн төслийн үйл ажиллагаануудаар дамжуулан хэрэгжүүлсэн загвар нь 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын А/304, А/699, А/460 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-т тусгагдаж, цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхээр болсон. (103-р хуудасны Бүдүүвч, зураг 3) Түүнчлэн төслийн хүрээнд боловсруулсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар” болон “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг 2018 оны 03 дугаар сарын 29-ний Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/155 тоот тушаалаар батлуулснаас гадна “Сургуульд хамрагдалтыг дэмжих хурал”, “Сургуулийн дэмжлэгийн баг” нь 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/292 тоот “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургах журам батлах тухай” тушаалаар батлагдсан. Эдгээр цуврал арга хэмжээний үр дүнд, төслийн хүрээнд бий болсон “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загвар” үр дүнгээ өгч, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд эрт үед нь хөгжлийн дэмжлэг, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн.

3-1-3 Үр ашиг

Үр ашгийг дараах шалтгаанаар “Өндөр” гэж үзсэн.

Японы талаас шаардлагатай гэж үзсэн төслийн оролтыг цаг хугацаа, хүн хүч, мэргэжлийн талаас нь авч үзсэн. Мөн Япон дахь сургалтад бүх хамтран ажилласан байгууллагыг оролцуулахад анхаарсны үр дүнд сургалтанд оролцогчдын чадавх дээшилсэн нь Монголд буцаж ирсний дараах үйл ажиллагаанаас харагдаж байсан нь төслийн ашгийг өндөрсгөсөн гэж болохоор байна.

Хамтран ажилласан байгууллагын тухайд, төслийн эхний хагаст Комиссын (хуучнаар Төв комисс) гишүүдийн тоо цөөрсөн болон комиссын дарга томилогдоогүй байсан зэргээс шалтгаалан үйл ажиллагаа нь тодорхой хугацаагаар зогсонги байдалд байсан боловч 2016 оны 09 дүгээр сард Комиссыг дахин эмхлэн байгуулагдсан. Комиссын гишүүд төслийн үйл ажиллагаанд оролцон, Монголд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх талаар судалж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” боловсруулахад төслийн мэргэжилтнүүдтэй хамтран оролцов. Ийнхүү Комиссын хүчин чармайлтаар уг зааврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын А/304, А/699, А/406 тоот

хамтарсан тушаалаар батлуулсан. Тиймээс үр ашигт сөрөг нөлөө үзүүлээгүй.

3-1-4 Үр нөлөө

Төслийн үр нөлөөг тооцохдоо, төсөл хэрэгжиж дуусах үед “Эрхэм зорилго” биелэгдэх төлөвийг хардаг. Эрхэм зорилго биелэгдэх төлөв болон одоогоор мэдэгдэж байгаа үр дүнгээс “Дунд зэрэг” гэж үзэж байна.

“Эрхэм зорилго биелэгдэх төлөв”

Төслийн эрхэм зорилго нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох” бөгөөд шалгуур үзүүлэлт нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалт нэмэгдсэн байна” юм. Төслийн эцсийн төлөв байдлын судалгаанаас үзэхэд, туршилтын сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамрагдалт нэмэгдсэн бол, туршилтын бус сургуулиудад нэмэгдээгүй. Гэхдээ төслийн зорилго биелсэн бөгөөд Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн цахим хуудсыг ашиглах болон цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зэргээр туршилтын аймаг, дүүрэг, туршилтын сургуулиас бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэх зорилгоор эхлүүлсэн бэлтгэл ажлыг төслийн хугацаанд хийж ирсэн бөгөөд цаашид туршилтын бус сургуулиудад төслийн хүрээнд бий болгосон загварыг түгээн дэлгэрүүлснээр эрхэм зорилго хангалттай биелэгдэх боломж харагдаж байна.

“Цар хүрээ, хамралтын үр дүн”

Бусад төсөл, хөтөлбөртэй хамтран ажилласан тухайд “Бага, дунд боловсролын байгууламжийг сайжруулах төсөл”-ийн зорилтот 3 сургуулийн багш нарт сургалт зохион байгуулж, “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал сургалтын (DET) сургагч багшийг ажиллуулсан.

Мөн туршилтын аймаг, дүүрэг, туршилтын сургууль нь бусад аймаг, дүүргийн хувьд лавлагаа төвийн үүрэг гүйцэтгэж байна. Баянгол дүүргийн Салбар комисс 2017-2018 онд 2 аймгаас 21 хүн, Хөвсгөл аймгийн Салбар комисс 2017-2018 онд 1 дүүрэг, 1 аймгаас 38 хүнийг сургалтад хамруулжээ. Туршилтын тусгай сургууль 2017-2018 онд 956 хүн, нийслэл дэх туршилтын ердийн сургуулиуд 223 хүн, Хөвсгөл аймгийн туршилтын ердийн сургуулиуд 35 хүнийг сургалтад хамруулсан.

3-1-5 Тогтвортой байдал

Бодлого, тогтолцооны тогтвортой байдал нь өндөр байгаа хэдий ч зохион байгуулалтыг цаашид бэхжүүлэх шаардлагатай байгаа тул тогтвортой байдлыг “Дунд зэрэг” гэж үзсэн.

“Бодлого, тогтолцоо”

Тус төсөл нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”, болон дээр

дурдсан 2 үндэсний хөтөлбөртэй ижил бодлого, чиглэлийг баримталсан бөгөөд төсөл дуусаны дараа ч Монгол Улсын Засгийн газар үргэлжлүүлэн идэвхтэй ажиллах юм.

2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын А/304, А/699, А/460 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” -ын дагуу хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Өндөр чанартай боловсролын үйлчилгээний тухайд, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар, аргачлалыг 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/155 тоот тушаалаар батлуулснаар тогтвортой байдлыг хангасан. Мөн төслийн хүрээнд нэвтрүүлсэн “Сургуульд хамрагдалтыг дэмжих хурал”, “Сургуулийн дэмжлэгийн баг” нь 2019 оны 05 дугаар сарын 14-ны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/292 тоот “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургах журам батлах тухай” тушаалаар батлагдаж, үндэсний хэмжээнд өргөжүүлэн хэрэгжүүлэх боломжтой болсон.

“Зохион байгуулалт, хүний нөөц”

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлуудыг зохион байгуулж байгаа бөгөөд төсөл хэрэгжиж дуусаны дараа ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг байгуулснаар хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар Засгийн газар үйл ажиллагаагаа улам эрчимжих боломжтой болж байна. Нөгөө талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь тэгш хамруулан сургах боловсролын асуудлыг 1 мэргэжилтэн хариуцдаг бөгөөд аймаг, дүүргүүдийн боловсролын байгууллагуудад энэ асуудлыг мэргэжилтнүүд хавсран гүйцэтгэж байгаа тул хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэргэжлийн хүн томилох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төслийн хэрэгжүүлсэн туршилтын бүх үйл ажиллагаа нь хамтран ажиллаж буй байгууллага, мэргэжилтнүүдийн (комисс, туршилтын тусгай сургууль зэрэг) үндсэн ажил үүргийн нэг хэсэг байж, төсөл дуусанаас хойш ч үйл ажиллагаа нь үргэлжлэх ёстой. Нөгөө талаар, Салбар комиссын гишүүд орон тооны бус, ердийн сургуулиудад тохируулгат орчин бүрдүүлэх зэрэг ажлыг хараахан үндсэн ажил үүргийнхээ нэг гэж ойлгоогүй байгаа тул зохион байгуулалтыг сайжруулахад анхаарах шаардлагатай .

“Төсөв, санхүү”

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам төслийн хугацаанд, сургагч багшийн

хөлс болон тусгай сургуулийн багш нарын ердийн сургуулийн багш нарт зөвлөн туслах үйл ажиллагааны зардал, хүүхэд хөгжлийн төвд ажилласан оюутан туслагчийн ажлын хөлс зэрэг зардлыг хариуцаж ирсэн. Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 145 дугаар тогтоолоор, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээл зааж буй ердийн сургууль, цэцэрлэгийн багш нарын цалингийн нэмэгдлийг 2019 оны 09 дүгээр сараас олгож эхлэхээр шийдвэрлэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Комиссын гишүүдийн томилолтын зардал, бүсчилсэн сургалтын зардлыг хариуцсан. Эдгээр нь Комиссын үндсэн ажил үүрэг гэдгийг харгалзан үзэхэд, цаашид энэ хэвээр үргэлжлүүлэх боломжтой байгаа юм.

“Технологи, ур чадвар”

Шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлыг, кэйс хэлэлцүүлгээр судлан шийдвэрлэх замаар туршилтын аймаг дүүргийн Салбар комиссын чадавхыг бэхжүүлэх, Портеж хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын чадавхыг туршлага солилцох семинараар дамжуулан бэхжүүлэх, эмч мэргэжилтнүүдийн чадавхыг ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах сургагч багш нарыг бэлтгэх, 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгт хянагч тандагч бэлтгэх сургалтаар дамжуулан бэхжүүлж ирлээ. Үүний үр дүнд, туршилтын аймаг, дүүрэгт кэйс хэлэлцүүлэг, Портежийн дэмжлэг, зөвлөгөө, ЭХЭМД-ийн ашиглалт, 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг тогтмол хэрэгжүүлж болсон.

Туршилтын сургуулиудад “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулах болон судалгаат хичээл зохион байгуулах, сургуулийн дэмжлэгийн баг байгуулах, тохируулгат орчин бүрдүүлэх зэргээр багш нарт технологи нэвтрүүлсний үр дүнд, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулах болон сургуулийн дэмжлэгийн баг ажилллуулах үйл ажиллагаа тогтмолжсон. Гэхдээ туршилтын аймаг, дүүргийн туршилтын сургуулиас бусад сургуулиудад технологи шилжүүлэх ажил хязгаарлагдмал бөгөөд одоогоор туршлага солилцох семинар болон туршилтын сургуулийн үйл ажиллагаатай танилцах хэмжээнд байна.

3-2 Төслийн хэрэгжилт, үр дүнд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд

Хамтран ажилласан байгууллагын холбогдох мэргэжилтнүүд өөрчлөгдсөнөөр төслийн үйл ажиллагааны хэвийн явцад зарим бэрхшээл учирч байсан.

3-3 Төслийн эрсдлийн менежментийн үр дүнтэй холбоотой үнэлгээ

Дээрх 3-2 дахь дурдсан асуудлыг шийдэх зорилгоор шинээр орж ирсэн хүмүүст дэлгэрэнгүй тайлбар, танилцуулга хийх болон хамтын ажиллагаа бий болгоход анхаарч ажилласан.

3-4 Сургамж ба тулгамдсан асуудал

3-4-1 Сургамж

3-4-1-1 Богино хугацааны үр дүнг тооцохын чухал

1990 онд Монгол Улс ардчилал зах зээлийн нийгэмд орсноос хойш УИХ-ын сонгууль бүрийн дараа Засгийн газар солигддог болсон. Ийнхүү бүх Засгийн газар дараагийн сонгууль хүртэлх 4 жилийн ажлаа үр дүнтэй тайлагнахыг чухалчилдаг тул холбогдох санал зөвлөмжийг анхааралдаа авч хэрэгжүүлэхийг хичээж байсан.

Тус төсөл нь 6 сар, эсвэл 1 хичээлийн жилийн хугацаагаар туршилтын үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж, гарсан үр дүнг нь тооцсон загвар болон хэрэглэгдэхүүнүүдийг төслийн хугацаа дуусаагүй байхад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд зөвлөмж өгч байсан. Тухайлбал, 2016 оны 02 дугаар сард батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д заасан олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд 2017 оны 12 дугаар сард баталсан (Монгол Улсын Засгийн газрын 321 дүгээр тогтоол) “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах ажилд 2017 оны 02 дугаар сараас эхлэн дараах саналуудыг өгч байсан .

Хүснэгт 55 Үндэсний хөтөлбөрийн төсөлд өгсөн санал

Цаг хугацаа	Үйл ажиллагаа	Үндэсний хөтөлбөрт өгсөн саналуудын агуулга
2017.02 сар	ХНХЯ-ны санал сонсох уулзалтад оролцсон	• Эрүүл мэнд болон боловсролын зорилготой холбогдуулан хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлгийг хөгжлийн дэмжлэг, сургуульд хамрагдалтад холбох тогтолцоо бүрдүүлэхийн чухал • Хүүхэд, сурагчдын үнэлгээг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд нийцүүлэх • Тохируулгат орчин бүрдүүлэхийн чухал
	Үндэсний хөтөлбөрийн төсөлд үнэлгээ хийж, ХНХЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэнд санал хүргүүлсэн	• “Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлдэг болох” зорилт • ЭХЭМД-ийг зохистой ашиглах, бага насны хүүхдийн товлолт үзлэгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулдаг болох
2017.03 сар	ХНХЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн даргад үндэсний хөтөлбөр боловсруулж буй байдлыг тодруулсан	-
2017.03-04 сар	БСШУСЯ-нд санал өгсөн	• Тусгай хэрэгцээтэй хүүхэд, сурагчид хичээл заадаг багшийн ажлыг үнэлэх тогтолцоо бүрдүүлэх • Асран хамгаалагчид болон оршин суугчдын ойлголт хандлагыг дээшлүүлэх, боловсролын үйл ажиллагаанд

		хамтран ажиллуулах • Дунд боловсролд дэвшин суралцахыг нэмэгдүүлэх • Тохируулгат орчин бүрдүүлэх • Сургууль, цэцэрлэгээс тосох, хүргэх үйлчилгээг бий болгох
2017.05 сар	Хүргүүлсэн саналын агуулга нь тусгагдсан эсэхийг БСШУСЯ-наас тодруулсан	

Дээрх байдлаар төслийн үйл ажиллагааны үр дүнг тооцсон дараах агуулга, хэрэглэгдэхүүнүүдийг үндэсний хөтөлбөрт тусгасан.

- Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хүүхдийн хөгжлийн явцыг ажиглах зорилгоор ЭХЭМД ашиглалтыг сайжруулахтай холбоотойгоор өрхийн эмч нар болон асран хамгаалагчдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах.
- Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийж, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх гарын авлага боловсруулах.
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд нь мэргэжлийн эмч, сэтгэл зүйч, ахуй засалч, хөдөлгөөн засалчдаас бүрдсэн төрөлжсөн мэргэжлийн баг байгуулж, тухайн газарт амьдардаг хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоох оношилгоо болон хөгжлийн үнэлгээг хийж, үр дүнгээ салбар комисст илгээх.
- Хүүхдийн хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар, боловсруулах аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх.

2018 оны 05 дугаар сарын 21-нд баталсан “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд ЭХЭМД ашиглах, ICF-ийн сургалт зохион байгуулах, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулахад төслийг хамтрагч байгууллагаар тэмдэглэсэн.

Эдгээрээс, богино хугацааны (6 сар, эсвэл 1 хичээлийн жил) туршилтын үйл ажиллагаагаар дамжуулан, үр дүнг нь тооцож чадвал, төрийн бодлогод тусгах боломж илүү бүрдэнэ.

3-4-1-2 Нийслэл хот, орон нутгийн ялгаатай байдалд нийцүүлсэн арга барил

Тус төсөл “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох” эрхэм зорилгыг биелүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг боловсруулсан. Тиймээс төслийн хүрээнд Монгол Улсын нийт хүн амын бараг тал нь оршин суудаг нийслэлээс 1 дүүрэг (Баянгол), орон нутгаас 1 аймгийг (Хөвсгөл) туршилтын талбараар сонгож, Нийслэлд 12 сургууль, Хөвсгөл аймагт 2 сургуулийг туршилтын сургуулиар сонгосон.

Нийслэлд сонгосон туршилтын дүүрэг хүн ам ихтэй учир төслийн үр өгөөжийг

хүртэгчийн тоо олон, төсөл үр ашигтай байх боломжтой. Мөн орон нутагтай харьцуулахад холбогдох байгууллага, мэргэжилтний тоо олон байсан нь төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлснийг үгүйсгэх аргагүй. Эдгээр байдлуудаас үүдэн, тус төсөл төрийн захиргааны төв байгууллагатай ч, дүүргийн харьяаны байгууллагуудтай ч уулзаж зөвшилцөж, аль болох олон оролцогч талтай сайн харилцаа үүсгэхэд анхаарч ирэв. Мөн сургалтууд зохион байгуулахдаа, нийслэлд лавлагаа төвийн үүрэг гүйцэтгэдэг сургуулиудын зохион байгуулдаг сургалтыг сонгосон аймаг дүүргийн ердийн сургуульд зориулан зохион байгуулсан.

Орон нутгаас сонгогдсон аймаг нь төслийн үр өгөөжийг хүртэгч цөөнтэй, сумд нь алслагдсан байрлалтайгаас төслийг үр ашигтай хэрэгжүүлэхэд асуудал гарч байсан. Тус төсөл нь ойролцоо байрлалтай хэд хэдэн сумдыг бүсчлэн сургалт зохион байгуулсан. Мөн аймгийн төвд Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан нэгдсэн сургалтаар дамжуулан төслийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлж ажиллав.

Цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхийн тулд цахимаар лекц унших, хичээлтэй танилцах зэрэг аргуудыг нэвтрүүлж, нийслэл болон орон нутгийн ялгаатай байдлыг арилгах боломжтой юм.

3-4-1-3 Тэгш хамруулан сургах боловсролд сургууль нийтээр хамтран ажилладаг тогтолцоо бий болгох

Боловсролд тэгш хамруулан сургах талаарх жишээ туршлагаас үзэхэд, сургууль нийтээр хамтран ажиллах тогтолцоо бий болгох нь амжилтын гол түлхүүр юм. Тус төсөл нь туршилтын ердийн сургуульд чиглэсэн үйл ажиллагаагаа анх эхлүүлэх үедээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ангийн багш нараас бүрдсэн ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэгт тусгай сургуулийн багш нар зөвлөгөө өгч туслан, төслийн баг сургууль бүрийн хэрэгцээнд нийцүүлэн багшлах арга зүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний талаар сургалт зохион байгуулсан нь сургуулийн үйл ажиллагаанд төдийлөн хэвшил болж чадаагүй. Энэ нь тусгай сургуулийн сурагчид ямар нэг хэлбэрээр хөгжлийн бэрхшээлтэй байдаг, тийм хүүхдүүдийн боловсрол нь тухайн сургуулийн бүх багшийн асуудал байдаг бол, харин ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй сурагчид нь зөвхөн хичээл заадаг багш нараар хязгаарлагддаг бөгөөд бусад багш нарын хувьд “Миний асуудал биш”, зөвхөн хичээл заадаг багшид л хамаатай гэж боддогтой холбоотой.

Сургууль нийтээр хамтран ажиллах тогтолцоо бий болгох арга хэмжээнд доорх хүснэгтэд үзүүлсэн (1) Сургуулийн удирдлагын ойлголтыг өөрчилж, хариуцлагыг тодорхой болгох, (2) Сургууль нийтээр хамтран ажиллах зохион байгуулалт, тогтолцоог бий болгох, (3) Холбогдох хүмүүсийн амжилтын туршлагыг хуримтлуулах зэргийг дурдаж болно.

Хүснэгт 56 Сургууль нийтээр хамтран ажиллах тогтолцоо бий болгох арга хэмжээ

Арга хэмжээ	Тайлбар
Сургуулийн удирдлагын ойлголт, хандлагыг өөрчилж, хариуцлагыг тодорхой болгох	Юуны өмнө, сургуулийн удирдлагад тэгш хамруулан сургах боловсролын үндсэн зарчим болон үр дүнг ойлгуулах зорилгоор сургалтыг зохион байгуулах. Мөн жил бүр, аймаг, дүүргийн засаг дарга нь сургуулийн захиралтай ажил үүргийн гэрээ байгуулах, сургуулийн төлөвлөгөөнд тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх тухай тусгах.
Сургууль нийтээр хамтран ажиллах зохион байгуулалт, тогтолцоог бий болгох	1-3-3-3 Ердийн сургуулийн багш нарын чадавхыг бэхжүүлэх b) Ердийн сургууль дээрх тохирох хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх чадавхыг сайжруулах (60-р хуудас)-д тэмдэглэсэн сургуулийн дэмжлэгийн багийг байгуулах. Сургуулийн дэмжлэгийн багийг 2019 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн БСШУС-ын сайдын А/292 тоот “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургах журам батлах тухай” тушаалаар үндэсний хэмжээний бүх сургуульд хэрэгжүүлэхээр болсон.
Холбогдох хүмүүсийн ололт амжилтын жишээ туршлагыг хуримтлуулах	Багш ажилтнууд өөрийн үйл ажиллагаагаар хүүхэд, сурагчид өөрчлөгдөж байгааг анзаарч мэдэрдэг байх нь сургууль нийтээр хамтран ажиллах тогтолцоогоо тогтвортой байлгах, боловсронгуй болгоход чухал байдаг. Эхлээд богино хугацаанд үр дүнгээ харах боломжтой кэйс сонгоод үйл ажиллагаагаа явуулж, тухайн кэйсээ судлах зэргээр холбогдох хүмүүсийн ололт амжилтын жишээ туршлагагыг хуримтлуулдаг болох.

3-4-1-4 Өмнө хэрэгжсэн туршлага хомс тул уян хатан байдлаар хандах нь чухал байв.

Төсөл эхлэхийн өмнө эцсийн үр өгөөжийг хүртэгчид нь 5-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж тооцож байв. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, боловсролын үйлчилгээнд хамруулахад эрт илрүүлэг, оролцоо чухал байсан тул ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах, 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх, үзлэгээр хөгжлийн хоцрогдол, бэрхшээл илэрсэн хүүхдүүдэд зориулсан Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, цэцэрлэгт хамруулах зэрэг хөгжлийн дэмжлэгийн арга хэмжээг зохион байгуулахаар шийдсэн. Үүнтэй уялдан, төслийн үр өгөөжийг хүртэгчдийн насны бүлэг өргөжиж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр хязгаарлалгүй, туршилтын аймаг, дүүргийн бүх хүүхэд төслийн зорилтот бүлэг болсон. Мөн хамтран ажилласан байгууллага болох Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гадна Эрүүл мэндийн яамтай үйл ажиллагаагаа уялдуулан ажилласан. Үүний үр дүнд, хүүхдийг төрсөн цагаас суурь боловсролын шат хүртэл эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлэх цогц загварыг боловсруулах хэрэгцээ гарсан.

Ийнхүү, боловсролд тэгш хамруулан сургах талаар өмнө нь хэрэгжсэн туршлага хомс байдлыг харгалзан, төслийн явцад гарч ирсэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд үр ашигтай, уян хатан арга барилыг эрэлхийлж, хамтрагч байгууллагуудаас бусад байгууллагыг ч татан оролцуулах нь чухал болов. Төслийн үйл

ажиллагааны төсөв болон хугацаа хязгаарлагдмал байсан хэдий ч, 1) Тухайн улс, орон нутагт өмнө хэрэгжиж байгаа үйл ажиллагаанд тулгуурлах, 2) Тухайн салбартаа танигдсан хүний нөөцийг ашиглах нь үр дүнтэй байдаг. 1) -ийн тухайд, тус төсөл Монголд хэдийнэ ашиглаж эхэлсэн ЭХЭМД-ийг анхааран үзэж ЭХЭМД-ээр дамжуулан 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, цэцэрлэгт хамруулах дэмжлэг зэргээр үйл ажиллагаагаа өргөжүүлж ирсэн нь хүмүүст хялбар ойлгогдож, их хэмжээний төсөв шаардагдаагүй. 2)-ын тухайд, ЭХЭМД-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд өмнө нь Эрүүл мэндийн яаманд ажиллаж байсан мэргэжилтнийг ажиллуулан, хийж байсан ажилтай нь уялдаатайгаар үйл ажиллагааг өргөжүүлсэн. Энэ талын туршлагатай хүнийг олж ажиллуулснаар Эрүүл мэндийн салбартай ажлаа уялдуулах боломж бүрдсэн.

3-4-2 Тулгамдсан асуудал

Дээр дурдсанчлан тус төсөл олон чиглэлээр үр дүнд хүрсэн хэдий ч, шийдвэрлэгдээгүй асуудлууд үлдсэн. Үүнд: 3-4.2.1 Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, 3-4.2.2. Хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх, 3-4.2.3. Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах, 3-4.2.4. Сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулан сургах боловсролыг төлөвшүүлэх, 3-4.2.5. Суурь боловсролд тэгш хамруулан сургах боловсролыг төлөвшүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудлуудыг тэмдэглэв.

3-4-2-1 Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудал

Төслийн хүрээнд туршин хэрэгжүүлсэн 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” болон хөтөлбөрийн төлөвлөгөөнд туссан бөгөөд 9 дүүрэг, 21 аймгийн Эрүүл мэндийн газарт хэрэгжүүлэхийг даалгасан Эрүүл мэндийн сайдын тушаал гарсан боловч Эрүүл мэндийн яамнаас бүх аймаг, дүүрэгт хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхой заагаагүй байна. Ялангуяа өрхийн эмч нар 2-3 жилд шилжих, өөрчлөгдөх явдал элбэг байдаг тул үзлэгийг чанартай, тогтвортой хийхэд тогтмол сургалт зайлшгүй шаардлагатай.

Цаашид, төслийн хүрээнд боловсруулсан “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага”-ыг ашиглах, эрүүл мэнд, хөгжлийн үзлэг хийх талаар сургалтыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй.

3-4-2-2 Хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудал

а) “Танака Бине оюун ухааны сорил V”

2019 оны 05 дугаар сарыг дуустал, үндсэн судалгаанд хамрагдсан нийт 800 хүүхдийн сорилд өгсөн хариултын тэмдэглэлийг нэгтгэх, орчуулах ажлыг зохион байгуулсан. Одоо Нагояа их сургууль сорилын хариултын оноог дүгнэх, дүн шинжилгээ хийх, Танака

боловсролын хүрээлэнтэй зөвшилцөн сорилын даалгаврыг эцэслэх, сорилын зааврыг эцэслэн боловсруулах ажлууд хийгдэж байна. Цаашид “Сорилын оноо дүгнэх заавар” болон “Онолын заавар” боловсруулах, сорилын тоглоом, хэрэглэгдэхүүнийг эцэслэн боловсруулахаар төлөвлөсөн.

Оюун ухааны сорилыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхийн хамт зөв зохистой, тогтвортой ашигладаг болоход Японы Танака боловсролын хүрээлэнтэй ижил чиг үүрэг гүйцэтгэх байгууллага Монголд зайлшгүй шаардлагатай болно. Энэ байгууллага сорил авагч бэлтгэх сургалт тогтмол зохион байгуулах, сорилын тоглоом, хэрэглэгдэхүүн боловсруулах, хянах, оюун ухааны сорилын талаар зөв зохистой ойлголт бий болгоход чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах ёстой. Оюун ухааны сорилыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгах”-ын тулд биш, хүүхдүүдийн хөгжлийг дэмжих зорилгоор ашиглах үүднээс уг байгууллагын чиг үүрэг чухал юм. “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулахад өнөөдрийг хүртэл хүчин зүтгэл гаргаж ирсэн МУБИС нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамтай зөвшилцөн тэрхүү үүргийг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна.

b) “Портеж эрт боловсролын хөтөлбөр”

Монголд танилцуулсан Портеж хөтөлбөрийг цаашид үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, зохистой ашиглахын тулд төрийн зүгээс хөгжлийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудыг дэмжиж ажиллах тогтолцоо бий болгох шаардлагатай. Дэмжлэгийн агуулгад, дэмжлэг шаардлагатай байгаа асран хамгаалагчдад хөгжлийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар мэдээлэл өгөх, үйл ажиллагаа, үйлчилгээг нь төсвөөс дэмжих зэргийг дурдаж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг рашаан сувилалд амраах гэх мэт өнөөг хүртэлх халамж үйлчилгээ, хөнгөлөлтийн нэр төрлийг олшруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

Мөн “Хэрэглээний зан үйлийн дүн шинжилгээ”-ний зарчимд суурилсан Портеж эрт боловсролын хөтөлбөрийн чанарыг хангах, сайжруулахад сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоо чухал бөгөөд энд гол МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын тэнхим чиг үүргийг гүйцэтгэж байгааг дурдаж болно.

3-4-2-3 Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулахтай холбоотой тулгамдсан асуудал

Тус төслийн туршилтын аймаг, дүүрэгт зохион байгуулж туршсан кэйс хэлэлцүүлгийг бүх аймаг, дүүргийн Салбар комисст тогтмол зохион байгуулдаг болох нь чухал. Анх, дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй хүүхдийн жишээ сонгон, хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах кэйс хэлэлцүүлгийг Салбар комиссын ажил үүргийн тодорхойлолтод тусгаагүй байсан бөгөөд гишүүдэд урамшуулал

олгодоггүй байсан. Харин 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын А/304, А/699, А/460 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” болон гарын авлагад, Салбар комисс улиралд 1 удаа, кэйс хэлэлцүүлэг зохион байгуулах тухай тусгасан бөгөөд уг үйл ажиллагааг хэвшүүлэхийн үүднээс кэйс хэлэлцүүлэг зохион байгуулсан Салбар комиссын гишүүдэд нэмэлт урамшуулал олгодог болох шаардлагатай юм.

3-4-2-4 Сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулан сургах боловсролыг төлөвшүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудал

Сургуулийн өмнөх боловсролын түвшинд тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын хэрэгцээ шаардлагыг харгалзан үзсэний үндсэн дээр, 4 жилийн төслийн эцсийн шатанд буюу 2018 оны 03 дугаар сараас туршиж эхэлсэн. Ингэхдээ дунд болон урт хугацааны зорилтод суурилсан тогтмол сургалтын хэмжээнд зохион байгуулаагүй боловч сургалт болон цэцэрлэг багш нартай хийсэн санал солилцох уулзалт, цэцэрлэгтэй танилцах зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан цэцэрлэгүүдийн өнөөгийн бодит нөхцөл байдалтай танилцан судалсан. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах, тогтмол явуулахад тулгамдсан асуудал цөөнгүй байна. Цэцэрлэгт огт хамрагдаж байгаагүй, цэцэрлэгийн элсэлтээс хоцорсон, явцын дундаас гарсан, буцаж ороход хүндрэлтэй тохиолдлууд элбэг байсан бөгөөд бага насандаа сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй хожим сургуульд хамрагдалтаас хоцрох, улмаар хөгжилд нь сөргөөр нөлөөлөх зэрэг янз бүрийн асуудал үүсгэх эрсдлийг дагуулдаг.

Тэгш хамруулан сургах үзэл санаанд үндэслэн цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулах, багш нарыг чадавхжуулах, асран хамгаалагчдад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай зэрэгцээ цэцэрлэгүүдээр тойрон мэргэжлийн зөвлөгөө өгөх явуулын зөвлөх үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх нь үр дүнтэй. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас тусгай цэцэрлэг, сургуулийн багш нар болон хөдөлгөөн засалч, ахуй засалч, хэл засалч, сонсгол засалч зэрэг мэргэжилтнийг дэмжлэг шаардлагатай цэцэрлэгт тогтмол илгээн ажиллуулах тогтолцоог бий болгох хэрэгтэй.

3-4-2-5 Суурь боловсролд тэгш хамруулах боловсролыг төлөвшүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудал

Тус төсөл туршилтын ердийн сургуулиудад чиглэсэн төрөл бүрийн сургалтыг зохион байгуулж ирсэн. Төсөл дууссаны дараа багш нарыг тасралтгүй чадавхжуулж байхын тулд 2019 оны 05 дугаар сарын 14-ний Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/292 дугаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургах журам батлах тухай” тушаалд, тусгай сургуулийн багш нар лавлагаа

төвийн гол мэргэжилтнүүд болж, ердийн сургуульд мэргэжлийн зөвлөгөө өгөх тухай тусгасан. Гэвч одоог хүртэл тусгай сургуулийн гол мэргэжлийн багш нарын тэтгэвэрийн хугацаа ойртсон, залуу багш нарыг чадавхжуулах ажил нь нэн тулгамдсан асуудал болж байна. Тус төслийн ажлын хэсгийн гишүүнээр ажилласан багш нарыг түшиглэн ажлын байрны сургалтын тогтолцоо бий болгох шаардлагатай.

Мөн орон нутгийн ердийн сургуульд тусгай сургуулийн багш шууд зөвлөгөө өгөхөд хүндрэлтэй байна. Одоогоор, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам аймаг бүрт 3 сургуулийг лавлагаа төв сургуулиар сонгон, аймгийнхаа бусад сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах мэргэжлийн зөвлөгөө өгөх тогтолцоо бий болгохоор төлөвлөж байна.

БҮЛЭГ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ДУУССАНААС ХОЙШ ЭРХЭМ ЗОРИЛГЫГ БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛД

4-1 Эрхэм зорилго биелэгдэх төлөв

Эрхэм зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг хүртэнэ.

Эрхэм зорилгод туссан “Сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн байна” хэмээх шалгуур үзүүлэлтийн хүрээнд эцсийн төлөв байдлын судалгаагаар туршилтын сургуулиуд (Тусгай сургуулиуд, ердийн сургуулиуд) болон туршилтын бус сургуулиудад (Туршилтын аймаг, дүүрэг дэх төрийн өмчийн ердийн сургуулиудаас Баянгол дүүргийн 13 сургууль, Хөвсгөл аймгийн 30 сургууль асуулгын хуудас бөглөн, хариулт ирүүлсэн) суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог судлав. Мөн “Хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ авч чадаж байгаа” эсэхийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын ээлжит хуралдаанд орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ” болон “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ” гэсэн 2 үзүүлэлтээр судалж үзэв.

4-1-1 Туршилтын сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнөх (Суурь судалгааг явуулсан үе) болон дараах үеийн (Эцсийн төлөв байдлын судалгаа явуулсан үе) туршилтын сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоон үзүүлэлтийг График 1-д харьцуулан харуулав. Үүнээс харахад туршилтын тусгай сургуулиудад хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нийт 1136-аас 1283 (ойролцоогоор 1.13 дахин), Нийслэл дэх туршилтын ердийн сургуулиудад 76-аас 100 (ойролцоогоор 1.32 дахин), Хөвсгөл аймаг дахь туршилтын ердийн сургуулиудад 53-аас 62 (ойролцоогоор 1.17 дахин) болж нэмэгдсэн байна.





График 1 Туршилтын сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Төслөөс дэмжлэг оролцоо үзүүлсэн (Туршилтын сургууль) болон үзүүлээгүй сургуульд (Туршилтын бус сургуулиуд) хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоон харьцуулсан үзүүлэлтийг График 2-т харуулав. Төсөл хэрэгжсэн туршилтын сургуулиудад сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өссөн (1265-аас 1445) бол туршилтын бус сургуулиудын тухайд буурсан (583-аас 477) үзүүлэлттэй байна. Учир шалтгаан нь төдийлөн тодорхой биш боловч тусгай сургууль руу шилжсэн эсвэл сургуулиас гарсан байж болзошгүй гэж таамаглах 1 шалтгаан байж болох юм. Бодит байдал дээр 2017-2018 оны хичээлийн жилд туршилтын ердийн сургуулиас тусгай сургууль руу шилжсэн 2, сургуулиас гарсан 1 хүүхэд байсан ба, туршилтын бус сургуулиудад тусгай сургууль руу шилжсэн 7, сургуулиас гарсан 12 хүүхэд байна.



График 2 Туршилтын болон туршилтын бус сургуулиудад хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Судалгааны үр дүнгээс үзэхэд туршилтын сургуулиудад хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч бусад сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт дорвитой сайжраагүй болох нь харагдлаа.

4-1-2 Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрлэсэн кэйсийн тоо

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын ээлжит хуралдаанаар орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн эсэхийг тандан судлах зорилгоор Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн салбар комиссоор хэлэлцсэн хүүхдийн тоог үзэхэд төсөл хэрэгжиж эхэлснээс хойш ээлжит хуралдаанаар хэлэлцэж, зөвлөгөө дэмжлэг авсан хүүхдийн тоо нэмэгдсэн байна.

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн салбар комиссоор хэлэлцэж, шийдвэр гаргуулсан хүүхдийн тоо төслөөс дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө (2015 он) болон хойших үед (2018 он) хэрхэн өөрчлөгдсөнийг График 3-т үзүүлэв. Үүнээс харахад төсөл хэрэгжиж эхэлснээс хойш эрс өссөн үзүүлэлттэй байна.



График 3 Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн салбар комиссоор хэлэлцсэн хүүхдийн тоо

Ээлжит хуралдаанаар хэлэлцсэн хүүхдийн тоо өссөн нь салбар комиссын үйл ажиллагаа 2015 онтой харьцуулахад тогтмолжсонтой холбоотой хэмээн таамаглаж болох ба Зорилт 1-ийн хүрээнд төслөөс зохион байгуулж ирсэн салбар комиссыг чадавхжуулах үйл ажиллагаанууд ч нөлөөлсөн гэж үзэж байна.

4-1-3 Туршилтын сургуулиуд болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өссөн эсэхийг тандах зорилгоор туршилтын болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоог тодруулсан.

Төсөл эхлэхээс өмнөх (Суурь судалгаа) болон төсөл хэрэгжиж эхлэснээс хойших (Эцсийн төлөв байдлын судалгаа) туршилтын сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоог График 4-т харьцуулан үзүүлэв. Туршилтын тусгай болон ердийн сургуулиудын аль аль нь илт өссөн үзүүлэлттэй байна. Туршилтын тусгай сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсан хүүхдийн тоо 76-аас 321 (Ойролцоогоор 4.2 дахин), туршилтын ердийн сургуулиудын тухайд нийслэлд 1-ээс 27, Хөвсгөл аймагт 1-ээс 31 болж нэмэгдсэн байна.





График 4 Туршилтын сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо

Туршилтын болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоон үзүүлэлтийг харьцуулан График 5-д харуулав. Үүнээс үзэхэд туршилтын бус сургуулиудаас ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа нь Баянгол дүүрэгт 13-0, Хөвсгөл аймагт 30-10 сургууль байгаа ба тус 10 сургуулийн 4 нь төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтад хамрагдсан сургууль юм.



График 5 Туршилтын сургууль болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо

Төслийн хүрээнд туршилтын тусгай сургуультай хамтран ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, аргачлалыг боловсруулсан ба Боловсролын хүрээлэнгээр дамжуулан БСШУСЯ-нд танилцуулсны үр дүнд 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Боловсролын сайдын А/155 тоот тушаалаар “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал” батлагдаж, ерөнхий боловсролын бүх сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулан ашиглах боломж бүрдсэн. Туршилтын тусгай сургуульд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах шийдвэр гарсан нь уг төлөвлөгөөгөөр хичээллэх хүүхдийн тоо өсөхөд нөлөөлсөн гэж үзэж байна.

Туршилтын ердийн сургуулийн хувьд туршилтын тусгай сургуулиас үзүүлдэг зөвлөн туслах үйл ажиллагаа болон төслийн хүрээнд зохион байгуулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, судалгаат хичээл зохион байгуулах зэрэг ажлууд нөлөөлөх томоохон шалтгаан болсон гэж хэлж болно. Харин туршилтын бус сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хараахан нэвтрээгүй байгаа нь тогтоогдсон бөгөөд энэ нь дээр дурдсан БСШУС-ын сайдын А/155 тушаалын тухай бүх багш нарт мэдээлэл хүрээгүй, Боловсролын хүрээлэн болон холбогдох мэргэжилтнүүд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалтай холбоотой дэмжлэг, оролцоо шаардлагатай байгаа зэргээс шалтгаалж байна.

4-2 Монголын талд тавих санал

Дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан, “Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг авдаг болох” гэсэн Эрхэм зорилгыг биелүүлэхийн тулд Бүдүүвч, зураг 4-д үзүүлсэн энэхүү төслөөр үр өгөөж нь тодорхой болсон үйл ажиллагаанууд (Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулах, Сургуульд хамрагдалтыг дэмжих хурал зохион байгуулах, Сургуулиуд дэмжлэгийн багийг гол цөмөө болгон тэгш хамруулан сургадаг болгох) болон шаардлагатай гэж үзсэн шинэ үйл ажиллагааг (Цэцэрлэгүүд тэгш хамруулдаг болох) үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх шаардлагатай.



Бүдүүвч, зураг 4 Хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай хөтөлбөр

Дээр дурдсан үйл ажиллагааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд ХНХЯ нь 1) Тусгай хэрэгцээтэй хүүхдэд үзүүлэх дунд болон урт хугацааны дэмжлэг, 2) Цэцэрлэгүүд тэгш хамруулан сургадаг болох, 3) Сургуулиуд дэмжлэгийн багтаа тулгуурлан тэгш хамруулан сургадаг болох гэсэн 3 үндсэн зорилт, чиглэлийн ажлуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж дэмжлэг үзүүлвэл илүү үр дүнтэй гэж үзэж байна. Эдгээр чиглэлийн үйл ажиллагаа болон 2 яаманд тавих саналуудыг дараах хэсэгт нэгтгэж тэмдэглэв.

4-2-1 Тусгай хэрэгцээтэй хүүхдэд үзүүлэх дунд болон урт хугацааны дэмжлэг

Төслийн үйл ажиллагаануудаас үр өгөөжтэй нь батлагдсан 1) Кэйс хэлэлцүүлэг, 2) Сургуульд хамрагдалтыг дэмжих хурлыг бүх Салбар комиссууд зохион байгуулах шаардлагатай. Комиссын зохион байгуулдаг бүсчилсэн сургалтаар, туршилтын аймаг, дүүрэг дэх үйл ажиллагааг танилцуулж, Салбар комиссуудад авч хэрэгжүүлэхийг үүрэг

болгон, дараа жилийнх нь бүсчилсэн сургалтын үед хэрэгжүүлсэн байдлыг нь эргэж нягталдаг болох.

ХНХЯ-нд тавих санал

- Салбар комиссоос доод тал нь 1 хүнийг орон тооны болгох.
- 9 дүүрэг, 21 аймгийн Салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтыг жил бүр зохион байгуулах.
- Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулсан тохиолдолд Салбар комиссын гишүүдэд урамшуулал олгодог болох.
- Аймаг, дүүрэг дэх Салбар комиссууд “Сургуульд хамрагдалтыг дэмжих хурал”-ыг тогтмол зохион байгуулж, хэвшүүлэх.
- Хөгжлийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр дэмжих. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүл, асран хамгаалагчдыг хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын талаарх мэдээллээр хангаж, холбон зуучлах ажлыг өргөжүүлэх, байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээнд төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлэх г.м.

4-2-2 Цэцэрлэгүүд тэгш хамруулан сургадаг болох

Туршилтын цэцэрлэг сонгон, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан тэгш хамруулан сургадаг цэцэрлэгийн загварыг бий болгох шаардлагатай байна. Цэцэрлэгт тэгш хамруулдаг болохтой холбоотой заавар, гарын авлага болон сургалтын модул боловсруулж, БМДИ-ээр дамжуулан үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх.

БСШУСЯ-нд тавих санал

- БСШУСЯ-нд Тэгш хамруулан сургах боловсролын хэлтэс байгуулж, мэргэжилтний тоог нэмэгдүүлэх (3 хүнтэй).
- БМДИ-д хариуцах мэргэжилтний тоог нэмэгдүүлэх.
- Тусгай цэцэрлэг, тусгай сургуулийн багш, хөдөлгөөн засалч, ахуй засалч, хэл сонсгол засалч зэрэг мэргэжлийн хүмүүсийг тодорхой хугацаагаар дэмжлэг шаардлагатай цэцэрлэгүүдэд томилон ажиллуулдаг зөвлөн туслах явуулын үйл ажиллагаа, тогтолцоог бий болгох.

4-2-3 Сургуулиуд дэмжлэгийн багтаа тулгуурлан тэгш хамруулан сургадаг болох

БСШУСЯ-ны судалж буй Нөөцийн төвийг бүх аймаг, дүүргийн голлох сургуулийг түшиглэн байгуулж, тухайн орон нутгийн сургуулиудад шаардлагатай мэдлэг, арга туршлагыг судалж мэдэх боломжтой болгох.

Бүх сургуульд дэмжлэгийн баг байгуулж, нөөц төвөөр дамжуулан бүх сургуулиудад ч “Дэмжлэг шаардлагатай хүүхдийг олж тогтоох”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах”, “Сургалтын орчин, хэрэглэгдэхүүнээр хангах”, “Дэмжлэг шаардлагатай хүүхдэд тохирсон хичээл, ангийг зохион байгуулах”, “Сургуульдаа кэйс хэлэлцүүлэг

зохион байгуулах” зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх чиглэл өгөх.

БСШУСЯ-нд өгөх зөвлөмж

- 9 дүүрэг, 21 аймагт нөөц сургууль (Лавлагаа төв) сонгох.